



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

[16 дахь жилдээ]

2017/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(16 дахь жилдээ)

2017/02

ДАА 346
ННА-67.400.7
Х-828

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2017/02 (50)
Улсын бүртгэлийн дугаар 244
16 дахь жилдээ

- П.Оюунчимэг *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор)*
- Ц.Адъяахишиг *Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга)*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй,
зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

ISBN: 978-99978-2-002-0

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

<i>Ж.Бямбадорж</i> Хууль сахиулагч ба хүний эрх	5
<i>П.Оюунчимэг</i> Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гол үйл ажиллагаа	14
<i>Б.Өнөрмаа</i> Хүүхдийн амьд явах эрх яагаад зөрчигдөж байна вэ?	21
<i>Б.Лхагвасүрэн</i> Шүүхийн шинжилгээ нь процессын эрхийг хангах баталгаа мөн	26
<i>Б.Батхишиг</i> Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө	37
<i>З.Өнөрсайхан</i> Иргэний давхар харьяаллын өнөөгийн нөхцөл байдал ба олон улсын туршлага	43
<i>Б.Мөнхшүр</i> Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гэрч-хохилогчийн эрхийг хамгаалах зарим асуудал	51

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

<i>Майкл Игнатъев</i> Дүрвэгсэд гэх “гадны” хүмүүс. <i>Орчуулсан Т.Ариунаа</i>	60
--	----

ЗОЧНЫ ЯРИА

<i>Ж.Хунан</i> Шударга ёс, хүний эрхийн мэдрэмж нь хуульчийн үнэт зүйлсийн салшгүй хэсэг.	68
--	----

ХАВСРАЛТ

НҮБ-ын Хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаарх Тусгай илтгэгч, Ноён Жон Х. Нокс Монгол Улсад хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлтээ танилцуулсан уулзалтын тэмдэглэлээс	73
НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт зөвлөмж	82

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

ХУУЛЬ САХИУЛАГЧ БА
ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын дарга, Хууль зүйн ухааны
доктор, профессор

Ж.БЯМБАДОРЖ

“Хууль сахиулах үйл ажиллагаа ба Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл

“Хууль сахиулах үйл ажиллагаа ба Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулагч, илтгэгч, оролцогч зочид төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлаар “Хууль сахиулах үйл ажиллагаа ба Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдвийн хүрээнд хууль сахиулах ажиллагааны бодлого, стратеги, туршлага, сургамж, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж байгаа нь Хүний эрхийн үндэсний байгууллагын хувьд ихээхэн чухал ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэж байна.

Хүний эрхийн асуудлыг мэдэхгүй хүнгүй атлаа чухамдаа түүний мөн чанар, агуулга, утга учрыг төдийлөн сайн ойлгоогүй байдал түгээмэл ажиглагддаг юм. Хүний эрхийн тодорхойлолтыг эрдэмтэд, судлаачид олон янзаар томъёолсон байдаг ч нийтлэг ойлголтуудыг хамруулан дараах тодорхойлолт өгч болох юм. **Хүний эрх гэж ямар нэг хэм хэмжээгээр тогтоогдож, хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүний чөлөөт**

байдал юм. Энэ нь тухайн хувь хүний хэв шинж, ахуйн онцлог, нийгэмд эзлэх байр суурь, төр, бусад хүмүүстэй харилцах харилцаагаар илэрхийлэгддэг амьдрах арга, нөхцөл юм.

Хүний эрх бол тунхаг, уриа лоозон, төрөөс иргэддээ хүртээж байгаа хайр хишиг, бэлэг бишээ. Хэн нэгний хязгааргүй, дур зоргоороо аашлах гэсэн ойлголт бас биш юм.

Өнөөдрийн энэ завшааныг ашиглан хүний эрхийн онол, түүхийн асуудлыг өнгөцхөн илэрхийлэх зорилго тавьснаа эхлээд толилуулая.

Хүн энэ дэлхийд ямар ч ялгаагүй адилхан ирдэг учраас цаашдын амьдрал нь ч адил тэгш байх ёстой гэсэн үзэл бодлын үүднээс хүний эрхийн асуудал тавигдаж ирсэн нь хүн төрөлхтний түүхээс харагддаг.

Хэдийгээр хүн төрөхдөө адилхан улаан нялзрай амьтан байдаг боловч, анхнаасаа хүйс, арьсны өнгөөр ялгаатай заяадаг нь хүн бие биедээ ялгавартай хандах анхны шалтгаан болсон бизээ. Хүй нэгдлийн нийгмийн байгуулал задарч нэг хэсэг нь өмчтэй, эрх мэдэлтэй болж, нөгөө хэсэг нь айх, гачигдах

зовлонд өртөж, ингэснээр тэмцэл тулаан, зодоон цохион, дайн байлдаан, алаан хядаан, ялгаварлан гадуурхалт хүн төрөлхтөний түүхэнд өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. *Энэ бол хүний эрхийн төлөө хүн төрөлхтөний хийсэн тэмцлийн түүх мөн.*

Миний бие хүний эрхийн асуудлыг **“мөрөөдлийн”, сонгодог хэлбэрээр нь гаргаж тавьсан, дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн** гэсэн хүн төрөлхтөний түүхийн гурван үед хувааж үздэг юм.

Монгол ардын үлгэр ... эртээ урьдын цагт гэж эхлээд ...амар сайхандаа жаргажээ гэж төгсдөг шүү дээ. Үлгэр домгийн утга нь харгислал, дарангуйлал, хүчирхийлэл, алагчлал, хагацал, зовлон, ядуурал, гуйланчлалын тухай л голлон байдаг. Түүнийг нь нэгэн баатар эр гарч ирэн төгсгөл болгож ард түмнээ аз жаргалтай амьдруулах болсноор төгсдөг. Энэ нь бүхэлдээ л хүн төрөлхтөн хүн эрх, эрх чөлөөтэй гэдгээ мэддэг, шударга ёс хэзээ нэгэн цагт тогтоно гэж хүсэн мөрөөдөж байсны илэрхийлэл гэж би үздэг. Дэлхийн ард түмний үлгэр, домог ч адилхан л юм билээ. Эртний агуу сэтгэгчдийн бүтээл, Английн 1215 оны Магна Харти мэтийн баримт бичгүүдийн үзэл санаа, Спартакийн бослого зэрэг үйл явдлууд хүний эрхийн л тэмцэл байсныг гэрчилнэ. Харамсалтай нь хүсэл мөрөөдлөөс хэтэрсэнгүй.

Хүний эрхийн асуудлыг сонгодог хэлбэрээр нь гаргаж тавьсан дэлхийн анхны баймт бичиг бол Францын 1789 оны “Хүний болон иргэний эрхийн тунхаглал” юм. Энэ тунхаглалд **“хүмүүс эрхийнхээ хувьд адилхан эрх чөлөөтэй төрж, тэр хэвээрээ үргэлжлэх ёстой. Төрийн аль ч холбоо хүний зайлшгүй, салшгүй эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Эрх чөлөө, өмч, аюулгүй байдал, дарлалыг эсэргүүцэхийн утга нь энэ мөн”** гэжээ. Ийм

баримт бичиг гарах болсон урьдач нөхцөл нь 1779 оны АНУ-ын Тусгаар тогтнолын тунхаглал, 1787 оны АНУ-ын Үндсэн хууль тус тус батлагдсан явдал юм. Дээрх тунхаглалд “Бид дараах үнэнийг зайлшгүй гэж үзнэ: бүх хүн тэгш эрхтэйгээр заяагдсан, тэд өөрийг нь бүтээсэн бурханаас бэлэглэсэн амьдрал, эрх чөлөө, аз жаргалын төлөөх тэмүүлэл гэсэн хэд хэдэн салшгүй эрхтэй. Энэ эрхүүдийг хангахын тулд удирдуулж байгаа түмэн олны саналын үндсэн дээр байгуулагдсан, шударга засаг хүмүүсийн дотроос байгуулагдан ажиллах ёстой” гэсэн байна.

Эдгээр баримт бичгүүдэд анх удаа ардчилсан ёс, эрх зүйт төрийн тухай үзэл санаа суусан байна. Өөрөөр хэлбэл ардчилсан, сонгууль төрийн тогтолцоо, эрх зүйт төрийн нөхцөлд л хүний эрх баталгаатай болно гэдгийг хүн төрөлхтөнд мэдүүлсэн байна. Энэ үеэс олон улс орон Үндсэн хуульт байгуулалд шилжиж, бүгд найрамдах засгийн хэлбэрийг сонгож авсан билээ.

Дэлхийн хоёрдугаар дайн дуусаж, 1945 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдаж, олон улсын хүний эрх зүйн баримт бичгүүд батлагдан хэрэгжиж эхэлснээр хүний эрхийн асуудал дэлхий нийтийн асуудал болох эхлэл тавигдсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан **Хүний эрхийн түгээмэл тунхаглал**-д **“...айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн”** гэж тодорхойлсон нь хүний эрхийн гол үзэл санаа болсоор ирлээ.

Хүний эрхийн асуудал дэлхий нийтийн болсон нь дараах шинжээр тодорхойлогдож байна.

1. Ардчилсан үнэлэмжийн гол шалгуур нь хүний эрх болсон байна. Тухайн улс төрийн ямар дэглэмтэй байгаагаас үл хамааран хүний эрхийг хэрхэн хүндэтгэн дээдэлж, хамгаалж байгаагаар нь ардчилсан улс эсэхийг хүлээн зөвшөөрдөг нь бидэнд нэгэнт тодорхой байна.

2. Хүн төрөлхтний нийгмийн сэтгэлгээнд хүний эрх, эрх чөлөө хүн бүрт заяагдмал, зайлшгүй гэдэг ойлголтыг суулгаж байна. Хүний эрхийг дээдэлдэг аль ч улсад хүүхэд багачууд, сурагч, оюутан, төрийн албан хаагч, иргэддээ хүний эрхийн боловсрол олгох асуудлыг онцгой анхаардаг болсон байна.

3. Дэлхийн бараг бүх улс хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуульдаа тусгаж, хүний эрхийг хангах, хамгаалах механизмтай болсон байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн Монгол Улс хүний эрхийн асуудлыг Үндсэн хуульдаа тусгаж, хууль тогтоомжоо хүний эрхэд нийцүүлэн гаргаж, хүний эрхийн талаарх олон улсын 50 гэрээг соёрхон баталж, Парисын зарчимд нийцсэн хараат бус, бие даасан Хүний эрхийн Үндэсний Байгууллага байгуулан иргэдийнхээ өмнө, дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүж байгааг хэлэхэд сайхан л байна.

4. Хүний эрхийн асуудал тухайн улсын дотоодын асуудал байхаа больж дэлхийн улс орнуудын түгээмэл нийтлэг асуудал болжээ. Хүний эрхийг ноцтой зөрчсөн тохиолдолд дэлхий нийтээрээ эсэргүйцэж, дуу хоолойгоо нийлүүлдэг, төр, засаг, удирдагчид нь хүний эрх зөрчсөн бодлого, үйл ажиллагаа явуулбал улс төр, эдийн засгийн хориг тавих замаар шахалт үзүүлдэг практик нэгэнт тогтжээ.

5. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм бүрэлдэн тогтсон байна. Энэхүү механизм нь НҮБ-ын тогтолцоо, Хүний

эрхийн үндэсний байгууллагуудын дэлхийн холбоо, түүний бүрэлдэхүүнд багтдаг бүс нутгийн Европын, Ази, номхон далайн, Африкийн, Америкийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын нэгдэл хамаарч байна.

НҮБ-ын тогтолцоо нь Хүний эрхийн Зөвлөл зэрэг НҮБ-ын тунхаг бичигт суурилсан байгууллагууд, олон улсын хүний эрхийн гэрээнд суурилсан байгууллагууд болон гэрээнд нэгдэж орсон гишүүн улсууд үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах бүрэн эрхтэй бие даасан шинжээч мэргэжилтнүүд буюу “Тусгай Журам”-аас бүрдэнэ. НҮБ-ын хяналт тавих гол системд хүний эрхэд хяналт тавих хоёр төрлийн механизм байдаг.

1. Уламжлалт механизм гэдэг нь олон улсын хүний эрхийн үндсэн гэрээний дагуу албан ёсоор байгуулагдсан тодорхой хороодыг хэлнэ. Үүнд:

- Хүний эрхийн хороо
- Эдийн засаг, нийгэм, соёлын хороо
- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг устгах хороо
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо
- Эрүүдэн шүүхийн эсрэг хороо
- Хүүхдийн эрхийн хороо
- Цагаач ажилчдын хороо
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хороо
- Хүчээр сураггүй алга бологсдын асуудлаарх хороо
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хороо орно.

Гэрээнд суурилсан бүтцээс гадна тухай бүрийн мэдээ баримт цуглуулах бие даасан нэмэлт механизмыг “Тусгай Журам” гэж нэрлэнэ. Хүний эрхийн Зөвлөлийн энэ механизм нь тодорхой нэг улсын хүний эрхийн нөхцөл байдал аль эсвэл дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүний эрхийн сэдэвчилсэн

асуудлыг авч хэлэлцдэг механизм юм. Тусгай журмын тухай бүр авах арга хэмжээ нь гэрээнд суурилсан байгууллагуудыг бодвол хүний эрхийн ноцтэй зөрчилд илүү уян хатан ханддаг шинж чанартай. “Тусгай Журам”-д ажилладаг шинжээчид нь өөрийн чадавхын хүрээнд хүний эрхийн асуудлаар ажиллаж чадах онцгой бүрэн эрхтэй, итгэл хүлээсэн хүн байдаг. Тусгай илтгэгч, төлөөлөгч, бие даасан шинжээч, аль эсвэл бүлэг болсон шинжээчдийг ажлын хэсэг гэж нэрлэнэ. Тэд бол Хүний эрхийн Зөвлөлөөс томилогдсон, сайн дураар ажиллах, бие даасан нэртэй шинжээч нар юм.

НҮБ-ын Дүрэмд үндэслэсэн, аливаа улс орны хүний эрхийн нөхцөл байдалд тогтмол хяналт тавих өөр нэг механизм бол Хүний эрхийн төлөв байдлын Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг билээ. Хүний эрхийн Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг бол НҮБ-ын гишүүн улсуудын хүний эрхийн нөхцөл байдлыг Хүний эрхийн Зөвлөл тодорхой хуваарийн

дагуу 5 жилийн давтамжтай авч хэлэлцэж дүгнэлт өгдөг онцлог үйл явц бөгөөд аливаа гэрээ конвенцод нэгдэн орсон эсэх болон тодорхой сэдвээр хязгаарлахгүйгээр хүний эрхийн нөхцөл байдлыг тогтоож, зөвлөмж өгдөгөөрөө гэрээний хороодын харьяалах асуудлын хүрээнд ороогүй аливаа хүний асуудлыг хамруулан авч үздэгээрээ давуу талтай юм. Энэхүү үйл явцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 дугаартай тогтоолоор бий болгосон бөгөөд эхний цикл эхэлснээс хойш 2011 оны 10 дугаар сар гэхэд НҮБ-ын гишүүн бүх улсын хүний эрхийн нөхцөл байдлыг хэлэлцэж дууссан байв. Энэ үйл явцын 3 дахь цикл 2017-2021 онд үргэлжилж дуусах юм.

Хүний эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ) нь НҮБ-ын тогтолцоон дахь хүний эрхийн өөр өөр хяналтын механизмуудад хамгийн сайн экспертизийн туслалцаа үзүүлэх, дэмжих чиглэлээр ажилладаг.

Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо



*Дэлгэрэнгүй мэдээллийг www.ohchr.org хаягаас харна үү.

Илтгэлийн дараагийн хэсэгт хууль сахиулагчийг хүний эрхийг хүндэтгэдэг, хэнтэй ч адилхан хүн шүү гэсэн сэтгэлгээгээр харилцдаг болгоход ямар бодлого баримталж, үйл ажиллагаа явуулах шаардлагатай талаар санал бодлоо хуваалцахыг зорилоо.

Хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах улс төр, хууль зүйн нөхцөл бүрэлдэж байна. Харин эдийн засгийн чадавх, санхүү мөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан манай иргэдийн олон эрх баталгаажиж чадаагүйг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байна. Түүнчлэн хүний субъектив хүчин зүйл, төрийн холбогдох албан тушаалтны хууль бус, ёс бус үйл ажиллагаа, мөн төр зарим тохиолдолд үүргээ биелүүлээгүйгээс хүний эрх зөрчигдөх үзэгдэл гарсаар байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс сүүлийн 3 жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 1894 гомдол хүлээн авснаас 1225 буюу 64.6 хувь нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдол байна. Үүнээс цагдаа, прокурор, шүүгчийн зан харилцаа, ёс зүй, эрүү шүүлттэй холбоотой гомдол 348 буюу 28.4 хувийг эзэлж байна.

Мөн сүүлийн 3 жилийн хугацаанд эрүү шүүлт тулгасан тухай нийт 348 гомдлыг хүлээн авч, холбогдох ажиллагааг явуулснаас эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй, эрүү шүүлт тулгасан болох нь тогтоогдсон гомдлыг Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын мөрдөн байцаах газрын Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэст тус тус шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлжээ.

Гэвч харьяалалын дагуу шалгуулахаар шилжүүлсэн нийт гомдлын ихэнхийг нь эрүү шүүлт тулгасан, хүч хэрэглэсэн болон гэмтлийн зэрэг тогтоогдоогүй гэх

үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн хариу ирүүлж байна.

Хууль сахиулагчийн буруутай үйл ажиллагаанаас иргэнд учирсан хохирлыг төрөөс төсвийн хөрөнгөөр хариуцан төлж, улсад ямар их хохирол учирч байгааг ч бодолцох учиртай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж тус тус заасан байдаг.

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “... тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг Засгийн газар гаргана” мөн хуулийн 8.3-д “Тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг зарцуулна” гэж заажээ.

Засгийн газрын нөөц сангаас гаргуулах шүүхийн шийдвэр бүхий иргэдэд төлөх

төлбөрийг 2008 оноос хойш Хууль зүйн сайдын тухайн жилийн төсөвт тусгагдсан мөнгөн хөрөнгөөс шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулж, улмаар 2008-2014 оны байдлаар Засгийн газрын нөөц сангаас гаргуулах шүүхийн шийдвэртэй 137 иргэнд 1.5 тэрбум төгрөгийг олгосон байна.¹

чадвар, тушлага эзэмшүүлэх, сэтгэлгээг нь өөрчилж хүний эрхийн мэдрэмж суулгах нь манай нийгмийн тулгамдсан асуудал болоод байна. Иймийн тулд:

Нэгдүгээрт: эрх зүйн орчинд иж бүрэн дүн шинжилгээ хийж дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгохын

Төлбөр төлөгч	Хууль зүйн сайдын тушаалаар төлбөр шийдвэрлэгдсэн							Нийт дүн	Шийдвэрлээгүй байгаа үлдэгдэл
	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он		2015 он
Хүн	16	13	22	3	44	30	9	137	47
Дүн	183,187.2	118,545.6	196,140.0	11,633.8	417,790.7	484,379.8	107,667.5	1,519,344.6	893,030.4

Өнөөдрийн байдлаар Засгийн газрын нөөц сангаас 47 иргэний 893.0 сая төгрөгийн төлбөр олгоогүй байгаагаас тэдгээр иргэд дахин хохирч, эрх нь зөрчигдөж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан цагаасаа хойш иргэний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, гэм хорын хохирлыг арилгуулахаар шүүхэд 33 иргэнийг төлөөлж, нийт 34 нэхэмжлэл гаргаж, шүүхээр 412 сая 214 мянган төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэр гаргуулсан байна.

Хүний эрхийн олон улын стандарт, хэм хэмжээ, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зөвхөн хуулиар зөвшөөрсөн тохиодолд л хүний эрхийг хязгаарлах эрхтэй шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын эрх зүйн аливаа зөрчлийг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээхээс аргагүй байдалд оруулдаг архагшсан дутагдлаас салгахын тулд хүний эрхийн чанартай боловсрол олгох, мэдлэг,

зэрэгцээ “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтаа биелүүлж, олон улсын гэрээний заалтыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэдэг Монгол Улс болмоор байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын 50 гэрээ болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан бусад дүрэм, журам, зааврыг тэр бүр мөрдөхгүй байгаа явдал хууль сахиулах байгууллага тэдгээрийн албан хаагчдад нийтлэг байна. Би энд нэгэн баримтыг жишээ болгон толилуулая.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1988 онд баталсан Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогцын 20 дугаар зарчимд “Хэрэв саатуулагдсан буюу хоригдол этгээд өөрөө хүссэн хийгээд түүний ял нь боломжтой бол түүний байнга оршин суудаг газарт нь ойр дөт саатуулах буюу хорих газарт байлгана” гэж заасан байдаг.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2015 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 03/326 дугаартай албан бичгийн хавсралт

сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа цагдан хорих байр сэлгүүлж, гэр бүлийн гишүүдээс нь алслан хорьж байгаа нь хүнлэг бус харьцаанд суурилсан эрүү шүүлтийн нэг хэлбэр юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2012 онд 160 сэжигтэн, яллагдагч 2013 онд 157 сэжигтэн, яллагдагч, 2014 онд 119 сэжигтэн яллагдагчийг цагдан хорих байр сэлгүүлэн хорьсон байна.

Хоёрдугаарт: хүний эрхийн мэдлэг, чадвар, туршлага эзэмшүүлэхийн тулд хууль зүйн их, дээд сургуульд хүний эрхийн боловсрол заавал олгож, хууль сахиулагчдыг тогтмол, давтамжтайгаар хүний эрхийн сургалтад хамруулдаг журам тогтоон хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Комисс 2014 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээл тусгагдсан эсэх, уг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг харьцуулан судалсан юм. Судалгаанд хууль зүйн 11 сургууль хамрагдсаны 6 нь буюу Орхон их сургууль, Түшээ дээд сургууль, Үндэсний тагнуулын Академи, Хууль сахиулахын их сургууль, Шихихутаг дээд сургууль МҮИС-ийн Хууль зүйн удирдлагын сургуулиуд Хүний эрх хичээлийг заавал судлах хичээл болгон үзэж байгаа бол Их засаг олон улсын их сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билэг дээд сургууль болон Улаанбаатар их сургуульд уг хичээлийг сонгон судлахаар сургалтын төлөвлөгөөндөө тусгажээ.

Хууль зүйн их, дээд сургуульд хүний эрхийн хичээлд хуваарилсан багц цагийг авч үзвэл дараах байдалтай байна. Заавал судлах

багц цаг сургууль бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд 1-3 багц цаг байгаа бол сонгон судлах багц цагийн хувьд 2 багц цаг байхаар тусгасан байна.

Их, дээд сургуулиудаас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл тухайн хичээлийг судалсан оюутнуудын тоо харилцан адилгүй байна. Тухайлбал, сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг гаргаж үзэхэд Их засаг их сургууль болон Хууль сахиулахын их сургууль уг хичээлийг судалсан оюутнуудын тоогоор бусдаасаа илүү байна. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар “Хүний эрх” хичээлийг сүүлийн 5 жилийн хугацаанд оюутнууд сонгон судлаагүй байв.

Судалгаанд хамрагдсан 11 сургуулийн “Хүний эрх” хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн онолын мэдлэг, үндсэн ойлголт, олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгийн талаарх дэд сэдвүүд орсон ч бодит амьдрал дээр тулгарч буй хүний эрхийн асуудлыг багтаах нь чухал юм. Дээрх сургуулиудын “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр нь бусад сургалтын хөтөлбөрүүдтэй залгамж холбоотой байх бөгөөд уг хичээлийн өмнө заавал “Үндсэн хуулийн эрх зүй” хичээлийг судалсан байхаар тусгажээ. Дээрх 11 сургуулиас 9-д нь “Хүний эрх” хичээлийг 2 дугаар дамжаанаас эхлэн зааж байна. Харин Монгол Улсын Их Сургууль 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн “Хүний эрх” хичээлийг бүх оюутнууд заавал судлахаар шийдвэрлэсэн байна.

Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийг хэлэлцээд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос гаргасан 2015 оны 29 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт Комиссын зөвлөмжийн дагуу Хүний эрхийн боловсролын хүрээнд дараах арга хэмжээ

авахыг Засгийн газарт чиглэл болгосон билээ. Үүнд:

а) Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр”, түүний төлөвлөгөөтэй уялдуулж төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б) бүх шатны боловсрол олгож байгаа сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг ерөнхий мэдлэгийн суурь хичээл болгон үзэх стандарт батлах;

в) хууль зүйн их, дээд сургуульд “Хүний эрх” хичээлийг заавал үзэх мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулах, эрх зүйн бакалавр, магистр, докторантурын сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулахад зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх, дээрх сургуулийг магадлан итгэмжлэх, тусгай зөвшөөрлийг олгохдоо хүний эрхийн сэдвийг нэг шалгуур үзүүлэлт болгох;

Энэхүү тогтоолын хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж үзэхэд:

а) Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх талаар зохион байгуулж буй үйл ажиллагаа, бодлого, арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

б) Энэхүү зөвлөмжид заасны дагуу бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг суурь хичээл болгон үзэх стандарт батлуулах талаар авч буй бодлого, арга хэмжээний талаарх мэдээлэл байхгүй байгааг хэлэх нь зүйтэй. Суурь

боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд “сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн төлөвших боломж олгох” зорилт дэвшүүлж, ерөнхий боловсролын сургуульд судалж буй сурах бичгүүдийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж эхэлсэн тул энэ шинэчлэлийн хүрээнд хүний эрхийн сургалтыг хэрхэн нэвтрүүлэх талаар цаашид судлах, бодлогын түвшинд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

в) Эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад “Хүний эрх” хичээлийг судалж буй байдал, эрх зүйн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөр, түүний агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулах, сургуулиудын магадлан итгэмжлэлд хүний эрхийн сургалтын үр дүнг нэг шалгуур болгон үнэлэх талаар 2014 онд Комиссоос хийсэн судалгаанаас өөр эх сурвалж, мэдээлэл байхгүй байна. Тиймээс эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудын хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ зэрэг үйл ажиллагаанд мониторинг хийх, багш нарыг хүний эрхийн чиглэлээр мэргэшүүлэх, “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, Хүний эрхийн чиглэлээр магистр, докторын бие даасан сургалтын хөтөлбөртэй болох ажлыг цаг алдалгүй хиймээр байна.

Гуравдугаарт: хууль сахиулагчдын сэтгэлгээнд хувьсгал хийж, хүний эрхийн мэдрэмж суулгах нь чухал байна. Дэлхийн хоёрдугаар дайны үеэр герман цэргүүд зүлгэн дээгүүр гишгэлгүй тойрч гүйж байгаад буудуулдаг байсан тухай орос багш нар маань дурсан ярьдаг байсныг

олонтой сонссон билээ. Хүний тархинд суусан сэтгэлгээ, мэдрэмж амь насаа алдах агшинд ч салдаггүйн жишээ энэ буюу. Тэгвэл хууль сахиулагч хэрэг зөрчил гарган шалгуулж, шийтгүүлж байгаа хүнтэй тэр харгис хэрцгий, үзэн ядмаар хэрэг хийсэн байлаа ч “сэтгэлтэй, айдаг, ичдэг, зовдог, өвддөг, аавтай, ээжтэй, ахтай, эгчтэй, дүүтэй, эхнэртэй, нөхөртэй, үр хүүхэдтэй, амьдралтай надтай л адилхан хүн” гэсэн байр сууринаас ханддаг сэтгэлгээтэй байлгах, удирдлагын зүгээс байнгын хяналт тавьж, ажил дүгнэх үзүүлэлт болгож байж үр дүнд хүрнэ. Хүний

эрхийн боловсрол, сургалтын агуулга ч үүнд чиглэгдэх ёстой. Хууль сахиулах байгууллага болгон ажилтнуудтайгаа ажилладаг сэтгэл зүйчтэй байх шаардлагатай. Миний бие энэ албан тушаалд томилогдож ирсэн цагаасаа цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад ийм орон тоо гаргуулах асуудлыг хөөцөлдсөний үр дүнд бага ч гэсэн ахиц гарч байна.

“Хууль сахиулагч та ч таны өмнө суугаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол ч хүн, би ч хүн бид бүгдээрээ энэ дэлхийд заяасан хүн билээ.”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн,
Хууль зүйн ухааны доктор, дэд профессор

П.ОЮУНЧИМЭГ

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс “хүний эрхийн үндэсний байгууллага” нэрийг авахын тулд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1993 онд баталсан НҮБ-ын Парисын зарчмуудад нийцсэн байхыг шаарддаг. Ялангуяа өөрийн улсын нутаг дэвсгэрт хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээдэг тул хүний эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх онцгой чиг үүргийг гүйцэтгэж, хүчтэй, үр нөлөөтэй хүний эрхийн үндэсний тогтолцоог бий болгох бүрэлдэхүүн хэсэг болдог.

Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн үндэсний байгууллагуудыг харьцуулан үзвэл, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний

байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны¹ магадлан итгэмжилсэн А үнэлгээтэй 69, В үнэлгээтэй 20, С үнэлгээтэй 10 нийт 99 байгууллага байна. Эдгээрээс Ази, Номхон далайн бүсийн 21, Европын 36, Африкийн 25, Америкийн 18 хүний эрхийн үндэсний байгууллага байх жишээтэй. Гэхдээ эдгээр нь хууль зүйн статус, бүрэн эрх, комиссын гишүүд, тэдний хувийн туршлага, томилох үйл явц, жендэрийн харьцаа, бүрэн эрхийн хугацаа, ажлын албаны ажилтнуудын тоо, албан хаагчдын ажлын туршлага, санхүүжилтийн эх үүсвэр, жилийн төсөв, салбар байгууллага, тусгайлсан институт зэргээр ялгаатай байдаг. Үүнийг тодотгох зорилгоор доорх хэсэгт хүснэгтээр харьцуулан харуулав.

¹ Олон улсын зохицуулах хорооны тухай бичих

Ази тивийн Хүний эрхийн үндэсний 8 байгууллагын харьцуулалт

	Афганистан Улс	Балба Улс	Индонези Улс
Бүтэн нэр	Афганистан Улсын Бие даасан Хүний эрхийн Үндэсний Комисс (Afghanistan Independent Human Rights Комисс)	Балба Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (National Human Rights Commission of Nepal)	Комнахам (Komnahan) Хүний эрхийн Бие даасан Үндэсний Комисс (Independent National Commission of Human Rights)
Байгуулагдсан он	2002	2000	1993
Хууль зүйн статус	Үндсэн хуулийн байгууллага	Үндсэн хуулийн байгууллага	Хуулиар тогтоосон байгууллага
Бүрэн эрх	PPP (Хөхиүлэн дэмжих, Хамгаалах, Урьдчилан сэргийлэх)	PPP	PPP
Сэдэвчилсэн үйл ажиллагаа	Тулгамдсан асуудал ² +терроризм, transitional justice	Тулгамдсан асуудал + IDP буюу дотооддоо дүрвэсэн хүмүүс, сураггүй алга болох	Тулгамдсан асуудал + олон нийтийг хамарсан хүний эрхийн зөрчил (үй олноор хомроглон алах зэрэг)
Комиссын гишүүдийн тоо / хүн амын тоо	9/30 сая.	5/30 сая.	11/220 сая.
Комиссын гишүүний ажлын туршлага	Засгийн газар: 4, Иргэний нийгэм: 5 (Томилгооны өмнө, Засгийн газрын салбарт ажиллаж байсан Комиссын гишүүд өмнө ажиллаж байсан ажлаа өгөх ёстой)	Дээд шүүхийн шүүгч асан, төрийн байгууллагын албан хаагч асан, иргэний нийгмийн ажлын туршлагатай этгээд	Бүгд иргэний нийгэмээс
Томилох үйл явц	- Нэр дэвшүүлэх: Комисс - Томилох: Ерөнхийлөгч	-Нэр дэвшүүлэх: Үндсэн хуулийн зөвлөл - Томилох: Ерөнхий сайд	-Нэр дэвшүүлэх: Комисс - Томилох: Парламент
Комиссын гишүүдийн жендерийн тэнцвэр	(Эрэгтэй : Эмэгтэй) 6:3	4:1	10:1
Бүрэн эрхийн хугацаа	5жил (дахин сунгах: нэг удаа)	6 жил	5 жил (дахин сунгах: нэг удаа)
Ажлын албаны албан хаагчдын тоо	Ойрол. 760	Ойрол. 150	Ойрол. 200-300
Албан хаагчдын ажлын туршлага	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн байхгүй	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн байхгүй	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн: 10% орчим
Санхүүжилтын эх үүсвэр	Засгийн газар + Олон улсын	Засгийн газар + Олон улсын	Засгийн газар +Олон улсын (Олон улсын санхүүжилт: зөвхөн хөхиүлэн дэмжих, боловсролд хэрэглэдэг)
Жилийн төсөв	11 сая		4 сая
Мужийн салбар	8 мужийн салбар /6 орон нутгийн салбар	5 мужийн салбар /3 хамтын ажиллагаат салбар	6 мужийн салбар /(нийт 31 тойргийн дунд)
Тусгайлсан институт	-	2 Салангид комисс (dalit буюу хамгийн доод каст/ эмэгтэйчүүд) Шударга үнэн, эвлэрлийн комисс/Сураггүй алга болох асуудлын комисс Бусад ноцтой асуудлаар комисс байгуулах шаардлагатай	2 Салангид комисс (эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл / хүүхдийн эсрэг хүчирхийлэл)

² Тулгамдсан асуудал: цагаачид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд, эрүү шүүлт, саатуулах байр, хорих анги, дүрвэгсэд гэх мэт

	Малайз Улс	Филиппин Улс	Тайланд Улс
Бүтэн нэр	Малайз Улсын Хүний эрхийн (Үндэсний Комисс (NHRCM буюу SUHAKAM)	Филиппин Улсын Хүний эрхийн асуудал хариуцсан Комисс (Commission on Human Rights of Philippines буюу CHRП)	Тайланд Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (National Human Rights Commission of Thailand)
Байгуулагдсан он	1999	1988	1997
Хууль зүйн статус	Хуулиар тогтоосон байгууллага	Үндсэн хуулийн байгууллага	Үндсэн хуулийн байгууллага
Бүрэн эрх	PPP	PPP + нэмэлт	PPP + нэмэлт
Сэдэвчилсэн үйл ажиллагаа	Тулгамдсан асуудал + Бизнес ба хүний эрх (эхлэлийн шатанд явж байгаа)	Тулгамдсан асуудал (дүрвэгсэдээс бусад) + IDP	Тулгамдсан асуудал + IDP
Комиссын гишүүдийн тоо / хүн амын тоо	16 (хагас цагийн) /27сая. (Засгийн газар: 80%)	5/87сая. (Засгийн газар:4, Иргэний нийгэм (дарга): 1)	7/66сая. Төрийн бүх салбараас (төрийн их сургууль гэх мэт)
Томилох үйл явц	Сонгуулийн тусгай хороо (зөвлөх) а Ерөнхий сайд (зөвлөх) а King	- Нэр дэвшүүлэх: Хяналтын хороо - Томилох: Ерөнхийлөгч	Зарлал аСонгуулийн хороо (7 хүний бүрэлдэхүүнтэй) а Товч нэрсийн жагсаалт а Парламентын дэд хороо (ярилцлага) а Сенат(7 нэр дэвшигч) а Хаан (Батлах)
Комиссын гишүүдийн жендерийн тэнцвэр	12:4	3:2	5:2 (Комиссын дарга: эмэгтэй)
Бүрэн эрхийн хугацаа	3жил (дахин сунгах: нэг удаа)	7жил(тогтмол)	6 жил
Ажлын албаны албан хаагчдын тоо	Ойрол.80	Ойрол.600	Ойрол.200
Албан хаагчдын ажлын туршлага	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн: 10% орчим	Засгийн газрын байгууллагаас шилжинэ. Нээлттэй өрсөлдүүлнэ (төрийн албан хаагч шинэ ажилд томилогдохын өмнө урьд хашиж байсан ажлаа өгсөн байхыг шаардана.)	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн: 100% төрийн албан хаагч
Санхүүжилтын эх үүсвэр	Засгийн газар	Конгрессс +Олон улсын (зөвхөн хөхиүлэн дэмжих, боловсролд хэрэглэдэг)	Парламентаар хэлэлцэж, Засгийн газар (Сангийн яам)
Жилийн төсөв	3 сая		АМ.ДОЛЛАР 8.2 сая.
Мужийн салбар	2 мужийн салбартай (зүүн Малайз)	15 мужийн салбартай	-
Тусгайлсан институт	-	Омбудсманы албан газар / 3 Салангид комисс (эмэгтэйчүүд, уугуул хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс)	Омбудсманы албан газар

	Зүүн Тимор Улс	Монгол Улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Бүтэн нэр	Зүүн Тимор Улсын Хүний эрх, шударга ёсны албан газар (Timor Leste Office of Human Rights and Justice)	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (National Human Rights Commission of Mongolia)	Солонгос Улсын Хүний эрхийн үндэсний комисс (National Human Rights Commission of Korea)
Байгуулагдсан он	2004	2001	2001
Хууль зүйн статус	Үндсэн хуулийн байгууллага	Хуулиар тогтоосон байгууллага	Хуулиар тогтоосон байгууллага
Бүрэн эрх	PPP	PPP + нэмэлт /төлөөлөн нэхэмжлэх бүрэн эрх/	PPP
Сэдэвчилсэн үйл ажиллагаа	Тулгамдсан асуудал ³	Тулгамдсан асуудал + IDP	Тулгамдсан асуудал + Бизнес ба хүний эрх
Комиссын гишүүдийн тоо / хүн амын тоо	1(омбудсман) 2 орлогч (улс төрч) /1сая.	3/3 сая. (Бүгд төрийн байгууллагаас)	11(4 байнгын)/ 48 сая. (Академич, иргэний нийгэм, шүүгч асан, прокурор гэх мэт)
Томилох үйл явц	- Нэр дэвшүүлэх: Улс төрийн нам - Томилох: Парламент	- Нэр дэвшүүлэх: Дээд шүүх, Парламентын Хууль зүйн байнгын хороо, Ерөнхийлөгч - Томилох: Парламент	- Нэр дэвшүүлэх: Үндэсний Ассемблей (4), Ерөнхийлөгч(4), Дээд шүүхийн шүүгч (3) -Томилох: Ерөнхийлөгч
Комиссын гишүүдийн жендерийн тэнцвэр	1:0	2:1	4:7
Бүрэн эрхийн хугацаа	5 жил (дахин сунгах: нэг удаа)	6 жил (дахин сунгах: нэг удаа)	3 жил
Ажлын албаны албан хаагчдын тоо	Ойрол.50	46 (12 эрэгтэй, 34 эмэгтэй)	Ойрол.170
Албан хаагчдын ажлын туршлага	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн байхгүй	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн: Ойрол. 5~10%	Засгийн газрын байгууллагаас шилжсэн хүн: 50% гаруй
Санхүүжилтын эх үүсвэр	Засгийн газар +Олон улсын	Засгийн газар	Засгийн газар
Жилийн төсөв	ам.доллар 500, 000	ам.доллар 325, 000	ам.доллар 20 сая
Мужийн салбар	4 мужийн салбартай	-	3 мужийн салбартай
Тусгайлсан институт	-	-	-

* Тайланд болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хохирогчийн нэрийн өмнөөс гэм буруутай этгээдийн эсрэг шүүхэд гомдол гаргах эрхтэй.

** Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх мэдээллийг 2015 оны байдлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын талаарх мэдээллийг 2017 оны байдлаар харуулав.

Үүнээс харахад тухайн хүний эрхийн үндэсний байгууллага нь газар зүйн байрлал, улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, дотоод болон гадаад

хүчин зүйлс зэргээс хамааран, боловсон хүчин, санхүүжилт, үйл ажиллагааны хамрах хүрээ, салбар өөр өөр боловч ижил төсөөтэй шинжүүдийг харах боломжтой. Мөн бусад бүсийн байгууллагуудын үйл ажиллагааг харьцуулахад ч нийтлэг зүйлсийг тодруулж болно.

³ Тулгамдсан асуудал: цагаачид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд, эрүү шүүлт, саатуулах байр, хорих анги, дүрвэгсэд гэх мэт

Үүнд:

- Үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилт
- Хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдал
- Ижил тэгшээр харилцах харьцааны асуудал
- Шударга ёс
- Иргэдийн оролцоо
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээ
- Тусгайлсан асуудал (тусгайлан чадавхижиж байгаа асуудлуудын талаар)

Үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилт:

Үндсэн хуулийн эсвэл тусгайлан хуулиар тогтоосон байгууллагаас үл хамааран тухайн улсын хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэн, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагааг хослуулж байна. Ялангуяа хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх явцад шүүхэд төлөөлөн нэхэмжлэх гаргах, тухайн холбогдох этгээдэд хариуцлага тооцох явцдаа үндэсний хууль тогтоомжийн удирдлага болгохын зэрэгцээ олон нийтийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Харин омбудсманы хувьд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй асуудлыг гол төлөв анхаарч ажилладаг бол хүний эрхийн үндэсний комиссуудын хувьд дан ганц төрийн албан хаагч бус, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, хувь хүний үйлдлийг хүртэл чухалчлах тохиолдол бий.

Хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдал:

Аливаа хүний эрхийн үндэсний байгууллагын нэг онцлог бол тухайн улсын

нутаг дэвсгэр дэх хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, судалгаа шинжилгээ, мониторинг хийх, өргөдөл гомдол хүлээн авах, аян өрнүүлэх арга хэмжээг дангаар болон бусадтай хамтран зохион байгуулах боломжтой.

Иймээс төрөл бүрийн нийгмийн давхаргын төлөөлөл болсон этгээдээс мэдээлэл хүлээн авах, шалгалт хийж нягтлах байдлаар үндэсний болон орон нутгийн хэмжээний хүний эрхийн хэрэгжилтийн асуудлыг үнэлж, шийдэл эрэлхийлэх, шийдвэрлүүлэх санал болгох боломжтой байдаг. Хүний эрхийн биелэлтэд мониторинг хийх, задлан шинжлэхийн зэрэгцээ олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн талаарх илтгэлээ илтгэхэд Засгийн газрын илтгэлийн зэрэгцээ сүүдэр илтгэлийг НҮБ болон түүний тусгай хороодод хүргүүлэх чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Мөн тухайн улсын жил бүрийн нөхцөл байдлыг үнэлсэн, эсвэл тодорхой нэг онцлог сэдвийг тусгайлан хөндсөн илтгэл боловсруулан, холбогдох байгууллагуудад танилцуулах, уламжлах байдлаар нөлөөллийн ажил хийх, цаашид төрийн зүгээс авах бодлогыг тодорхойлох, түүнд дэмжлэг үзүүлэх, олон улсын хандивлагч байгууллагуудын зүгээс тухайн улсад хөрөнгө оруулахдаа анхаарах “луужин”-г гардуулж өгдөг гэж болно.

Ижил тэгшээр харилцах харьцааны асуудал:

Ижил тэгш харилцах гэдэгт хувь хүн бүр өдөр тутмын амьдралдаа нас, хүйс, нийгмийн байдал, гарал угсаа, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, итгэл үнэмшил зэргээс үл хамааран тэгш байдлаар оролцох, залан явахыг хэлнэ. Үүний зэрэгцээ хүн бүр хууль, шүүхийн

өмнө эрх тэгш байх эрхтэй тул хүмүүс хэдий ялгаатай байсан ч, нэгэн ижил цэгээс эхлэх боломжгүй ч гэлээ адил тэгш хандах, ялгаатай байдлыг нь хүлээн зөвшөөрөх явдлыг түгээн дэлгэрүүлсэн орчинд хүрэхийг эрмэлзэж байна. Ялангуяа энэхүү үйл ажиллагааны гол чиглэл нь ялгаварлан гадуурхалттай тэмцэх юм. Зарим улсын хувьд хөгжлийн бэрхшээл, эмэгтэйчүүд, жендэр, арьс үндэс зэргээр ялгаварлах асуудлыг хариуцсан, тус сөрөг үзэгдлийг арилгахад чиглэсэн тусгайлсан нэгж, эсвэл институтыг байгуулан ажиллаж байна.

Шударга ёс:

Шударга ёс гэсэн үгийн цаана ихэнх хүмүүсийн өдөр тутмын амьдралаас хол хөндий сонсогдож магадгүй. Гэхдээ “эрх зүйт ёс” гэсэн нэр томъёог хэрэглэж байгаа бол дээрх нэр томъёо нь ардчиллын тулгуур шинжийг тодорхойлно гэдгийг ойлгох хэрэгтэй. Эн тэргүүнд төрийн зүгээс санамсаргүй, гэнэтийн байдлаар ямар этгээдийн эсрэг халдах халдлагаас хамгаалах баталгаануудын нийлбэр цогцыг шударга ёс гэж томъёолох боломжтой. Харин эдгээр баталгааг бид хүний эрхийн ойлголтод шингээсэн болохыг мэднэ.

Нөгөө талаас хүний эрхийг юуны өмнө үндсэн хууль, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан тул хүмүүсийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх явдал үүнтэй шууд холбогдох буюу хувь хүн бүр хуулиа мэддэг, өөрийн үйлдлийн учир холбогдлыг ухаж таньсан байх асуудлыг хөндөнө гэсэн үг.

Харин тухайн хууль нь цагдаажсан төр эсвэл дарангуйллын эсрэг тухайн улсын төр хэрхэн удирдан ажиллах ёстойг тодорхойлсон байвал зохино. Учир нь тухайн улсыг удирдан залах төртэй холбоотой хууль тогтоомжийн

мөн чанар, бодит амьдралд илрэлээ олж хэрэгжиж байгаа нь эрх зүйт ёс, хүний эрхтэй салшгүй нягт уялдана. Иймээс эрх зүйн мэдлэг, өргөдөл гомдол гаргах, асуудлыг шийдвэрлэх боломж, мөн эрх нь хязгаарлагдсан болон хохирогч хүмүүсийг эрхийг хүндэтгэх явдалд хүний эрхийн үндэсний байгууллагууд цаг ямагт анхаарч, ажиллаж байна. Үүнтэй уялдан шүүх, цагдаа, хорих анги зэрэг хууль хяналтын байгууллагатай өргөн хүрээнд хамтарч ажилладаг онцлогтой.

Боловсрол:

Нэгэнт хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг удаа дараа дурдсан учраас дараагийн үйл ажиллагаа бол яах аргагүй боловсрол мөн. Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн үйл явцын салшгүй нэг хэсэг бөгөөд нийгмийн бүхий л түвшинд хамаарах этгээдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх үндэс гэж болно. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын нэг гол үйл ажиллагаа болсон хүний эрхийн боловсролыг түгээх нь хүний эрхийг хүндэтгэдэг, үүрэг хариуцлагаа ухамсарласан нийгмийн оролцогчдоор дамжуулан, хүний эрхийн соёлыг бүтээх тасралтгүй үйл явц билээ. Нөгөө талаар боловсролоор дамжуулан мэдлэг олгох, ойлголт төрүүлэх, цаашид хандлагатай болгох нь хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх суурь хөрс юм.

Ялангуяа хувь хүнээс төрийн албан хаагч хүртэл, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд ч хүний эрх зөрчигдөхгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжийг олгодог давуу талтай.

Тусгайлсан асуудал:

Өмнө дурдсанчлан тухайн улс орны онцлогоос хамааран зарим хүний эрхийн үндэсний байгууллагууд тусгайлан анхаарал хандуулах асуудлыг тодорхойлсон байна.

Үүнд:

- Үндэстний цөөнх
- Адил тэгш хандах
- Дотооддоо шилжсэн хүмүүс
- Ялгаварлан гадуурхалт (эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээл,бэлгийн цөөнх хүүхэд гэх мэт)
- Хүчээр сураггүй алга болох
- Терроризм
- Жендэрийн тэгш байдал
- Хомроглон устгах гэх мэт.

Хэдийгээр хүний эрхийн үндэсний байгууллагууд Парисын зарчимд нийцсэн байдлаар үйл ажиллагаа явуулдаг ч онцлог шинж байгааг цохон дурдах нь зүйтэй.

Гэсэн хэдий боловч “хүний эрх” гэсэн энэ том салбарт өөр өөрийн гаргасан замаар хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгохоор зорин ажиллаж байна. Нөгөө талаар дийлэнх байгууллагын үйл ажиллагааны хүрээ нийтлэг шинжтэй болсон ч цаашид “хүний эрх ба бизнес”, “хүний эрх ба хүрээлэн буй орчин”, “хүний эрх ба хөгжил” зэрэг шинэ онцлог асуудал бүхий сэдэв, чиглэлээр өргөжин тэлэхийг үгүйсгэх аргагүй билээ.



ХҮҮХДИЙН АМЬД ЯВАХ ЭРХ ЯАГААД ЗӨРЧИГДӨЖ БАЙНА ВЭ?



УЕПГ-ын Сургалт судалгааны төвийн
судлаач, хууль зүйн ухааны доктор

Б.ӨНӨРМАА

Аливаа улс оронд тухайн улсын хүн амын өсөлт бууралт, нас баралтыг шинжлэх ухааны үндэслэлтэй суурь судалгаагаар тогтоож, бодит баримтад тулгуурлан бүх талын шалтгаан нөхцөлийг тогтоодог судалгааны байгууллагууд байдаг. Манай улсад хүн амын дундах амиа хорлох тохиолдлыг бодит эрүүгийн хэрэг дээр тулгуурлаж хийсэн судалгаа хийгдэж байгаагүй бөгөөд амиа хорлосон тохиолдлуудыг бүртгэдэг зарим байгууллагын мэдээ баримтад тулгуурласан, бусад улс оронд хийгдсэн амиа хорлосон тохиолдлын мэдээг нэгтгэн харьцуулах шинжтэй зарим нэг судалгаа байдаг.

Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын нөхцөл шалтгаан, нийгэм эдийн засаг, гэр бүлийн нөлөөлөл, сэтгэл зүйн талаас тогтоох, тархалтыг газар зүйн байрлаар тодорхойлох, мөрдөн байцаалтын шатанд дээрх тохиолдлыг бүрэн шалгаж тогтоодог эсэхийг судлах, “бусдыг амиа хорлоход хүргэх” гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дүгнэлт

хийх, шүүхээс дээрх төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй практикийг судлах зорилгоор УЕПГ-ын Сургалт, судалгааны төвөөс анхны суурь судалгааг хийлээ.

Сүүлийн таван жилийн байдлаар буюу 2012 онд 484, 2013 онд 397, 2014 онд 441, 2015 онд 388, 2016 онд 333 хүн амиа хорлосон тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна. Улсын хэмжээнд 2012-2016 оны хооронд амиа хорлох тохиолдлын тоо буурсан бөгөөд энэ хугацаанд 2055 хүн амиа хорлож, жилд дунджаар 411 амиа хорлосон тохиолдол бүртгэгджээ.

Хүйсийн харьцааны хувьд авч үзвэл нийт тохиолдлын 1729 нь эрэгтэй, 326 нь эмэгтэй хүн амиа хорлосон бөгөөд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс 5.2 дахин их байна. Амиа хорлосон тохиолдлыг насны бүлгээр авч үзвэл 10-89 хүртэлх насны хүмүүс амиа хорлосон ба дундаж нас нь 33 ± 12.9 байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл 605 тохиолдол буюу 29.4 хувь нь 10 наснаас 25 нас хүртэлх, 1450 буюу 70.6 хувь нь 29-өөс дээш насны амь хохирогчид байсан. Тэр тусмаа 29 хүртэлх насны

хүмүүсийн дундах амиа хорлолт жил бүр өсөх хандлагатай байна.

Статистикийн шугаман хандлага тооцох аргачлалаар тооцож үзэхэд амиа хорлолт 2017 онд 332, 2018 онд 312, 2019 онд 293, 2020 онд 275 болж буурахаар байна. Гэвч өсвөр насны хүүхэд болон 29 хүртэлх насны залуусын дундах амиа хорлолт жил бүр өссөөр байгаа нь бүх талдаа анхаарлаа хандуулах нөхцөл бий болж байгааг судалгааны дүн харуулсан.

Сүүлийн таван жилд 2012-2016 онд 10-25 насны 605 хүн амиа хорлосон бөгөөд нийт 2055 тохиолдлоос 29.44 хувийг эзэлж байна. Үүнээс 10-14 насны хүүхэд амиа хорлосон нийт 78 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хот хамгийн их 27 буюу 34.6 хувь, хөдөө орон нутгаас Хөвсгөл аймагт 10.2 хувь байна. 15-19 насны нийт 179 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 57 буюу 31.8 хувь, Хөвсгөл аймагт 17 буюу 9.5 хувь, 20-25 насны амиа хорлосон нийт 348 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 154 буюу 44.25 хувь, Хөвсгөл аймагт 7.7 хувь нь бүртгэгдсэн байна. 2016 онд Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол Улсын хүний хөгжлийн талаарх” суурь судалгааг 16-17 насны сурагчдын дунд явуулсан байдаг. Судалгаагаар сүүлийн 12 сарын хугацаанд амиа хорлох талаар нухацтай бодож байсан гэж хариулсан нь судалгаанд хамрагчдын 26.1 хувь, амиа хорлохыг завдаж байсан гэж 10.7 хувь нь хариулсан байдаг. Аравхан настай хүү, 12-хон настай охин насанд хүрсэн эрүүл хүний толгойд ч багтамгүй аймшигт шийдвэрийг гаргаж байгаа нь хагацал үзсэн гэр бүлийн эмгэнэл биш нийгмийн эмгэнэл юм. Дээрх асуултад хариулсан байдлыг судалгааны тоон үзүүлэлтэй харьцуулаад л харахад дан ганц томчууд биш хүүхдүүд сэтгэцийн

тулгамдсан асуудалдтай, гарах гарцаа мэдэхгүй байгаа нь ажиглагдаж байна.

Суурь судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлоход хүргэсэн шалтгаан, нөлөөлөл нь тэдний хүмүүжил болон зан байдлын онцлог, өссөн орчин болон амьдарч буй орчин, гэр бүлийн хүчирхийлэл, үерхэж буй охин, хөвгүүнтэй муудалцах, тохиолдлын бэлгийн харилцаанд орох, гэмт хэрэгт холбогдох, зан төлөвийн тогтворгүй байдал, эцэг эхийн анхаарал халамж дутмаг, хойд эцэг, эхтэйгээ ойлголцдоггүй, өөрт тулгамдаж буй асуудлынхаа талаар эцэг, эхдээ ярьдаггүй гэх мэт олон хүчин зүйлтэй холбоотой байсан. Зарим тохиолдлоос харахад багш, дотнын найз нөхдөдөө өөрт тулгамдсан асуудал буюу амиа хорлоход хүргэсэн шалтгаанаа ярьсан боловч тэдгээр нь анхаарч ойлгоогүй, ач холбогдол өгч, зөвлөж туслаагүйн улмаас сэтгэл зүйн тогтворгүй байдал, гутралд орж өсвөр насны хүүхэд амиа хорлоход хүрсэн гэж үзэж болохоор тохиолдлууд байна. Түүнчлэн өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлосон гэх хэрэгт өгсөн гэрчүүдийн мэдүүлгийг харахад амь хохирогчийн зан байдлын талаар эцэг, эх буюу гэр бүлийн гишүүдийн өгсөн мэдүүлэг, найз нөхөд эсхүл үерхдэг охин, хөвгүүнийх нь өгсөн мэдүүлэг нь хоорондоо зөрүүтэй байлаа. Тухайлбал, гэр бүлийнхний мэдүүлгээр дуугүй, томоотой, нээлттэй биш гэж мэдүүлсэн байхад багш, найз нөхөд нь зан төлөвийн талаар өөрөөр тодорхойлж илэн далангүй, хөгжилтэй гэх зэргээр мэдүүлсэн байна. Мөн дотно үерхэж нөхөрлөдөг найзуудын талаар эцэг, эх нь огт мэддэггүй тохиолдлууд нэлээд байна.

Амь хохирогчдын амиа хорлохоос өмнөх нөхцөл байдлыг авч үзвэл ихэнх тохиолдолд өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлоно гэж заналхийлэх, амиа хорлох арга

зам, хэрэгслийг эрж хайсан, сэтгэл зүйн хувьд мухардаж, амьдралын зорилгогүй болсноо илэрхийлэх, уурлаж хилэгнэх эсвэл өшөө авахыг эрэлхийлэх, бодлогогүй үйлдэл хийдэг байж. Мөн согтууруулах ундаа эсвэл мансууруулах бодисын хэрэглээгээ нэмэгдүүлэх, найз нөхөд, гэр бүл, нийгмээс өөрсдийгөө тусгаарлах, сэтгэл тавгүйтэх, цухалдах эсхүл зан ааш нь огцом өөрчлөгдөх, нойргүйдэх, байнга унтах, бусдад ачаа дарамт болж байна гэж үзэх зэрэг шинж тэмдгүүд ажиглагдаж байсан нь амь хохирогчид сэтгэцийн тулгамдсан асуудалтай байсан нь тогтоогдож байсан. Манай улсад сэтгэл зүйч бэлтгэдэг сургууль нь байдаг. Гэтэл эдгээр хүмүүсийг ажлын байраар хангадаггүй, сэтгэл зүйчийн мэргэжлийн ач тусыг ойлгож мэдэхгүй байгаа нь харамсалтай байна.

Өсвөр насны хүүхдүүд нь зан төлөв, сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшиж амжаагүй байдаг учраас тэдэнтэй ярилцаж, тэднийг ойлгох, сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэгдсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байх нь урьдчилан сэргийлэх хамгийн зөв арга юм.

Хүний шууд буруутай үйлдлээс гадна бусдыг үхэлд хүргэж болзошгүй олон хүчин зүйлээс сургуулийн орчинд урьдчилан сэргийлэх боломжтой юм. Судалгааны үр дүнгээс дүгнэхэд:

- Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид сурагчиддаа тавих анхаарал сул, сурагчдынхаа эцэг эхтэй харилцах харилцаа дутмаг,
- Хүүхдэд өөрийгөө хэрхэн бусдад ойлгуулах, сэтгэл гутралд орвол хэрхэн даван туулах талаар зөвлөдөггүй,
- Хүүхдийн зан байдал, сэтгэл зүйн онцлог, ар гэрийн амьдрал зэргийг мэддэггүй,

- Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажилладаггүй, тухайн сургуулийн сурагч амиа хорлосон тохиолдолд дүгнэлт өгдөггүй,
- Хичээлийн хөтөлбөрт сэтгэл зүйн сургалт ордоггүй зэрэг байдал нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 5 дугаар зүйлийн 5.15 дахь хэсэгт зааснаар бага болон суурь боловсролын агуулгад “зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох”, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэгт бүрэн дунд боловсролын агуулгад “...гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ гэж заажээ.

Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.15 дахь хэсэгт Ерөнхий боловсролын захирал “сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, хяналт тавих” үүрэгтэй бөгөөд 22 дугаар зүйлийн 22.1.6, 22.1.9 дэх хэсэгт багш “... хүүхдийн эрх ашгийг хамгаалахад эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх”; “хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хуульд заасан үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх” үүрэгтэй гэж тус тус заажээ.

Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь хэсэгт “..... зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох” гэсэн дээрх зорилтыг сургууль бүрэн хэрэгжүүлдэггүй, сургуулийн захирал, багш

хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байгаа нь сурагч, оюутан гэмт хэрэг зөрчилд холбогдсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, мансууруулах бодис хэрэглэсэн, сургуулийн орчинд гарсан цуу ярианаас ичсэн, гэр бүлийн амьдралын нөхцөл тааруу зэрэг нөхцөлөөс болж сэтгэл гутралд орж амиа хорлосон тохиолдлуудаас тогтоогдож байна.

Цаашид өсвөр насны хүүхэд, оюутан, 25 хүртэлх насны залуус амиа хорлохыг завдсан, хорлосон тохиолдол бүрт онцгой анхаарч шалтгаан нөхцөлийг судлаж байх, дахин ийм эмгэнэлт явдлыг гаргахгүй байхад бүх шатандаа анхаарлаа хандуулах шаардлагатай.

Бусдыг амиа хорлоход хүргэж буй гэмт хэрэг нь шууд бусаар бусдыг “үхлийг өөрөө сонгох”-д хүргэж буй хэрэг. Амь хохирогчийн үхэлд шууд болон шууд бус санаагаар хандсан гэм буруутай үйлдэл юм. Бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулвал шалгаж тогтооход хамгийн хүндрэлтэй хэргийн нэг бөгөөд ялангуяа амь хохирогч өсвөр насны, өвчний улмаас бусдын эрхшээлд байсан бол уг тохиолдлыг шалгаж тогтооход нь учир дутагдалтай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. 2002 оны Эрүүгийн хуулиар шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг судалж үзэхэд 2012-2016 онд 19 хэргийг шүүх шийдвэрлэжээ. Шүүхээс дээрх төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй байдалд дүгнэлт хийхэд бусдыг амиа хорлоход хүргэж буй этгээдээс байнгын бие махбодын хүчирхийлэл үйлдсэн, харгис хэрцгий хандсан, гэр бүлийн хүчирхийлэл, удаан хугацааны туршид гэр бүлд тогтсон “хэвшил” байх эсвэл нэр, төр алдар хүндийг нь байнга гутаан доромжилсон, хохирогч энэ идэвхитэй үйлдлийн улмаас амьд явах хүсэлгүй болсны улмаас өөрийнхөө амийг хорлох бүхий л аргыг хэрэглэсэн байхыг

шаардаж байна. Харин шинээр батлагдсан Эрүүгийн хуульд бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн объектив шинжийг илүү тодорхойлж амь хохирогчийн бусдаас хараат байж болох нөхцөлийг тодорхой тусгаснаар объектив шинжийг мөрдөн байцаалтын шатанд тогтоох боломжтой болох нь харагдаж байна. Хуульд заасан объектив үйлдлүүд бүгд “байнга” хийгдсэн байхыг шаардаж байгаа нь зарим тохиолдолд ялангуяа өвчний улмаас бусдын эрхшээлд байгаа эсвэл өсвөр насны хүүхэд нэг удаагийн ноцтой үйлдэл, доромжлолын улмаас амиа хорлоход хүргэсэн гэмт хэргийг шалгаж, тогтооход хүндрэл учруулж болзошгүй байдлыг бий болгохоор байна.

Сэтгэл зүйн хувьд төлөвшөөгүй, эцэг, эх, асран хамгаалагчаас эсхүл эдийн засаг, бие махбодын хувьд бусдаас бүрэн хараат байдалд байгаа нөхцөлд өөрийгөө илэрхийлэх чадваргүй, боломжгүй, өөрийгөө хамгаалах эрх зүйн бүрэн чадамжгүй хүний (**нэр төр, алдар хүнд гэдэг үгний утгыг бүрэн ойлгохгүй өсвөр насны хүүхэд**) хувьд тухайн цаг мөчид сэтгэл зүйд хүндээр тусгах үг, доромжлолыг мэдрүүлсний улмаас амиа хорлосон тохиолдолд бусдыг доромжилж нэр төрд нь халдсан байсан ч “байнга” гэсэн шинжийг агуулаагүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй байна.

Бусдыг амиа хорлоход “гарцаагүй” хүргэсэн байх шинжийг хэрхэн ойлгон, шалгаж тогтоох нь тодорхойгүй байгаа бөгөөд амь хохирогчийн хувьд тухайн нөхцөлд хийсэн үйлдэл нь тухайн амь хохирогчийн хувьд гарцаагүй байсан гэдгийг тогтооход бэрхшээлтэй гэж судлаачийн хувьд үзэж байна. Хуулийн дээрх тодорхойлолтоос үзвэл амиа хорлох гэж буй хүний “*гарцаагүй байдал*” нь тухайн хүний хувьд үүнээс өөр үйлдэл хийх боломжгүй нөхцөлд орсон

байхыг шаардаж байна. Удаан хугацааны туршид гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, доромжлогдсны улмаас амиа хорлосон нь “гарцаагүй байдал” эсхүл “сэтгэл зүйн хувьд уг үйлдлийг даван туулах чадваргүй болсон нөхцөл” байсан эсэхийг эрх зүйн онолын үүднээс тайлбарлах уу эсвэл сэтгэл зүйн талаас тайлбарлах уу гэдэг нь тодорхойгүй байна.

Өсвөр насны хүүхэд өөрт тулгарсан дарамт, доромжлол, сэтгэл зүйн гутрал, тогтвортой бус байдал зэргийг өөр аргаар даван туулах боломжтойг ойлгох, мэдэх чадваргүй субъект юм. Амь хохирогч тухайн нөхцөлд амиа хорлох гарцаагүй байдалд орсон гэж ойлгосон субъектив шинжийг амь хохирогчийн зүгээс үү эсхүл тухайн тохиолдлыг шалгаж байгаа субъектийн зүгээс тодорхойлох уу гэдэг нь маргаантай юм.

Өнөөдөр хүүхэд аюулгүй байх хамгийн найдвартай орчин бол сургууль, гэр. Хамгийн итгэлтэй, найдвартай аль ч үед туслаж дэмжих ёстой хүн нь багш, эцэг байх ёстой атал хүүхэд энэ орчинд хамгийн их ганцаардаж, тулгарсан асуудал, бэрхшээлээ хэнд ч ярьж чадахгүйгээр ийм аймшигтай

алхмыг сонгож байгаа нь эмгэнэлтэй хэрэг юм.

Хүүхэд төвтэй сургууль, эцэг эхийн харилцаа бодит бус, бие биедээ хэтэрхий найдаж хүүхдийг анхаарлын төвөөс алдчихсан, амьдралд хөл тавих гэж тэмүүлж байгаа хойч үедээ бэрхшээлийг даван туулах арга ухаан, асуудлын гарцыг зөв олж харах алсын харааг заахын оронд “дуугай, томоотой эсвэл эрдэмтэй мундаг” хүн болгох гэж оролддог хүмүүжлийн буруу арга барил эргээд хүүхдийг нээлттэй бус болгож байгааг өөрчлөх болжээ. Бөмбөг хөөж, чихэр харж хөөрдөг, эцэг эхдээ зэмлүүлэхээсээ айдаг насан дээрээ байгаа хүүхэд үхлээс айх биш үхлийг сонгож аймшигтай үйлдэл хийж байгаа нь хагацал үзсэн эцэг эхийн биш нийгмийн эмгэнэл юм.

Цаашид хүүхдийн төлөвшилд сэтгэлзүйн сургалт буюу амьдралын ухаан, бэрхшээлийг даван туулах арга замыг зааж өгөх нь маш том нөлөө үзүүлдэгийг бүх шатандаа ойлгож, сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийн амьд явах эрх шууд бусаар зөрчигдөж байгаад анхаарлаа хандуулах цаг болжээ.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ НЬ ПРОЦЕССЫН ЭРХИЙГ ХАНГАХ ШИНЖЛЭХ УХААНЫ БАТАЛГАА МӨН



Хууль сахиулахын их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Шинжлэн магадлахуйн
тэнхимийн дэд профессор, хууль зүйн
ухааны доктор, Цагдаагийн хошууч

Б.ЛХАГВАСҮРЭН

Түлхүүр үг: хүний эрх, шинжлэн магадлахуй, криминалистик, шинжээч, шалгуур, стандарт, шударга ёс.

Товч агуулга: Гэмт этгээдүүд технологийн дэвшлийг өөрийн зорилгодоо өргөн ашиглах замаар шинжлэх ухааны агууламж бүхий арга, ов мэхийг эзэмшиж, зохион байгуулалтын ахисан зэрэглэлд шилжсэн өнөө цагт хүний эрхийг эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгаанаас гадна “шинжлэх ухааны” баталгаагаар хангах зүй ёсны шаардлага тавигдаж байгаа бөгөөд процессын эрхийг шүүхийн шинжилгээгээр хангах онолын үзэл баримтлалын талаар энд дурдсан болно.

Оршил: Шинжлэн магадлахуйн онол, шүүхийн шинжилгээний практик судлалын хүрээнд шийдлээ хүлээсэн тулгамдаж буй олон асуудал хуримтлагдсан хэмээн судлаачид үздэг. Эдгээрийн дотор шүүхийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагааг хүний эрхийг дээдлэх зарчимтай уялдуулан хэрэгжүүлэх асуудал анхаарал татсаар байна.

Профессор Б.Чимид “Иргэний үндсэн эрхэд байцаан шийтгэх ажиллагааны буюу процессын эрх гэсэн ангилалт

байх нь зүйтэй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон”¹ хэмээн тэмдэглэсэн. Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэгт сэрдэгдсэн хэн нэгнийг хилсээр шийтгэхээс сэргийлэх, нөгөө талд гэм буруутай этгээдэд шударгаар ял оногдуулах явдал нь процессын эрхийн асуудал бөгөөд үүнд шүүхийн шинжилгээ “онцлог” нөлөөтэй. Монгол Улсад эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шинжилгээг бүрэн, үр дүнтэй ашиглах, шинжээчийн дүгнэлтийг зөв үнэлэх асуудал онол, практик, эрх зүйн зохицуулалтын хувьд олон улстай харьцуулахад хангалтгүй байгаа нь “процессын эрх”-ийг хангах шинжлэх ухааны баталгаа манай оронд гүйцэт төлөвшөөгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна. Энэхүү нийтлэл үндсэн хэсэг (*нэгдүгээрт, шүүхийн шинжилгээ ба хүний эрх, хоёрдугаарт, шинжээчид хандах хандлага, гуравдугаарт, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуур гэсэн 3 хэсэгтэй*), дүгнэлт, санал, эх сурвалж гэсэн бүтэцтэй.

¹ Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008. 107 дахь тал.

1. Шүүхийн шинжилгээ ба хүний эрх. Шүүхийн шинжилгээг хүний эрхтэй холбон тайлбарлахын тулд олон улсын хүний эрхийн суурь баримт бичиг болон гол гэрээ, конвенцийн зарим зүйл, заалтын агуулгыг судлах шаардлагатай.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 А(III) тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын² 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”, 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэж заасан нь процесс хэрэгжүүлэгч хэрэгт холбогдсон этгээдийг залхаан байцаах, доромжлон харьцах, хууран мэхлэх, цагдан хорих зэрэг эрүүдэн шүүх арга барилаас өөр замаар буюу хэргийн бодит байдлыг шинжлэх ухааны арга зүйгээр эргэлзээгүй тогтоох, улмаар шүүхийн мэтгэлцээнд шинжлэх ухааны тэгш боломжоор хангагдсан байх эрхийг тунхагласан үзэл баримтлал хэмээн ойлгож байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 онд баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ыг БНМАУ 1974 онд соёрхон баталсан ба түүний 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр... шударгаар шүүлгэх эрхтэй”, 3 дахь хэсгийн (b)-д “өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх

хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх...”, (e)-д “өөрийх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах буюу байцаалгуулах, эсрэг гэрчтэй адил нөхцлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах” гэж заасан байдаг. Жишээ нь: Америкийн конвенцийн³ 8.2.f дугаар зүйлд яллагдагчийн өөрийгөө хамгаалахад бэлтгэх бодит бололцоотой байх эрхийг хангах үүднээс шинжээчийг шүүх хуралдаанд гэрчээр оруулахыг зөвшөөрсөн байдаг. Өөрөөр хэлбэл, яллагдагч өөрийгөө хамгаалах нотлох баримт бүрдүүлэхдээ хувийн шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийн туслалцааг авдаг ба улсын болон хувийн шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчид шүүх хуралдааны үед шинжлэх ухааны мэтгэлцээн өрнүүлдэг байна.

Цаашид манай оронд өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх болон тэгш байдал, мэтгэлцээний зарчим зэрэгт үндэслэн төрийн бус шүүхийн шинжилгээний байгууллагын эрх зүйн үндэс, зохицуулалтыг бий болгох шаардлага байгааг хууль тогтоогчид анхааралдаа авах нь зүйтэй.

Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээ авна”⁴ гэж заасан ба эрүү шүүлтээс ангид байх ”үр нөлөөтэй арга хэмжээ” гэдэгт аливаа гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ мөр, биет баримт, шинжээчийн дүгнэлтийг нотлох

² МУХЭҮК. Олон улсын хүний эрхийн билл. Уб., 2015. 6-16 дахь тал.

³ Шударга шүүлгэх эрх. Эмнести интернэшнл. Уб., 2013. 52 дахь тал.

⁴ МУХЭҮК. Олон улсын хүний эрхийн билл. Уб., 2015. 329 дэх тал.

баримтаар бүрэн, зөв, үр дүнтэй ашиглах явдал юм.

Истанбулын протокол⁵ (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг баримтжуулах, мөрдөхөд баримтлах заавар) бол эрүүгийн процессын үед хүний эрхийг хангахад баримтлах олон улсын гол баримт бичиг юм. Энэ баримт бичигт эрүү шүүлттэй холбоотой мөр, биет баримтыг илрүүлэх, хамгаалах, криминалистикийн гэрэл зураг авах, биологийн нотлох баримт болон бие махбод, сэтгэцийн өөрчлөлтийг нотлох эд мөрийн баримтыг бэхжүүлэх, шинжлэх зэрэг шүүхийн шинжилгээ, криминалистикийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, зарчим, арга зүйг тодорхойлсон байдаг.

“Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ийн 15 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүчээр алга болгох гэмт хэргийн хохирогч... нас барсан тохиолдолд цогцсыг задлан шинжилж, таньж тогтоож, буцаах талаар бие биетэйгээ хамтран ажиллаж, эрх зүйн туслалцааг өөр хоорондоо дээд зэргээр хүргэнэ”⁶ гэжээ. Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газраас шүүх генетик бол хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд “нэн чухал алхам” болсон гэж тэмдэглэсэн. 2010 онд Балба Улсад дотоод мөргөлдөөний үеэр таван оюутан алга болсон ба тэдгээрийн эрэн сурвалжлах, эрэн хайх ажилд НҮБ-ын ХЭДКГ-аас ихээхэн анхаарал хандуулж, олон улсын шинжээчдийн баг илгээжээ. Алга бологсдын цогцсыг илрүүлсэн ба шүүх генетикийн шинжилгээгээр хэн болохыг тогтоож чадсан байна. Өмнө нь шүүх шүд судлал,

шүүх эмнэлэг, хурууны хээний бүртгэл зэргээр цогцос, эд эрхтний үлдэгдлийг тогтооход багагүй хүндрэл учирдаг байсан бол шүүх генетикийн шинжилгээ асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж НҮБ-ын шинжээчдийн илтгэлд дурьджээ. Мөн тус илтгэлд хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэхэд шүүхийн шинжилгээний найдварт байдал, баталгаа хангагдсан байх ёстойг тэмдэглэж, олон орны шүүхийн шинжилгээний практикт нэгдсэн стандартгүй байгаа талаар бичсэн. Цаашид улс орнуудын шүүхийн шинжилгээний технологийн зөрүүг арилгах, тоног төхөөрөмжийг сайжруулах, сургалт явуулах, гэмт хэрэг мөрдөх ажиллагааны шинжлэх ухаанч байдлыг сайжруулахад анхаарч ажиллах талаар НҮБ-аас зөвлөмж гаргах шаардлагатай гэсэн байна⁷.

Ийнхүү хохирогчийн талаар мэдээлэл цуглуулах, хохирогчийн эрхийг хамгаалах, түүнчлэн яллагдагчийн гэм буруугүйг тогтоох, эсвэл хилсээр шийтгэгдэхээс урьдчилан сэргийлэхэд шүүхийн шинжилгээний чухлыг НҮБ болон түүний салбар байгууллагууд сайшаан тэмдэглэж, улмаар зөвлөмж, шийдвэрүүд гаргасан байдаг. Тухайлбал, НҮБ-ын ХЭДКГ-аас 2000 онд 2000/32 дугаартай тогтоолоор баталсан “Хүний эрх ба шинжлэн магадлахуй” зөвлөмж ба уг зөвлөмжийг 2003 онд 2003/33 дугаартай тогтоол, 2005 онд 2005/26 дугаартай тогтоолоор⁸ тус тус шинэчилсэн байна.

“Хүний эрх ба шинжлэн магадлахуй” зөвлөмж удиртгал, 11 зүйлтэй. Удиртгал хэсэгт: Хүний эрхийн комисс болон гишүүн улсуудын Засгийн газарт шинжлэн магадлахуй бол эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус харьцах, хууль

⁵ https://s3.amazonaws.com/PHR_Reports/istanbul-protocol_opt.pdf

⁶ Мөн тэнд. 390 дэх тал.

⁷ www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/Forensic.aspx

⁸ OHCHR. XI, E/CN.4/2005/L.10/Add.11

бусаар шийтгэх, дур зоргоор цаазаар авах гэмт үйлдлийг илрүүлэх, нотлох баримт бий болгодог чухал арга, хэрэгсэл мөн болохыг **хүлээн зөвшөөрч**, шинжлэх ухаанч мөрдөх ажиллагаа нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, хүний эрхийг ноцтой зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх, амжилттай яллах нотолгооны үндэслэл бий болгох, хүний эрхийн зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг **хүлээн зөвшөөрөхийг** уриалж, улс орондоо хэрэгжүүлэх 11 зүйл зөвлөмжийг баталсан байна.

Шүүхийн шинжилгээг хүний эрхэд суурилсан хандлагаар тодорхойлж, ойлгох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаанч хандлага төлөвшсөнөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог хэлбэр болох “шүүхийн шинжилгээ” хүний эрхийн баталгаа болох зүй тогтолтой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хоёр талын эсрэг байр суурь, ашиг сонирхол зэрэг хөндөгддөг. Тиймээс хохирсон хэн нэгний зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талд гэм буруутай этгээдэд шударга ял оногдуулах, эсхүл хилсээр шийтгэхгүй байх “дэнс” нь шүүх ажиллагааны шинжлэх ухаанч хандлага юм. Процесс хэрэгжүүлэгчдээс хууль ёсны зарчмыг ягштал баримтлахын зэрэгцээ хэрэг, маргааны болж өнгөрсөн бодит байдлыг шинжлэх ухааны аргаар нотолж, тайлбарлавал шүүхийн шийдвэр “шударга ёсны шалгуур”-ыг бүрэн хангана.

Тухайн процесс хүний эрхийг зөрчсөн үү, эсхүл хууль ёсны хязгаарлалт уу гэдгийн мөн чанар нь процесс хэрэгжүүлэгчийн шинжлэх ухаанч хандлагаас хамаарна. Мөрдөгч, прокурор, шүүгч үйл ажиллагаандаа шинжлэх ухаан, техникийн ололт амжилт, тэр дундаа тусгай

мэдлэгийг хэрхэн ашиглаж байгаа түвшин, шинжээчийн дүгнэлтийг үнэлэх чадвараас хамаарч шүүх ажиллагааны шинжлэх ухаанч хандлага тодорхойлогдоно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжлэх ухаанч хандах гэдэг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлж, үйл ажиллагаандаа хуулийг зөв хэрэглэхээс гадна, тусгай мэдлэг болон техник, технологийг үр дүнтэй, зөв ашиглах, шинжээч, мэргэжилтний үйл ажиллагаа, дүгнэлтийг үнэлэхдээ шинжлэх ухааны найдварт байдлыг тооцохыг чиглэлээ болгож буйг хэлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2-т “Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно”⁹ гэж заасан. Эргэлзээгүй байна гэдэг нь няцаагдаагүй үлдсэн, бодит үнэнд хамгийн ойр, үндэслэлтэй нотлох баримт байдаг. Эргэлзээгүй байхын гол шалгуур бол шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар юм.

Дээрхээс дүгнэвэл, хүний эрх, шүүхийн шинжилгээ нь хоорондоо шууд хамааралтай байх ба шинжлэх ухаан бол хүний эрхийн хамгаалалт мөн.

2. Шинжээчид хандах хандлага. Шинжээчид хандах хандлага бол хүний эрхийг шинжлэх ухааны аргаар хангах үзэл баримтлалд чухал нөлөөтэй. Түүхэн энэ цаг үед шинжлэх ухааны мэдлэг ард түмний дунд түгээмэл бус байсан тул зарга, заалхайд холбоотой зэвсгийн зүйл, мөр болон хүүр зэргийг “уран нарийн” аргаар шинжиж, хэрэгт ач холбогдолтой мэдээлэл

⁹ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017. №23.

гарган өгч буй хүнийг гайхан бишэрч, тэдний тайлбар, дүгнэлт гарцаагүй үнэн мэт санагдаж байсан нь лавтай. Энэ сэтгэлгээ, хандлага 1926 онд анх баталсан “Монгол Улсын шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль”, үүнээс хойших 1935, 1949 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олж, шинжээчийг эрдэмтэн лугаа үзэж, “эксперт” хэмээн нэрлэн, экспертээс хэргийн учрыг шинжлэн асуухыг гуйх, тусгай учир тохиолдвол аливаа эрдэмтэн ба эксперт зэрэг онц аж үйлдвэрийн байдал, төлөвийг мэдэх хүмүүсээс хэргийн учрыг тодорхойлуулах зэргээр хүндэтгэлтэй хандах талаар хуульчилсан байна.

ЭБШ хууль тогтоомжийн хөгжлийн энэ үед шинжээчийг шүүгчтэй зэрэгцүүлэн үзэх хандлага байсан ба Германы эрдэмтэн, хуульч, улс төрч Карл Миттермайер (1787–1867) XIX зууны 60-аад оны үед “шинжлэх ухааны шүүгч-шинжээч” гэсэн онол, үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Энэ онол ёсоор, “шүүхийн шинжилгээ нь нотлох баримт, баримт сэлттэй олон талаараа адилхан боловч, эрүүгийн хэргийн нотолгооны хувьд онцгой төрөл юм. Энэ нотлох баримтын гол мөн чанар нь дүгнэлт гаргасан хүний тусгай мэргэжлийн хүрээн дэх *их мэдлэг* юм. Иймд шинжээч шинжлэх ухааны шүүгч мөн”¹⁰ гэжээ.

Миттермайерын үзэл баримтлалыг Оросын эрүүгийн процессын нэрт эрдэмтэн Л.Е.Владимиров идэвхитэй дэмждэг. Тэрээр Миттермайерын дэвшүүлсэн ерөнхий гол санаа буюу 1-рт, шинжээчийн дүгнэлт шүүхийн шийдвэрийн үндэслэл, мөн иргэдийн төлөөлөгчийн оноож буй шийтгэлийн суурь болдог, 2-рт, шинжээчийн эзэмшсэн мэдлэгийг шүүгч эзэмшээгүй байдаг, тиймээс тэдний гаргасан дүгнэлтийг

шүүгч шалгаж үзэх боломжгүй¹¹ гэсэн онолыг дэмждэг байв.

Гэвч Оросын процессын дийлэнх эрдэмтэд Миттермайер болон Владимировын үзэл баримтлалыг эсэргүүцээр байжээ. Тэдний нэг нь И.Я.Фойницкий ба, тэрээр: “хэрвээ шинжээчийн дүгнэлтийг шүүх заавал баримтлавал эрүү шүүлт дахин хууль ёсны нотлох баримт болж сэргэнэ гэсэн үг” гэжээ. Шүүх болон шинжээчийн үйл ажиллагаа хоорондоо ялгаатай. Шүүгч бол гэм буруутай тухай асуултад богино хугацаанд эрс хариулт өгөх ёстойг хуулиар үүрэг болгосон. Харин шинжээч бол түүнээс асуусан асуултад хариулах боломжтой гэж өөрөө үзсэн тохиолдолд дүгнэлт гаргадаг. Шинжээч асуултад хариулахгүй байж болно, зарим тохиолдолд түдгэлзэж ч бас болно. Тэгвэл шүүгч ингэж чадахгүй¹² гэж шүүгч, шинжээч нарын процессын үүргийн ялгааг тайлбарлажээ. Шүүгч, шинжээч эрх мэдэл, үүрэг, үйл ажиллагаа зэргээр хоорондоо ялгаатай учраас энэ үзэл баримтлал шүүхийн практикт биелэлээ олоогүй байна.

“Шинжлэх ухааны шүүгч-шинжээч” онолоос үүдэлтэй “шинжээчийн дүгнэлттэй үл маргах зарчим” гэсэн ойлголт бий болжээ.

Шинжээчийн дүгнэлттэй үл маргах зарчим дараах нөхцөл байдлыг бий болгосон.

- Шинжээчийн дүгнэлт нотлох баримтын тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үзсэн;
- Шинжээчийн дүгнэлтийг шүтэх хандлага бий болсон;
- Шинжилгээний арга зүйг зөв үнэлж чадахгүйд хүрч, худал дүгнэлтийг ялгахгүй болсон;

¹¹ Владимиров Л.Е. Учение об уголовных доказательствах. 3-е изд. СПб., 1910. С 197.

¹² Фойницкий И.Я. Курс уголовного судопроизводства. 3-е изд. Т. 2. СПб., 1910.

¹⁰ Белкин Р.С. Криминалистическая энциклопедия. М., 2000. С.259.

- Шинжлэх ухааныг хууль бус шийдвэр гаргахад ашиглах эрсдэл бий болсон.

Монгол Улсад ХХ зууны 60-аад оныг хүртэл буюу ЭБШ хууль тогтоомжийн хөгжлийн эхэн үед шүүхийн шинжилгээ хийх эрх зүйн зохицуулалт, шинжээчийн эрх зүйн байдал системчлэгдээгүй байсан ба шинжээчийн дүгнэлтийг үнэлэх зарчим хуульчлагдаагүй байсан явдал нь ингэж хандахад хүргэжээ.

Харин 1963 оны ЭБШ хууль батлагдан гарснаар “шинжээчийн дүгнэлтэй үл маргах” зарчим, хандлага өөрчлөгдөхөд хүрсэн. Тус хуулийн 78 дугаар зүйлд “Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаагаа үндэслэсэн байвал зохино¹³” гэсэн зарчмыг анх хуульчилж, шинжээчийн дүгнэлтийг хэт шүтэх хандлага өөрчлөгдөх болсон.

“Шинжээчийн дүгнэлтийг баримтлах үүрэггүй” гэсэн зарчим 1963 оны социалист хэв маягийн ЭБШ хуулиас хойш 2002 оны ардчилсан хэв маягийн ЭБШ хуульд уламжлагдан хадгалагдаж, 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ч мөн адил утгаар хуульчлагдсан байх ба энэ зарчмаас үүдэлтэй шинжээч бол “шинжлэх ухааны гэрч” гэсэн хандлага шүүхийн практикт бий болжээ. Ингэснээр шинжээчийн эрх зүйн байдал гэрчтэй ижилсэж, дүгнэлт гаргуулахаар дуудах, албадаж ирүүлэх зэрэг эрх зүйн зохицуулалт бий болж төлөвшив. Түүнчлэн шинжээчээс мэдүүлэг авахад худал мэдүүлэг өгөх, эсвэл мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийх, татгалзвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ хэмээн

хуулийн хариуцлага сануулж, мэдүүлгийн тэмдэглэлд урьдчилан гарын үсэг зуруулдаг. Гэтэл 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254, 255 дугаар зүйлд шинжээч худал мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс зайлсхийх тухай диспозиц байдаггүй байсан. Энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нар шинжээчийг гэрчтэй адилтгаж ойлгодгоос үүдэлтэй, хууль зүйн үндэслэлгүй, буруу жишиг юм. Мөн ЭБШ хуульд 2007 онд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан шинжээчтэй холбоотой “ганц” заалт бол шинжилгээний хугацаа хэтрүүлбэл шинжээчид торгууль оногдуулахаар хуульчилж, шинжээчийн эрх зүйн байдлыг дордуулсан байна.

Шинжээчийг гэрчтэй адилтгах боломжгүй. Шинжээч, гэрч хоёул тухайн хэрэгт ямар нэгэн хувийн сонирхолгүй байх шинжээрээ төстэй боловч, нотлох баримтын эх сурвалж, объектив, субъектив хүчин зүйлсээрээ шинжээчийн дүгнэлт гэрчийн мэдүүлгээс ялгаатай байдаг. Шинжээч бодит байдлыг шинжлэх ухааны арга зүйгээр тайлбарладаг бол гэрч зөвхөн өөрт шууд тусгагдснаар ойлгож, хүлээн авснаараа тайлбарладаг.

Гэрчийн мэдүүлгийг үнэлэхэд тухайн хүний аливаа зүйлийг тусган ойлгох чадвар, сэтгэцийн байдал, нас, хүйс, боловсрол, эрүүл мэндийн байдал зэргийг харгалздаг. Энэ нь болж байгаа үйл явдалд анхаарлаа хандуулахдаа хүн бүр адил байдаггүйтэй холбоотой. Шинжээч тусгай мэдлэгийн хүрээнд, стандарт арга зүйн дагуу, шинжлэх ухааны бодит зүй тогтолд үндэслэн дүгнэлт гаргадаг тул гэрчийн мэдүүлгээс нотлох баримтын шалгуурын хувьд ялгаатай. Иймд шинжээчийн эрх зүйн байдлыг гэрчтэй адилтгаж, шинжээчийн дүгнэлтийг гэрчийн мэдүүлэгтэй нотлох баримтын шаардлагын хувьд ижил үнэлэх боломжгүй юм.

¹³ ХЗҮХ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Уб., 2012. 216 дахь тал.

“Шинжээчийн дүгнэлтийг баримтлах үүрэггүй” зарчим дараах нөхцөл байдлыг бий болгоод байна. Үүнд:

- Шинжээчийн дүгнэлт бусад нотлох баримттай ижил гэж үзэх;
- Шинжээчийн дүгнэлтэд дотоод итгэлээр ханддаг болсон;
- Шинжилгээний арга зүйд анхаарал хандуулдаггүй;
- Шинжээчийн эрх зүйн байдлыг гэрчтэй адил болгосон (албадах, торгох, байцаах).

Эртнээс өнөөг хүртэл шинжээчийг “шинжлэх ухааны шүүгч”, эсвэл “шинжлэх ухааны гэрч” гэж хоёр өөр хандлагаар тодорхойлж, шинжээчийн дүгнэлттэй үл маргах, эсвэл шинжээчийн дүгнэлтийг үл хэрэгсэх гэж нотлох баримтын хувьд эсрэг 2 туйл руу хэлбэлзүүлэн үнэлэх практик ЭШБ хууль тогтоомжийн хөгжлийн үе шатанд байжээ. Эдгээр ойлголтын шалтгаан нь шинжээчийн дүгнэлт найдвартай, үнэн зөв, эргэлзээгүй гэдгийг үнэлэх тусгай шалгуур байдаггүй байсанд оршиж байжээ гэж дүгнэж байна. Шинжээч бол шүүгч, гэрчийн аль нь ч биш, харин тусгай мэдлэгтэй хүн юм. Шинжээчийн дүгнэлтийг хэт шүтэх, эсвэл үл хэрэгсэж байгаа нь цаанаа хүний эрхийн зөрчлийг бий болгодог.

Иймд судлаач бид шинжлэн магадлахуйн хөгжлийн чиг хандлага болон ЭБШ ажиллагаа хүний эрхэд суурилсан байх зүй ёсны шаардлагад үндэслэн шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шинэ зарчим бий болгох шаардлагатай болоод байна. Энэ нь шинжээчийн дүгнэлтийн найдварт байдлыг үнэлэхэд тусгай шалгуур баримтлах зарчим билээ.

3. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуур. Шинжээчийн дүгнэлтийн баталгаатай, эргэлзээгүй байдлыг үнэлэхдээ нотлох баримтын бусад эх сурвалжтай

өрсөлдүүлэх нь зохимжгүй. Харин шинжлэн магадлах үйл ажиллагааны мөн чанар, зарчим, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах арга зүйн онцлогт үндэслэн боловсруулагдсан тусгай шалгуурыг баримтлан шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь процесс хэрэгжүүлэгчдийн шинжлэх ухаанч хандлагыг илтгэх ба хэргийн бодит үнэнийг эргэлзээгүй тогтоох зарчимд илүү нийцнэ.

Шинжээчийн дүгнэлт бусад нотлох баримтуудтай давхцаж байгаа бол бодитой дүгнэлт гарсан байна гэж үзэх нь өрөөсгөл ойлголт. Харин тухайн шинжээчийн дүгнэлтийг тодорхой шалгуураар үнэлснээр бодит, зөв дүгнэлт гарсан эсэхийг тогтооно. Түүнээс биш бусад баримтуудтай харьцуулж үзсэнээр бодит үнэлгээ хийлээ гэж болохгүй юм. Энэ тухай Р.С.Белкин, Ю.Г.Коруков нар “шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ бусад нотлох баримтуудтай харьцуулж үзэх ёстой гэсэн үзэл баримтлал нь шинжээчийн дүгнэлтийг бодитой дүгнэх чадваргүй байгааг харуулж байгаа явдал”¹⁴ гэсэн байдаг.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх шалгуурыг тусгайлан боловсруулах шаардлага байгаа юу гэдэг асуудал бидний өмнө гарч ирэх нь зүйн хэрэг бөгөөд энэ асуудлыг хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс авч үзэх хэрэгтэй.

Доктор Ж.Эрхэсулан бүтээлдээ: “Хэргийн байдлыг бүх талаас нь бүрэн бодитойгоор тогтоох явдал нь ...өнөө цагийн шаардлагыг харгалзан шүүгчийн дотоод итгэл, эрх зүйн үнэмшлийн шинжлэх ухааны үндэс бүхий загварчилсан шалгуур тогтоох нь онол арга зүйн төдийгүй практик ач холбогдолтой. Нотлох баримтын үнэлгээ, нотлох баримт үнэн болон

¹⁴ Коруков Ю.Г. Достоверность экспертного заключения и пути совершенствования ее оценки. //Вопросы теории судебной экспертизы. М., 1988.

худлыг шалгаж тогтоох үйл ажиллагааны стандарт хэрэгжүүлэх нь чухал байна¹⁵” гэж дүгнэсэнтэй санал нийлж байна.

Шүүхийн шийдвэр үнэн, бодитой байх гол үзүүлэлт нотлох баримтыг зөв үнэлэх асуудал. Энэ ч утгаараа шинжээчийн дүгнэлтийн найдвартай, баталгаатай, шинжлэх ухаанч байдал нь хүний эрх, эрх чөлөөг хангах зүй тогтолтой. Гэтэл шүүх шийдвэр гаргахдаа баримталдаг тэр нотлох баримт нь найдвартай, баталгаат байдлын шалгуурыг хангахгүй бол энэ зүй тогтол алдагдана. Практикт тулгамдсан эл асуудал нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэх тусгай шалгуур зайлшгүй байх ёстойг харуулж байна.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлж буй практикийг тодруулах үүднээс явуулсан¹⁶ санал асуулгын судалгааны “ЭБШХ-ийн 85 дугаар зүйлийн 85.4-т зааснаар шинжээчийн дүгнэлтийг заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ хэрхэн тодорхойлдог вэ?” гэсэн асуултад 71.4 хувь нь “Энэ бол дотоод итгэлийн асуудал” гэж, 28.6 хувь нь “тодорхой шалгуур хангахгүй байгааг ойлгоно” гэж хариулсан. Мөн “Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх стандарт шалгуурын талаар та юу мэдэх вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын 78.5 хувь нь “мэдэхгүй” гэж, 21.5 хувь нь “ЭБШХ-ийн 95-р зүйлд заасан шаардлага” гэж хариулжээ.

Санал асуулгын судалгаанаас үзвэл, шинжээчийн дүгнэлтийг баримтлах, эс баримтлахаа дотоод итгэлээр үнэлдэг гэсэн хэдий ч яаж дотоод итгэлтэй болдог талаараа мэдэхгүй байгаа нь сонирхол татаж

байна. Эндээс процесс хэрэгжүүлэгчид шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд учир дутагдалтай хандаж байна гэж дүгнэж байна.

Шинжээчийн дүгнэлт тодорхой шалгуур хангаж байвал тэрхүү “дотоод итгэл” төрнө. Шинжээчийн дүгнэлтийг хүн бүр дур зоргоор, өөрийн үзэмжээр үнэлэх бус харин процесст оролцогчдоос хүлээн зөвшөөрсөн тодорхой шалгуураар үнэлэх нь зүйн хэрэг.

XX зууны эхэн үеэс дэлхийн шинжлэн магадлахуйн хөгжлийг капиталист, социалист гэж хоёр өөр чиг хандлагаар тодорхойлж байсан АНУ, ОХУ-ын эрдэмтэд өнөөдөр шинжлэх ухааны бодит зүй тогтолд захирагдан, шинжээчийн дүгнэлтийг тусгай шалгуураар үнэлэх зарчим дээр санал нэгтэй байгаа нь харагддаг.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд хууль зүй, шинжлэх ухаан, техник, хүний хүчин зүйлийн шалгуурыг харгалзах ёстой¹⁷ гэж судлаачийн зүгээс санал болгож байна.

Хууль зүйн шалгуур:

1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий субъект шинжилгээ хийлгэсэн байх;
2. Хэрэгт хамааралтай байх;
3. Шинжээчийг татгалзан гарах үндэслэлгүй байх;
4. Шинжилгээний зүйлсийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулан шинжилгээнд хүргүүлсэн байх;
5. Шинжээч худал дүгнэлт гаргахгүй байх талаар хуульд заасан журмын дагуу баталгаа гаргасан байх;

¹⁵ Эрхэсхулан Ж. Шүүхийн шатанд эрүүгийн хэргийг үнэн бодитойгоор тогтоох онол, практикийн үндсэн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2013. 182 дахь тал.

¹⁶ Шинжилгээ хийлгэх эрх бүхий 250 албан тушаалтнаас санал асуулгын судалгаа авав.

¹⁷ Лхагвасүрэн Б. Криминалистикийн шинжилгээ судлал. Уб., 2010. 27 дахь тал.

Шинжлэх ухааны шалгуур:

1. Шинжээчээс асуусан асуултад орчин үеийн шинжлэх ухааны арга, хэрэгсэл хариулт өгөх боломжтой байх;
2. Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс шинжээчээс асуусан асуултад хариулт өгөхөд хангалттай, боломжтой байх;
3. Шинжээч өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийсэн байх;
4. Шинжилгээний арга зүй, технологи нь шинжлэх ухааны үндэстэй, найдвартай байхын зэрэгцээ баталгаажсан байх;
5. Шинжилгээ хийх тогтсон үе шагыг баримталсан байх;
6. Шинжилгээ хийх аргыг зөв сонгож, хослуулсан байх;
7. Шинжилгээнд шаардлагатай багаж, хэрэгслийг дүүрэн ашигласан байх;
8. Оношлогооны болон адилтгалын ач холбогдол бүхий шинж тэмдгүүдийн нийлбэр цогцыг үндэслэн дүгнэлтэнд хүрсэн байх.

Хүний хүчин зүйлийн шалгуур:

1. Тусгай мэдлэг эзэмшсэнийг гэрчлэх дипломтой байх, эсхүл тодорхой салбарт хүлээн зөвшөөрөгдсөн байх;
2. Шинжилгээ хийх, эрх лицензтэй байх;
3. Сэтгэцийн хувьд эрүүл байх;

Технологийн шалгуур:

1. Дүгнэлтийг монгол хэлээр бичсэн, шинжлэн магадлахуй, хууль, шинжлэх ухааны тогтсон нэр томъёо хэрэглэсэн байх;
2. Албан хэрэг хөтлөх стандартын дагуу бичсэн байх;

3. Утга, найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй байх;
4. Дүгнэлтийн нүүр бүрт шинжээч гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулсан байх;
5. Гэрэл зургийн үзүүлэлтэд тайлбар, хаяг, тэмдэглэгээ хийсэн байх. Жич: зарим төрлийн шинжилгээний гэрэл зургийн үзүүлэлтэд тэмдэглэгээ хийхгүй байх талаар стандартад тусгана. Хэрэв гэрэл зураг дээр тэмдэглэгээ хийсэн бол түүнтэй яг адил хяналтын гэрэл зургийг тэмдэглэгээгүйгээр үзүүлэх.

Дүгнэлт. Процессын эрхийг шинжлэх ухааны аргаар хангах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд шүүхийн шинжилгээний үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн дараах дүгнэлт гаргаж байна.

Криминалистик болон шүүхийн шинжилгээг “яллахуйн арга хэрэгсэл” хэмээн үзэх хандлага хууль зүйн салбарт гүн оршсоор байна. Энэ хандлагад яллах тал нотолгооны бүх арга хэрэгслийг давуу байдлаар ашигладаг хууль, эрх зүйн онцлог нөлөөлсөн гэж үзэж байна. Иймд шүүхийн шинжилгээг хүний эрхийг хангах, хамгаалахтай холбон шинэ хандлагаар өргөтгөн тайлбарлах хэрэгцээ, шаардлага эрх зүйн шинэтгэлтэй давхцан бий болжээ.

Болж өнгөрсөн хэрэг явдлын бодит байдлыг сэжиг төдий таамаглал, субъектив шинжтэй мэдүүлэг болон хүч хэрэглэх, эсвэл хуурч мэхлэх аргаар сэжигтэн, яллагдагчаар хэрэг хүлээлгэх (эрүү шүүлт) байдлаар тогтоох бус, харин “мөр үүсэх зүй тогтлын бодит үнэнд тулгуурлан, гэмт үйлдлийн тусгал болсон мөр, биет баримтыг шинжлэх ухаан, технологит суурилсан арга зүйгээр тайлбарлах замаар хэргийн бодит байдлыг нотлох ёстой” гэсэн

шинжлэх ухаанч хандлага манай орны хууль сахиулах, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд дутагдаж байна. Хэрэг, зөрчлийн бодит байдлыг эргэлзээгүй тогтоох, шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийн зөрчилгүй явагддаг байх “хууль зүйн шаардлага” хууль сахиулах, шүүх байгууллагын үйл ажиллагаанд нэмэгдэхийн хэрээр процесс хэрэгжүүлэгчдийн эрх зүйн мэдлэг, туршлагыг чадавхжуулахаас гадна, тэдний үзэл санааг хүний эрх болон шинжлэх ухаанч хандлагад чиглүүлэх нь гарцаагүй.

Санал: Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хангах баталгааг төгөлдөршүүлэх, шүүхийн шинжилгээг зөв, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах онолын болон практик ач холбогдол бүхий дараах саналыг боловсруулав. Үүнд:

1. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас 2005 онд баталсан 2005/26 дугаартай “Хүний эрх ба шинжлэн магадлахуй” хэмээх хүний эрхийн тогтоолын удиртгал хэсэгт заасан: “Шинжлэн магадлах үйл ажиллагаагаар хүний эрх болон олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн этгээдийн эсрэг нотлох баримт бүрдүүлснээр түүнд хариуцлага хүлээлгэх, амжилттай нотлох үндэслэл бий болгох, хүний эрхийн зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрөх” гэсэн заалтыг процесс хэрэгжүүлэгчид ухамсарлан, шүүхийн шинжилгээ бол “яллахуйн арга хэрэгсэл” гэсэн уламжлалт сэтгэлгээг өөрчлөх.
2. Шүүхийн хэлэлцүүлгийн явцад яллах, өмгөөлөх тал эрх тэгш мэтгэлзэх зарчимтай ба талуудын харилцан няцаалтын аль нь

илүү бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэйг шүүгч үнэлдэг. Шүүх ажиллагааны яллах, өмгөөлөх талууд шинжлэх ухааны тайлбар ашиглах тэгш боломжоор хангагдсан байх шаардлагатай тул шинжлэн магадлахуйн олон хэлбэрийн салбаруудыг хөгжүүлэх, үүсэн бий болох харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бий болгох зорилгоор Шүүхийн шинжилгээний тухай хуульд “Төрийн бус шүүхийн шинжилгээний байгууллага” гэсэн бүлэг зохицуулалт нэмэлтээр оруулах.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Шинжээчийн дүгнэлтийг шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлийг заана” гэсэн заалтыг “Шинжээчийн дүгнэлтийг шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч тусгай шалгуураар үнэлсний эцэст хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах эсэхийг шийдвэрлэнэ” гэж өөрчлөн найруулж, уг хэсгийн дараа “Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх тусгай шалгуурыг Улсын дээд шүүхээс тогтооно” гэж нэмэх.
4. Шүүхийн шинжилгээ нь хүний эрхийг хангах, хамгаалах “шинжлэх ухааны баталгаа” болохынх нь хувьд шүүхийн шинжилгээний байгууллагын төрөлжсөн лабораториудын шийдвэрлэх асуудлын хүрээг нэмэгдүүлж,

шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, шинэ тутам шаардлагатай байгаа лабораториуд байгуулах, шинжээчдийг чадавхжуулах, олон улсын шинжилгээний стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

5. Шинжээчийн тусгай мэдлэг эзэмшсэн сургалтын үйл явц, шинжилгээний тодорхой нэг төрлөөр мэргэшсэн байдал нь түүний гаргасан дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэлтэй шууд хамааралтай тул Монгол Улсын шинжлэн магадлахуйн салбарын шинжээч бэлтгэх, шинжилгээ хийх эрх олгох, мэргэшүүлэх, давтан сургах, боловсролын зэрэг ахиулах сургалтын үйл ажиллагаа шаталсан, тасралтгүй байх зарчмаар явагдах шаардлагатай. Ингэснээр шинжлэн магадлахуйн боловсрол эзэмшсэн, шинжилгээний тодорхой төрлөөр нарийн мэргэшсэн хүний нөөц Монгол Улсын шүүхийн шинжилгээний хөгжлийн суурь болно.

Эх сурвалж

Хууль, эрх зүйн баримт бичгийн эмхтгэл.

1. Монгол Улсын Үндсэн хууль. // Төрийн мэдээлэл. 1992. №1.
2. Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. // Төрийн мэдээлэл. 2010. №2.
3. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл. 2017. №23.
4. Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. Уб., 2010.

5. Олон улсын хүний эрхийн билл. МУХЭҮК. Уб., 2015.
6. Хүний эрх-олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл: НҮБ. Уб., 1992.

Онолын болон судалгааны бүтээл

1. Белкин Р.С. Криминалистическая энциклопедия. М., 2000.
2. Владимиров Л.Е. Учение об уголовных доказательствах. 3-е изд. СПб., 1910.
3. Корухов Ю.Г. Достоверность экспертного заключения и пути совершенствования ее оценки. // Вопросы теории судебной экспертизы. М., 1988.
4. Лхагвасүрэн Б. Криминалистикийн шинжилгээ судлал. Уб., 2010.
5. Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008.
6. ХЗҮХ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Уб., 2012.
7. Фойницкий И.Я. Курс уголовного судопроизводства. 3-е изд. Т. 2. СПб., 1910.
8. Шударга шүүлгэх эрх. Эмнести интернэшнл. Уб., 2013.
9. Эрхэсхулан Ж. Шүүхийн шатанд эрүүгийн хэргийг үнэн бодитойгоор тогтоох онол, практикийн үндсэн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2013.

Цахим сурвалж

1. https://s3.amazonaws.com/PHR_Reports/istanbul-protocol_opt.pdf
2. www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/Forensic.aspx

ТӨРИЙН НУУЦ БА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ



Үндэсний Тагнуулын Академийн
эрх зүйн тэнхимийн эрхлэгч, докторант

Б.БАТХИШИГ

Өнгөрсөн зууны хагасаас хойш олон улсын хэмжээнд мэдээлэл олж авах эрхийг хүний суурь эрхийн хэмжээнд хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэх боломж, механизмыг хууль тогтоомжоор баталгаажуулахад онцгой анхаарч байна. НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн 1946 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 59 дүгээр тогтоолын тэргүүн хэсэгт “Мэдээллийн эрх чөлөө бол хүний суурь эрх мөн бөгөөд НҮБ-ийн хүндэтгэн дээдэлсэн бүхий л эрх чөлөөний тулгуур мөн”¹ гэж заасан нь орчин үед мэдээллийн эрх чөлөө хүний эрх, эрх чөлөөний дотор ямар чухлаар тавигдаж буйг илэрхийлдэг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах,

түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.”² гэж мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан нь хүний эрхийн олон улс, бүс нутгийн хэмжээний бусад гэрээ, конвенцид нэгэн адил тусгалаа олсон байна.

Хүний эрхийн салбар дахь олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хүний мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хангах, хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээсний дагуу дэлхийн ардчилсан орнуудад энэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг батлан гаргаж, эрх зүйн нийтлэг жишгийг нэгэнт тогтоожээ. Хамгийн анх Скандинавын орнууд, түүний дотор Швед Улс 1766 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлан гаргаснаас хойш 1951 онд Финлянд, 1966 онд Америк, 1970 онд Дани, Норвеги, 1973 онд Австри, 1978 онд Франц, Голланд, 1982 онд Австрали, Шинэ Зеланд, Канад, 1990-1999 онд Итали, Унгар, Португал, Бельги, Ирланд, Тайланд, Өмнөд Солонгос, Израйл, Чех, Япон Улс мэдээллийн эрх чөлөөний

¹ www.medialaw.asia/document/-430

² Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс. Олон Улсын хүний эрхийн билл. УБ., 2015, 15 дахь талд.

тухай хуулиа батлан гаргасан байна. Эдгээр оронд ил тод байдлын зарчим хуульчлагдсан байна. Харин шинээр ардчилсан тогтолцоонд шилжсэн орнуудад 1990-ээд оны төгсгөл үеэс “мэдээллийн эрх чөлөө” болон “ил тод байдал” гэдэг нэр томъёонууд хэрэглэгдэж, хууль зүйн түвшинд бэхжүүлж эхэлжээ.

Манай улсад 1992 оны анхны ардчилсан Үндсэн хуульдаа “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, тайван жагсаал, цуглуулан хийх эрх чөлөөг тунхаглан баталгаажуулсны зэрэгцээ түүнтэй салшгүй холбоотой “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах” эрхийг давхар хүлээн зөвшөөрч хуульчилсан. Эдгээр заалтын дагуу дээрх эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотой 1994 онд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, 1995 онд Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль, 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон мэдээлэл ил тод, нээлттэй байх шаардлага, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эдгээр эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн тодорхой заалтыг тусгасан хуулиудыг батлан гаргасан байна. “2007 онд манай хуульчдын Монголд үйлчилж буй 360 хуульд хийсэн судалгаагаар 120 гаруй хуулийн зүйл, заалтаар мэдээлэл ил тод байдал, нээлттэй байх зарчим, хэм хэмжээг зохицуулсан”³ байжээ. Харин ардчилсан орнуудын нийтлэг жишиг болсон мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах суурь хууль болох Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай

хуулийг нилээд хожуу буюу 2011 онд батлан гаргасан байна. Түүнчлэн төрийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой Шилэн дансны тухай хуулийг Улсын Их Хурал 2014 онд баталсан. Үндсэндээ Монгол Улсад иргэний мэдээллийн эрх чөлөөг хангах, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах эрх зүйн орчин ихээхэн өргөжиж байна гэж дүгнэж болохоор байна.

Хүний эрхийн олон улсын эрх зүйн баримт бичигт ч, ардчилсан нийгмийн үзэл санаанд ч тодорхой мэдээлэл олж авах, танилцах, тараах эрхэд хуулиар тодорхой шалгуурын үндсэн дээр хязгаарлалт тогтоож болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасны дагуу мэдээллийн эрх чөлөөг “гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон” тохиолдолд хязгаарлаж болно. (29 дүгээр зүйл) мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 12.1, 18.2, 19.3, 21, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарлалтыг хэрэв зайлшгүй шаардлагатай бол дараах тохиолдолд хэрэглэж болохоор заасан. Үүнд:

- үндэсний болон нийгмийн аюулгүй байдлыг хангах;
- хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах;
- бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах;
- нийгмийн дэг журмыг хамгаалах;

Дээр дурдсан үндэслэлээр иргэний мэдээллийн эрх чөлөөнд тогтоосон нэг хязгаарлалт бол үндэсний аюулгүй байдлын хангах зорилгоор хуулиар тогтоож хамгаалсан

³ Мэдээллийн эрх чөлөө. Хууль боловсруулагч, тогтоогчдод зориулсан гарын авлага. УБ., 2009 он, 12 дахь тал.

нууц мэдээлэл юм. Энэхүү үндэсний аюулгүй байдлаа хангах зорилгоор хуулиар нууцалж хамгаалалтад авдаг мэдээллийг ихэнх оронд төрийн нууц гэж нэрлэдэг.

Ардчилсан орнуудад төрийн нууцад хамааруулж нууцлах мэдээллийг тогтооход тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах үр дагавартай эсэхэд онцгойлон анхаарч, энэ шалгуураар төрийн нууцад хамаарах мэдээллийг тодорхойлдог. Энэ нь гадаад орнуудын төрийн нууцын тухай хууль тогтоомжид заасан төрийн нууцын тухай ойлголтод ч агуулагдаж байдаг. Тухайлбал, ОХУ-ын Төрийн нууцын тухай хууль⁴-ийн 2 дугаар зүйлд “төрийн нууц гэж задруулбал, ОХУ-ын аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тус улсын цэргийн, гадаад бодлого, эдийн засаг, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх-эрэн сурвалжлах үйл ажиллагааны салбар дахь төрийн хамгаалалтад байх мэдээлэл” гэж тодорхойлжээ.

Украин Улсын Төрийн нууцын тухай хууль⁵-д заасны дагуу “төрийн нууц гэдэгт хуулиар тогтоосон журмын дагуу төрийн нууц болохыг хүлээн зөвшөөрсөн, төрөөс хамгаалбал зохих, задруулбал Украины үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, гадаад харилцаа, төрийн аюулгүй байдал, эрх зүйн дэг журмыг хамгаалах хүрээн дэх мэдээлэл агуулсан нууц мэдээллийн төрлийг ойлгоно.” гэж заасан байна.

Европын холбооны гишүүн Болгар Улсын Нууц мэдээллийг хамгаалах тухай хууль⁶-ийн 25 дугаар зүйлд заасны дагуу *төрийн нууц* нь “үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад бодлого, үндсэн

хуулиар тогтоосон журмыг хамгаалахтай холбоотой, хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд Бүгд Найрамдах Болгар Улсын ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах тус хуульд заасан мэдээлэл”, Литва Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль⁷-д төрийн нууцыг “тус хуулиар тогтоосон журмын дагуу нууцалсан, үрэгдүүлэх эсхүл хууль бусаар задруулсан тохиолдолд төрийн ашиг сонирхолд хохирол учруулах, хүний амь насыг аюулд оруулах, Литовын Бүгд Найрамдах Улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, батлан хамгаалах хүчин чадалд аюул заналхийлэл учруулж болзошгүй төрийн, цэргийн, тагнуул, сөрөх тагнуулын, хууль сахиулах, шинжлэх ухаан техникийн мэдээлэл” гэж тодорхойлжээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хууль⁸-ийн 93 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн нууц нь ХБНГУ-ын гадаад аюулгүй байдалд хүнд хор уршиг учруулах аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд гадаад улсаас нууцлан хамгаалах, зөвхөн хязгаарлагдмал хүрээний этгээд танилцах үйл баримт, эд зүйл, мэдлэг мөн.” гэж заажээ.⁹

Дээрх орнуудын төрийн нууцын тухай хууль тогтоомжид заасан төрийн нууцын тухай ойлголтыг тодорхойлох нийтлэг шинж нь улсын аюулгүй байдал, ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах мэдээлэл болох нь тодорхой байна.

Гадаад орнуудын нэгэн адил манай улсын хууль тогтоомжид төрийн нууцыг тодорхойлох гол шинж нь үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах үр дагавар болохыг Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн 16 дугаар зүйлийн

⁴ Закон Российской Федерации “О государственной тайне”. 1993.06.21, №5485-1

⁵ Закон Украины “О государственной тайне” 1994.01.21 №3855-XII

⁶ Classified information protection act, 2002.04.30 Official Gazette No. 45/30.04.2002

⁷ Law on State Secrets and Official Secrets, November 25, 1999. No. VIII-1443 Official translation.

⁸ Criminal Code (Strafgesetzbuch, StGB) As promulgated on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 945, p. 3322).

⁹ German criminal code. 13 November 1998, Federal Law Gazette (Bundesgesetzblatt) I p.3322

17-д “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”, Төрийн болон албаны нууцын тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно” гэж тус тус хуульчлан баталгаажуулсан.

Энэ бүхэн нь төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт нь төрийн нууцын тухай хууль тогтоомжоор тогтоосон үндсэн шалгуур шинжид нийцсэн байх ёстойг харуулж байна. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлын асуудал нь өргөн хүрээтэй, олон салбарыг хамаарах учир түүний дотор ямар мэдээлэл нь аюул, занал, хохирол учруулах үр дагавартай болохыг нарийвчлан тогтоох шаардлагатай гэсэн үг. Эс тэгвээс үндэсний аюулгүй байдал гэдэг нэрийн дор хэт өргөн хүрээтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлах, ингэснээр төрийн нууцын утга агуулга алдагдаж, ардчилсан нийгмийн үнэт зүйл, иргэний мэдээллийн эрх чөлөөг зөрчих сөрөг үр дагавартай юм. Ийм учраас хууль тогтоогч төрийн нууцын тухай хууль тогтоомжийг боловсруулах, батлан гаргахад төрийн нууц буюу үндэсний аюулгүй байдалд аюул, занал, хохирол учруулах мэдээлэл болох эсэхэд онцгой анхаарал хандуулах ёстой.

Саяхан хүртэл буюу 2017 оны 9 дүгээр сарын 1-нийг хүртэл үйлчилж байсан Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай Монгол Улсын

хуулиудад заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг үзэхэд, тэдгээр нь төрийн нууцын үндсэн шалгуур шинж болоод иргэний мэдээллийн эрх чөлөөг хангах талаас ихээхэн дутагдалтай байв. Тодруулбал, Төрийн нууцын тухай хуульд төрийн нууцын ойлголтыг “задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээлэл” болохыг онцлон заасан ч Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд тухайн үндэслэл, шалгуурт нийцэх эсэх нь эргэлзээтэй олон мэдээлэл төрийн нууцад хамаарч байв. Тухайлбал, хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын ажлын удирдамж төлөвлөгөө, төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг устгасан тухай мэдээ, баримт бичиг, иргэний хамгаалалтын оператив болон онцгой үеийн арга хэмжээний төлөвлөгөө, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, улсын онц чухал болон тусгай объектын байршил, газрын нэр, шинжлэх ухаан, технологийн ололтыг дотоод, гадаадад дамжуулах лицензийн гэрээтэй холбоотой баримт бичиг, иргэний бүртгэл, мэдээллийн улсын сан гэх мэт мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалд ямар хохирол учруулах үр дагавартай гэж үзсэн нь тодорхойгүй байлаа.

Гадаад орнуудын нийтлэг жишигт төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл нь түүнийг задруулсан тохиолдолд үндэсний аюулгүй байдалд хүнд, эсхүл онц хүнд хохирол учруулах мэдээлэл болохыг шууд тодорхойлдог. Тэдгээрийн нэгэн адил манай улсын хуульд төрийн нууцад хамаарах мэдээллийн нууцын зэрэглэлийг “Онц чухал-маш нууц”, “Маш нууц”, “Нууц” гэсэн заасан боловч заримд нь “нууцалсан зэрэглэлээр” хэмээн нээлттэй орхисон байв.

Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд “холбогдох”, “нууцалбал зохих” мэдээ, баримт бичиг, эд зүйл, үйл ажиллагаа гэсэн томъёолол их тусгагдсан байсан бөгөөд энэ нь түүнтэй холбоотой бүх зүйлийг төрийн нууцад хамааруулж, өргөн хүрээтэй тогтоох боломжийг бий болгодог. Ийм учраас тэдгээрийн дотроос үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах шалгуур хангасан төрийн нууцад хамаарах мэдээллийг нарийвчлан тогтоох шаардлага үүсдэг ч хуульд түүнийг тогтоох субъект, эрх үндсийг ч заагаагүй байв.

Шинээр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлд өмнө үйлчилж байсан төрийн нууцын тухай хууль тогтоомжид төрийн нууцад хамааруулж байсан зарим мэдээллийг хасч, төрийн нууцад хамаарах мэдээллийн нарийвчилсан жагсаалтыг Засгийн газар батлан гаргахаар заасан байна. Мөн төрийн нууцын зэрэглэлийн шалгуурыг “Онц чухал”, “Маш нууц” зэрэглэл тус бүрээр зааж, үр дагавар нь задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд, эсхүл хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээлэл байхаар тогтоожээ. Эндээс үзвэл, төрийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох шалгуур шинж тодорхой болж, үндэсний аюулгүй байдлыг хангах болон иргэний мэдээллийн эрх чөлөөг хамгаалах тал дээр ихээхэн ахиц гарсан байна. Гэвч өмнөх хуулиудад гарч байсан төрийн нууцад хамаарах эсэх нь эргэлзээтэй мэдээлэл тодорхой хэмжээнд байсаар байгаа нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалт дээр харагдаж байна.

Түүнчлэн шинээр “хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл” (13 дугаар зүйлийн 13.1.5.”ж”)–ийг төрийн нууцад хамааруулсан нь илэрхий зөрчилтэй заалт болжээ. Учир нь энэ заалтын дагуу тухайн албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай, түүний дотор ханиад хүрсэн, хоолой өвдсөн гэх мэт бүх мэдээлэл төрийн нууцад хамаарахаар болсон байна. Түүнээс гадна төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээллийг нууцлахыг хориглож ил байх шаардлага тавьдаг гадаадын зарим орны жишигтэй ч зөрчилдөж байна. Тухайлбал, ОХУ-ын Төрийн нууцын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан төрийн нууцад хамааруулах болон нууцалж болохгүй мэдээлэлд иргэний эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн гамшиг, осол, онцгой үйл явдал, тэдгээрийн үр дагавар, түүнчлэн гамшиг, түүний албан ёсны урьдчилсан мэдээ болон үр дагаврын тухай, гэмт явдлын төлөв байдлын тухай, төрөөс иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжид олгосон онцгой эрх, нөхөн төлбөр, халамжийн тухай, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний зөрчлийн тухай, улсын алтны, валютын нөөцийн хэмжээний тухай, төр засгийн байгууллага, албан тушаалтны хууль ёс зөрчсөн тухай мэдээллээс гадна “ОХУ-ын төрийн өндөр албан тушаалтнуудын эрүүл мэндийн байдлын тухай” мэдээлэл ч багтдаг.

Энэ бүхнээс үзэхэд, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцад хамааруулсан тодорхой мэдээлэл нь төрийн нууцын үндсэн шалгуур шинжид нийцээгүй, төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих иргэний эрхийг хязгаарласан хэм хэмжээг

агуулж байгаа нь тодорхой байна. Үүний шалтгаан нь төрийн нууцад хамааруулах мэдээллийг тогтоохдоо аюул занал, хохирол учруулах шалгуур шинжийг анхаараагүй, түүнчлэн тус хуульд олон улсын гэрээ, төрийн бүрэн эрхт байдал, ардчилсан үндсэн хуулийн журамд үл нийцэх мэдээллийг төрийн нууцад хамааруулахыг хориглосон эрх зүйн зохицуулалт тусгаагүйтэй холбоотой болов уу.


Орчин үед мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн ил тод байдлыг хангах нь төр засгийн шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус үйлдэлтэй тэмцэх, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах төдийгүй үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй гэх үзэл хандлага дэлхий нийтэд бий болсон. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдал гэдэг нэрийн дор төр засгийн хууль бус үйл ажиллагааг нууцлах боломж нь

улсын оршин тогтнол, ардчилсан дэглэмд сөргөөр нөлөөлөх учир үүнээс иргэд хяналт тавих боломжийг хангаснаар сэргийлнэ гэж үзэх болсон байна. Энэ нийтлэг чиг хандлагыг ч манай улсад төлөвшүүлэх, үндэсний аюулгүй байдлын салбар дахь холбогдох хууль тогтоомжийг боловсруулах, батлан гаргахад харгалзан үзэх шаардлагатай юм.

Дээрх чиг хандлагын дагуу авч үзвэл, мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлахад үндэсний аюулгүй байдалд аюул занал, хохирол учруулах шалгуур шинж эс харгалзан тогтоовол хүний эрхийн салбар дахь олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн иргэний суурь эрх болох мэдээллийн эрх чөлөөг зөрчөөд зогсохгүй үндэсний аюулгүй байдалдаа эргээд сөргөөр нөлөөлөхөд хүргэх үр дагавартай болохыг онцгой анхаарах нь зүйтэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭНИЙ ДАВХАР ХАРЬЯАЛЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



Гадаадын иргэн, харьяатын газар
Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн дарга,
олон улсын эрх зүйн магистр

З.ӨНӨРСАЙХАН

Оршил

Иргэний харьяалал нь төрийн зүгээс баталгаажуулсан иргэний эрх, эрх чөлөө бөгөөд иргэний харьяалалтай болох, харьяаллаа алдах нь тухайн улс орны тусгаар тогтнолтой холбоотойгоор зохицуулагдаж байдаг хүний эрхийн асуудал юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 15 дугаар зүйлд хүн бүр иргэний харьяалалтай байх эрхийг баталгаажуулж, аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй болохыг заасан билээ.

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйлд зааснаар аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар ялгаварлан гадуурхахдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлагатай хамгаалалт эдлэх ёстой бөгөөд энэхүү хамгаалалтад хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрх хамаардаг болно.

Даяаршлын өнөө үед монголчууд бусад улс оронд ажиллаж, амьдрах болсноор ялангуяа тэдгээрийн хүүхэд нь хөрсний зарчимтай улсад төрсөн, цусны зарчимтай улсын иргэнээс төрсөн, гэрлэлтээр иргэнээ болгодог улсын иргэнтэй гэр бүл болсон, гадаадын иргэнд үрчлүүлсэн, давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсын иргэний харьяалалтай болсон зэргээс шалтгаалан иргэний давхар харьяаллын асуудал хөндөгдөх боллоо.

Иймээс монголчуудын бусад улс орны иргэний харьяалалтай болж байгаагаас үүдэн гарч байгаа давхар харьяаллын эрх зүйн орчин, иргэний харьяалалтай байх эрхийн баталгааг олон улсын нийтлэг зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хоёр: Иргэний давхар харьяаллын тухай ойлголт, олон улсын туршлага

Иргэний давхар харьяаллын асуудал нь хувь хүн нэгээс илүү улсын иргэний харьяалалтай болох, тухайн улс тухайн этгээдийг өөрийн улсын харьяалалтай иргэн

хэмээн хүлээн зөвшөөрөх агуулга бүхий улс орны бодлогын шинжтэй олон улсын эрх зүй дэх иргэний эрхийн статусын онцгой төрөл юм.

Дэлхийн улс орнууд “jus sanguinis” буюу “цусны”, “jus solis” буюу “хөрсний” гэсэн 2 үндсэн зарчмын аль нэгийг баримтлан харьяаллын асуудлыг зохицуулдаг болно. Хүүхдийн харьяаллыг эцэг, эхийн харьяаллаар тогтоохыг “цусны”, хүүхэд тухайн улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол эцэг, эхийнх нь харьяаллыг үл харгалзан уг улсын харьяаллаа олгохыг “хөрсний” зарчим гэдэг.

Дэлхийн 172 оронд иргэний харьяаллын хууль тогтоомжуудыг харьцуулсан судалгаанаас үзэхэд 51 улс (Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Монгол Улс) давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй, 50 улс (Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Болгар, Франц, Унгар, Итали, Словак, Турк Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Канад Улс, Оросын Холбооны Улс, Румын Улс, Швейцарын Холбооны Улс, Шинэ Зеланд) давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг, 71 улс (Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Испаний Вант Улс, Тайландын Вант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улс) давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй боловч онцгой тохиолдолд зөвшөөрдөг байна.¹

Иргэний давхар харьяалал дараах нөхцөл, шалтгааны улмаас үүсдэг. Үүнд:

1. “Цусны” зарчим баримталж харьяаллын асуудал шийдвэрлэдэг улсын харьяат эцэг, эхээс “хөрсний”

¹ United states office of personnel management investigations service “Citizenship laws of the world” IS-1 March 2001, Дэлгэрэнгүйг www.multiplecitizenship.com харна уу.

2. Өөр улсын иргэнтэй гэр бүл болж тухайн улсын харьяаллыг авахад;
3. Натурализацийн аргаар буюу хүсэлт гаргаж харьяалалтай болсноор эсхүл гадаад улсын харьяалалтай болох хүсэлт гаргасан иргэнд тухайн улсаас анхдагч(төрөлх) харьяаллаа хадгалахыг зөвшөөрөхөд;
4. Улс орнууд хоорондоо хүн амынхаа тодорхой хэсэгт (тухайлбал, түүхэн шалтгааны улмаас гадаадын харьяалалтай болсон үндэстэн нэгтнүүддээ) давхар харьяалалтай байхыг зөвшөөрсөн хэлэлцээр байгуулахад;
5. Анхдагч (төрөлх) харьяалалтай улсаасаа зөвшөөрөл авалгүйгээр өөр улсын харьяалалтай болсон хүнд төрөлх харьяаллаа хадгалахыг зөвшөөрөхөд эсхүл өөр улсын харьяалалтай болсон тухай төрөлх улсад нь мэдэгдээгүй тохиолдолд тухайн иргэн албан ёсны давхар харьяалалтай байх нөхцөл бүрдэх зэрэг болно.

Олон улсын хэмжээнд давхар харьяалал бүхий иргэдийн тоог цөөлөх, шинээр бий болгохоос зайлсхийх, урьдчилан сэргийлэх бодлого баримталж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллага 1954 онд Харьяалалгүй иргэдийн статусын тухай, 1961 онд Харьяалалгүй байдлыг бууруулах тухай, Европын холбоо 1963 онд Давхар харьяаллыг бууруулах тухай конвенци тус тус баталжээ.

Гэвч дэлхийн улс орнуудын харилцаанд бий болсон шинэ нөхцөл байдал давхар харьяаллыг зарим талаар хүлээн зөвшөөрөх хандлагыг бий болгож байна. Дэлхий дахины эдийн засгийн интеграцчилал

хийгээд Европын холбоо байгуулагдсанаар иргэний давхар харьяаллын асуудалд зарим нэг өөрчлөлт гарч байна. Тухайлбал, Давхар харьяаллыг бууруулах тухай Европын холбооны 1963 оны конвенцийн давхар харьяаллыг бууруулах, хориглох шаардлагыг зөөлрүүлж 1993 онд нэмэлт протоколыг бий болгосон байна.

Үүнээс гадна 1997 оны Европын холбооны Харьяатын тухай конвенцид зааснаар төрснөөр буюу гэрлэснээр давхар харьяаллыг шууд авах, аливаа улсын харьяалалтай болохдоо өмнөх улсын харьяаллаас татгалзахыг шаардах эсэхээ гишүүн орнууд өөрсдөө шийддэг тогтолцоо бий болсон байна.

Энэ үйл явцтай зэрэгцээд зарим улс орон эх орондоо буцаж ирсэн цагаач иргэдийн давхар харьяаллыг хүлээн зөвшөөрч байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Колумби Улс 1991, Бүгд Найрамдах Доминикан Улс 1994, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс 1996, Мексикийн Нэгдсэн Улс 1998 онд тус тус давхар харьяаллыг хүлээн зөвшөөрчээ. Азийн улс орнуудаас Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам зэрэг улс саяхнаас тодорхой нөхцөлөөр давхар харьяаллыг хүлээн зөвшөөрч эхэлсэн байна. Тухайлбал, 2005 оноос Энэтхэг Улс нь Исламын Бүгд Найрамдах Пакистан болон Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсаас бусад оронд байгаа энэтхэг гаралтай хүмүүсийн давхар харьяаллын асуудлыг хүлээн зөвшөөрөх болсон байна. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын парламент 2008 онд давхар харьяаллыг хүлээн зөвшөөрсөн хууль батлан гаргажээ.

Манай хоёр хөршийн тухайд Бүгд Найрамдах Хятад Ард Улс давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй, харин

Оросын Холбооны Улс давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг болно. Мөн Оросын Холбооны Улс нь олон улсын гэрээний хүрээнд тухайлбал, Бүгд Найрамдах Таджикистан, Туркменистан зэрэг улстай давхар харьяаллыг зохицуулах талаар хэлэлцээр байгуулжээ.

Давхар харьяалалтай иргэдийн хувьд улс төр, иргэний эрхийг эдлүүлэх, хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг нь хамгаалах, татвар, нийгмийн даатгалд хамруулах, улс төрийн болон төрийн алба хаших, цэргийн алба хаах зэрэг асуудлыг олон улсын эрх зүйгээр зохицуулах шаардлагатай байдаг. Олон улсын өнөөгийн практикт давхар харьяалалтай хүмүүсийг голчлон байнга оршин суугаа улсынх нь иргэн гэж үзэх хандлага байдаг учраас тэр улсынх нь хууль тогтоомжийн дагуу эдгээр асуудлыг шийдвэрлэдэг байна.

Иргэний давхар харьяалалтай иргэн гэж тусгаар тогтносон, бүрэн эрхт хоёр буюу түүнээс дээш улстай улс төр-эрх зүйн хамааралтай болсон бөгөөд тэдгээр нь тухайн иргэнийг өөрийн улсын иргэний харьяалалтай хэмээн хүлээн зөвшөөрөх² явдал хэмээн тайлбарласан байдаг. Нэгээс дээш иргэний харьяалалтай байхыг хоёрдмол харьяалал, давхар харьяалал, олон харьяалал зэргээр томъёолж байна.

Улс орон бүр өөрийн иргэний харьяаллын хуульд үндэслэн, хувь хүний иргэний харьяаллыг тогтоож байна. Улс орон бүрийн иргэний харьяаллын зарчмын ялгаатай байдлаас үүдэн хувь хүн олон иргэний харьяалалтай байх боломжтой болж байгаагаас иргэний харьяаллын зөрчил, хийдэл үүсч байна. Олон улсын эрх зүйд хүн нэг зэрэг олон иргэний харьяалалтай байхыг иргэний харьяаллын идэвхтэй зөрчилдөөн, харьяалалгүй байхыг

² С.Нарангэрэл. 2008 он. Эрх зүйн эх толь бичиг УБ, Адмон, х-494

иргэний харьяаллын идэвхгүй зөрчилдөөн гэж томъёолдог. Идэвхтэй зөрчилдөөн түүний аль улсын иргэний харьяаллыг баримтлахыг, идэвхгүй зөрчилдөөн ямар хууль баримтлахыг тогтоодог байна.

Давхар харьяаллын асуудлыг шийдвэрлэх нэг арга бол тухайн хоёр улсын хооронд давхар харьяаллын асуудлаар гэрээ байгуулах явдал юм. Энэхүү гэрээг *нэгдүгээрт*: давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх таслан зогсоох, *хоёрдугаарт*: давхар харьяаллыг харилцан зөвшөөрч, үүсэх асуудлуудыг зохицуулах гэсэн хоёр үндсэн зорилгоор байгуулдаг байна. Мөн улс орнууд давхар харьяаллаас урьдчилан сэргийлэх бөгөөд устгах талаар хоёр талын хэлэлцээр хийж байна.

Олон улсын практикт иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөх, хориглох, хүлцэх хандлага, зарчмыг хэрэглэдэг. Үүнтэй уялдан олон улсын практикт иргэний давхар харьяаллын асуудлаар байгуулсан гэрээг гурав ангилж үздэг.

1. Давхар харьяаллын асуудлыг зохицуулахад чиглэгдсэн гэрээнүүд;
2. Давхар харьяаллыг устгахад чиглэсэн гэрээнүүд; Давхар харьяаллаас урьдчилан сэргийлэх үүднээс тухайн үедээ Зөвлөлт Холбоот Улс бүх социалист орнуудтай ийм агуулгатай гэрээ байгуулдаг байжээ. Үүний үндэс нь давхар харьяалалтай иргэн тодорхой хугацааны дараа аль нэгийг сонгох ёстой гэсэн дүрмийг тогтоодог. Хэрэв тогтоосон хугацааны дараа сонголт хийгдээгүй бол нутаг дэвсгэр дээр нь амьдарч байгаа улсын иргэний харьяалалтай байна.
3. Давхар харьяаллын үр дагаврыг арилгахад чиглэгдсэн гэрээнүүд; (дипломат хамгаалалт үзүүлсэн

эсхүл цэргийн алба хашсантай холбогдуулан)

Зарим улс орнуудын хууль тогтоомжид иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх зарчмыг баталгаажуулсан нь эрх зүйн үр дагаврыг хүлээн зөвшөөрөхгүй байхыг илэрхийлнэ. Энэ нь 1930 оны Гаагийн конвенцийн 3 дугаар зүйлд үндэслэдэг болно. Улс орнуудын иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх зарчмыг хэрэглэхийг хориглосон эсхүл хязгаарласан, олон улсын эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ байдаггүй.

Иргэний давхар харьяаллын асуудлыг авч үзэхийн тулд улс орнуудын дамнасан шилжилт хөдөлгөөн тэр дундаа “оюуны нүүдэл”³ буюу буурай хөгжилтэй улс орнуудын олон арван эрдэмтэд, мэргэшсэн хүний нөөц өндөр хөгжилтэй улс оронд ажиллаж, амьдрахаар явж буй их нүүдэлтэй салшгүй холбоотой бөгөөд үүнийг хөндөж ярихаас өөр аргагүй юм.

Зарим улс орнууд хүн амын дунд өөрийн үндэстний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, үндэстний эв нэгдлийг хангах, түүхэн шалтгааны улмаас харь улсад суугаа нутаг нэгтнүүдээ татах, боловсрол мэдлэг, гоц авьяас, ур чадварыг ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой иргэний харьяаллын бодлого явуулж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Болгар Улсын нийгмийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан хүнд, Оросын Холбооны Улсад шууд төрлийн өвөг эцэг нь орос гаралтай бол, Израил Улсад еврейчүүдийн эв нэгдлийг бэхжүүлэх, эх орондоо ирж суурьшихад нь дэмжлэг үзүүлэх, Бүгд Найрамдах Турк Улсад томоохон хөрөнгө оруулалт хийсэн эсвэл эрдмийн зэрэг

³ Х.Гэрэлчулуун. 2013 он, Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн гарын авлага. УБ. х.35

цолтой, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, урлагийн салбарт хөгжил дэвшил гаргаж чадахуйц гадаадын иргэнд, турк гаралтай гадаадын иргэнд хөнгөвчилсөн нөхцөлөөр, хатуу чанга хуультай гэгддэг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад тодорхой нөхцөл шалгуураар, мөн хуучин Зөвлөлт Холбоот Улсын нутаг дэвсгэр дээр амьдарч буй герман үндэстэнд тус тус иргэний харьяалал олгож байна.⁴

Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Бангладеш зэрэг улс нь давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй боловч Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрээр онцгой тохиолдолд давхар харьяалал олгодог байна. Гадаадад төрсөн Бельгийн Вант Улс, Бруней Даруссалам Улсын хүүхэд тэр орныхоо харьяалалтай байх нөхцөлд 18 нас хүртлээ давхар харьяалалтай байж болно. Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад гадаадад төрсөн тэдний хүүхэд давхар харьяаллаа хадгалах бөгөөд эх орондоо эргэн ирж, амьдарсан тохиолдолд тухайн улсын иргэн гэж үздэг байна. Гадаад хүнтэй суусан Кампучийн Вант Улсын иргэн эхнэр нөхрийнх нь харьяалах улс шаардаагүй нөхцөлд харьяаллаа хадгалах эрхтэй байдаг байна.

Гурав: Иргэний давхар харьяалал ба онөөгийн нөхцөл байдал

Монгол Улс төрийн бодлогын хувьд иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй улс орны ангилалд хамаардаг бөгөөд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэний харьяаллын асуудлыг дараах байдлаар зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар заалтад “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас

гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтоох”-оор заасны дагуу Харьяатын тухай 1995 оны хуулиар Монгол Улсын харьяат байх, харьяатаас гарах, харьяаллаа сэргээн тогтоолгохтой холбогдох харилцааг зохицуулж байна.

Хэдийгээр хууль тогтоомжоор иргэний давхар харьяаллыг хориглосон боловч манай улсын нэлээдгүй тооны иргэд дараах 4 үндсэн нөхцөл, шалтгааны улмаас гадаад улсын харьяалалтай болж, давхар харьяалал үүсгэж байна. Үүнд:

1. Эцэг, эх нь хоёулаа буюу эсхүл эцэг, эхийн хэн нэг Монгол Улсын иргэн боловч “хөрсний” зарчмаар иргэний харьяаллыг олгодог гадаад улсад төрсөн хүүхэд тухайн улсын харьяалалтай болдог. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Канад Улс зэрэг давхар харьяаллыг зөвшөөрдөг улсад манай улсын иргэдийн дундаас болон холимог гэр бүлээс төрсөн хүүхэд тухайн улсын хуулийн дагуу шууд иргэний харьяалалтай болж байна.

Харьяатын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эцэг, эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан үед төрсөн хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу түүний гадна төрснөөс хамаарахгүй Монгол Улсын харьяат байна”, тус хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна” гэж заасны дагуу Монгол Улсын иргэний харьяалалтай болдог.

Түүнчлэн Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол хүүхдийн иргэний харьяаллыг эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны

⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах зорилгоор хийсэн судалгааны ажлын тайлан. Х.65.

үндсэн дээр шийдвэрлэнэ” гэж заасныг гадаад улсын харьяалал авсан үндэслэлээр Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар болон хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд холимог гэр бүлээс төрсөн хүүхдийг иргэний улсын бүртгэлд бүртгэхгүй байгаа юм. Энэ заалтыг тухайн асуудлыг хариуцаж байгаа албан тушаалтнаас хамаарч хэрэгжүүлж байгаа тул энэхүү нөхцөл байдлаас үүдэн хэдэн хүүхдээ алдаж байгаа талаарх судалгаа байхгүй байна.

2. Давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсын иргэнтэй гэр бүл болсон Монгол Улсын иргэд тухайн улсын харьяалалтай болж байна. Энэ тохиолдолд харьяалалтай болж буй улсын хувьд нэгэнт давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг учраас анхдагч (төрөлх) харьяалалтай улсынхаа харьяаллаас гарсан байхыг шаарддаггүй юм.

3. Гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчилж авсан эцэг/эхийнхээ харьяалах улсын харьяат болж байна. 1999 оноос 2016 оны 05 дугаар сарын 03-ны байдлаар Монгол Улсын харьяат 262 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн ба эдгээр хүүхдүүд Монгол Улсын иргэний харьяаллаа хэвээр хадгалж байна.

(Америкийн Нэгдсэн Улс-155, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс-34, Бүгд Найрамдах Франц Улс-20, Бүгд Найрамдах Итали Улс-19, Бүгд Найрамдах Солонгос Улс, Нидерландын Вант Улс тус бүр-6, Хамтын Нөхөрлөлийн Австрали Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Бельгийн Вант Улс тус бүр-4, Канад Улс-3, Япон Улс-2, Данийн Вант Улс, Испаний Вант Улс, Бүгд Найрамдах Финланд Улс, Шведын Вант Улс, Оросын Холбооны Улс тус бүр-1).

4. Зарим улс орон гадаадад амьдарч байгаа үндэстэн нэгтнээ өөрийн улсад шилжин суурьшихад иргэнийхээ харьяаллыг хялбаршуулсан журмаар олгодог. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Грек Улс, Израил улсууд. Эдгээрийн нэгэн адил Бүгд Найрамдах Казахстан Улс хүн амынхаа казах үндэстний эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд уг журмын дагуу харьяалалтай болохыг хүссэн хүнээс өөрийн үндсэн харьяаллаасаа гарсан байхыг шаардахгүй байна.

1994 оноос 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 58298 иргэн (казах) Монголын Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяаллыг авсан бөгөөд үүнээс эргээд 1739 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон болно.

Монгол Улсын харьяатаас гарагчдын дийлэнх хувийг тусгай дундаас дээд боловсролтой иргэд эзэлж байна. 1995-2016 оны 05 дугаар сарын 03-ны байдлаар Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний харьяалалтай болсон иргэдийг оруулалгүйгээр бусад улсын иргэний харьяалалтай болох зорилгоор 1777 иргэн Монгол Улсын харьяатаас гарч, 221 гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын харьяат болсон байна. Дээрх тоон үзүүлэлтийг харьцуулан үзэхэд орц, гарц даруй 12 дахин зөрүүтэй манай улсын хувьд сөрөг үр дагавартай юм. Монгол Улсын харьяатаас гарсан 1777 иргэнээс насанд хүрээгүй хүүхэд 252, Монгол Улсын харьяат болсон 221 иргэнээс насанд хүрээгүй хүүхэд 34 байна.

Дүгнэлт

Монгол Улсын хууль тогтоомжоор давхар харьяаллыг зөвшөөрдөггүй боловч

де-факто давхар харьяалалтай болсон тохиолдлыг зохицуулах боломжгүй байна. Манай улс иргэний давхар харьяаллыг хууль зүйн үүднээс хүлээн зөвшөөрдөггүй ч гэсэн гадаад улс орнууд өөрсдийн иргэний харьяаллын хуулийг баримталснаас болоод амьдралд олон хүүхэд, олон хүн иргэний давхар харьяалалтай болж байна.

Санал

Дэлхийн улс орнууд иргэний харьяаллын асуудлыг “шилжих хөдөлгөөн”, “ухаалаг тархи”, “эдийн засгийн өсөлт”, “хүний нөөц хөгжил”, “шилжих хөдөлгөөний талаарх бодлого” гэсэн асуудлуудтай нягт уялдаа холбоотой авч үзэж, иж бүрнээр шийдэх гарц хайж байгаа өнөөгийн нөхцөлд манай улс ч гэсэн цогц бодлого нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд юуны өмнө:

1. Гадагшаа урсах шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дэлхийн жишигт хүргэх, хүний хүчин зүйл, оюуны үнэлэмжийг шинэ шатанд гаргахад чиглэгдсэн төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
2. Иргэний харьяаллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монгол Улс давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх, одоогийн үүссэн нөхцөл байдлыг арилгах цаашид давхар харьяалал үүсгэхгүй байх асуудлыг хуульд тусгаж, нэг мөр цэгцлэх;

Мөн монгол эцэг, эхээс болон холимог гэр бүлээс төрсөн хүүхэд хаана төрснөөс үл хамааран 18 нас хүртэлээ давхар харьяалалтай байхыг зөвшөөрөх, 18 насанд хүрсний дараа хоёр жилийн хугацаанд аль

нэг улсын иргэний харьяаллыг сонгох, тухайн хугацаанд аль нэг улсын иргэний харьяаллыг сонгоогүй тохиолдолд Монгол Улсын иргэний харьяаллыг алддаг байхаар зохицуулах нь зүйтэй юм. Энэ нь хүүхэд төрснөөр бий болох Монгол Улсын иргэний харьяаллаа алдахгүй байх, үндэсний аюулгүй байдал талаасаа насанд хүрсэн иргэний харьяаллын идэвхтэй зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх, бодит байдалд бий болсон иргэний харьяаллын зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх гарц гэж үзэж байна.

3. Гадаадад амьдарч суралцаж байгаа монголчуудаа эх оронд нь буцаан авчрахын тулд эдийн засаг, амьдрах орчны нөхцөл зэрэг хөшүүргийг өргөн ашиглах, ялангуяа нарийн мэргэжлээр мэргэшсэн мэргэжилтэн, урлаг, спортын авьяастнуудад урамшуулал түлхүү хэрэглэх;
4. Иргэний харьяаллын асуудлаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүртгэл, мэдээллийн тогтолцоог төгөлдөржүүлэх.

Ном зүй, ашигласан материал

I. Хууль тогтоомж, хуулиуд Монгол улсын болон олон улсын эрх зүйн эх сурвалжууд:

- 1) Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
- 2) Хүний эрхийн түгээмэл тунхаглал. НҮБ. 1948 он.
- 3) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. НҮБ. 1966 он.
- 4) Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989 он.

- 5) Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протокол. 1989 он.
- 6) Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.
- 7) Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль. 1995 он.
- 8) Монгол Улсын Харьяатын тухай хууль. 1995 он.
- 9) Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай. 2010 он.
- 10) Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 оны Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол.

II. Судалгааны зохиол монгол хэл дээрх эх сурвалжууд:

- 1) М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ.1999 он.
- 2) Д.Ганхуяг, Ш.Юмжав. Консулын эрх зүй. УБ.2012 он.
- 3) Х.Гэрэлчулуун. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ.2011 он.
- 4) Х.Гэрэлчулуун. Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн. УБ.2013 он.
- 5) С.Нарангэрэл. Англи-Орос-Монгол хууль зүйн толь. УБ.1994 он.
- 6) С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ.2008 он.
- 7) Ж.Амарсанаа, Д.Базарсад, С.Гэрэлмаа, Б.Отгонбаяр, П.Цагаан, В. Лхагвасүрэн. Хүний эрхийн нэр томъёоны товч толь. УБ. 1996 он.
- 8) Ч.Баярбат. Дэлхийн Улс орон, газар зүйн нэрсийн англи-монгол түлхүүр бичиг. УБ.2011 он.
- 9) Ж.Амарсанаа. Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон. УБ.2012 он.
- 10) О.Пунцагдаш. Иргэний харьяалал (олон улсын эрх зүйн асуудал). УБ. 2002 он.
- 11) Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх,эрх

чөлөөний байдлын тухай илтгэл. УБ.2002 он.

- 12) Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл. УБ. 2010 он.
- 13) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Судалгааны тайлангийн эмхтгэл (2010-2011). УБ. 2012 он.

Гадаад хэл дээрх эх сурвалжууд:

- 1) А.Н.Вылегжанин. “Международное право”, МГИМО. М.2010 он.
- 2) Русско-Английский юридический словарь. У.Э.Батлер. Москва.2001 он.
- 3) Xu Xianyu. Зөрчилдөөний эрх зүй. Shanghai.1999 он.
- 4) United states office of personnel management investigations service “Citizenship laws of the world” IS-1 March 2001.

III. Цахим эх сурвалжууд:

- 1) www.multiplecitizenship.com
- 2) www.google.mn
- 3) www.gia.gov.mn
- 4) www.legalinfo.mn
- 5) www.wikipedia.org
- 6) www.mongolnews.mn
- 7) www.forum.mn
- 8) www.parliament.mn
- 9) www.gov.cn
- 10) www.1212.mn (статистикийн мэдээллийн нэгдсэн сан)
- 11) www.86148.com (China’s law and regulations information)
- 12) www.baidu.com

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЗАРИМ АСУУДАЛ



Хууль сахиулахын их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Олон улсын
эрүүгийн эрх зүйн ангийн сонсогч

Б.МӨНХШҮР

Хураангуй: Монгол улсад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч эрүүл мэнд, аюулгүй байдлаа хамгаалуулах боломжийг багалгаатай хангахын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүчирхийлэгч этгээдийг даруй баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зайлшгүй хэрэглэх шаардлагатай эсэхэд хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх тус тусын үйл ажиллагаандаа хяналт шинжилгээ, мониторинг хийж ажиллах шаардлагатай байгаа тухай саналаа дэвшүүлэхийг зорилоо.

Өөрөөр хэлбэл, баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчирхийлэгч этгээдийг албадах, тусгаарлах хэрэгсэл гэдэг талаас нь¹ бус гэрч, хохирогчийг харин бодит аюул, эрсдэлт нөхцөл байдлаас яаралтай хамгаалах, зайлшгүй шаардлагатай таслан сэргийлэх арга хэмжээ байж болох талаар өөрийн

саналаа дэвшүүлэхийг зорилоо. Энэ төрлийн гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч буюу хохирогчийг сэжигтэн, яллагдагчийн нөлөөллөөс хамгаалахын тулд баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авахын ач холбогдол нь хохирогч өөрөө гэмт хэргийн гэрч нь болж, хохирогч төвтэй арга барилд тулгуурлан нотолгоо бүрдүүлдэг онцлог гэмт хэргийн хувьд яллагдагчид тохирсон эрүүгийн хариуцлагыг оногдуулах, үр дүнтэй яллах нөхцөлийг бүрдүүлж байгаагаар тодорхойлогдоно.

Түлхүүр үгс: Хүчирхийлэл, гэрч, хохирогчийн эрх, хамгаалах арга хэмжээ, баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ.

Some witness-victim protection issues of violence crimes

Abstract: The Article aims to indicate significance of taking arrest and detain the defendant of crimes such as domestic violence

¹ 2002 оны ЭБШХийн 69 дүгээр зүйлд

Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих үндэслэл нь оргон зайлж болзошгүй, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж байсан ба гэрч хохирогчийг хамгаалахын тулд эрх чөлөөг нь түр хугацаагаар хязгаарлах тухай заалт тусгагдаагүй явж ирсэн.

or human trafficking urgently and immediately. It could be one of guaranteed way during criminal procedure to protect victim's right of health and security on time. Plus, law enforcement agencies, prosecutor office and court have their own certain responsibility and should make monitoring on the activities related.

In other words, there are some suggestions which says that arrest or detain is not just compulsory measure but also effective and urgent protection measure for witness and victim which are in the situation of real danger and risk.

Significance of taking arrest and detain suspect or defendant urgently and immediately is determined by protection level of victim. The protected victim could be the key witness of the case. In that sense, the perpetrator can be accused successfully.

Key words: violence, witness, victim right, protection measure, arrest, detain.

Оршил. Монгол улсад эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий нотлох баримт болох гэрч, хохирогчийн мэдүүлэг² хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх анхаарлаа хандуулж, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо үйлчилсээр ирсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах зэрэг хүч хэрэглэсэн аргаар үйлдэгддэг гэмт хэрэгт хохирогч нь өөрөө тухайн хэргийн гол гэрч байдаг онцлогтой. Иймд хохирогчийн хохирол, хор уршгийг төлүүлэхээс гадна эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хамгаалах, дахин халдлагад өртөхөөс сэргийлэхийн тулд Гэрч хохирогчийг хамгаалах тухай

хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргасан билээ. Цаашид хууль сахиулах болон прокурор, шүүхийн байгууллага хуулийн зүйл, заалтыг амьдралд нэг мөр хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулалтын болон менежментийн тодорхой арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, ажиллах шаардлагатай байна.

Гэрч, хохирогч нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд боловч практик судалгаанаас үзэхэд тэдний аюулгүй байдлын хамгаалалт хангалтгүй байсаар байна. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэлзүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдэлд хүргэж буйг судлаачид тэмдэглэсэн байна.³

Нийгэмд хүчирхийллийн аргаар үйлдэгддэг гэмт хэргийн гэрч, хохирогчийн эрхийг баталгаатай хамгаалах нь эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна иргэд, олон нийтэд хууль зүйн мэдлэг, чадвар олгож, тэдний хандлагыг өөрчилж ажиллах, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаанаас шууд хамааралтай.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гэрч хохирогч нь бусад хүчирхийлэлийн аргаар үйлдэгдэх гэмт хэргийн гэрч, хохирогчоос илүү эмзэг, хамгаалах арга хэмжээг цаг хугацаанд нь авч чадаагүй тохиолдолд богино хугацаанд амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүй, эд хөрөнгийн хувьд ямарч эрсдэлд орох боломжтой онцлог хэрэг юм. Иймд тухайн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хэрхэн хамгаалж, аюулгүй

² Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, Судалгааны тайлан, 2010, хуудас 1.

³ Хохирогчийн эрхийн судалгааны төв, UNDP, "Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан, 2010 он

байдлыг нь хангаж чадсан эсэхээс тухайн хэргийн шийдвэрлэлт, шүүн таслах ажиллагааны үр дүн шууд хамааралтай байдаг гэдгийг өнөөдөр практикт нийтээр хүлээн зөвшөөрөөд байна.⁴

Иймд энэхүү нийтлэлээр Монгол улсын хувьд ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхийг баталгаатай хангах зорилгоор сэжигтэн, яллагдагчийг даруй баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад анхаарах асуудлыг тусган харуулж, өөрийн саналаа дэвшүүлээ.

Хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа хамгаалуулах эрх, түүний эрх зүйн орчин

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэг нь далд, нууцлагдмал аргаар үйлдэгддэг, хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай, хил дамнан үйлдэгддэг буюу цагдаа, хуулийн байгууллагад мэдээлэгддэггүй нь нэг талаар энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг мэдээлэх, зүйлчлэх, шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт хоцрогдсоноос шалтгаалж байсан боловч нөгөө талаараа хувь хүний нэр төр, үр хүүхдээ өрөвдөх, бусдыг бодох, өршөөх зэрэг Монгол хүний сэтгэхүйн онцлог, уламжлал, соёлтой ч холбоотой юм.

Мөн ихэнх тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд захиргааны журмаар торгох, баривчлах арга хэмжээ авдаг практик нь бодит байдалд хохирсон хүнээр торгуулийн мөнгийг төлүүлдэг, гэмт хэргийн хохирогчийг шийтгэх зарчмаар ажилладаг гажиг тогтолцоо нь цагдаа, шүүхийн байгууллагын дарамт, үйл

ажиллагааны шат дамжлага нь хохирогчдыг энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг мэдээлэхгүй өнгөрөхөд хүргэдэг талаар судалгаа гарчээ.⁵

Албан болон албан бус мэдээллээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол эрс өсөх хандлагатай байна. Сүүлийн зургаан жилд хүчирхийлэлд өртөж 95 хүн нас барсан гэсэн судалгаа Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд бүртгэгджээ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийсэн хууль тогтоомжийн шинэчлэлийн дараа энэ асуудлын хүрээнд дорвитой ахиц гараагүй бөгөөд хуучин арга барил хэвээр, зарим тохиолдолд илүү дордсон байж болох талаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төв болон бусад төрийн бус байгууллагуудаас тодорхой санал гаргаж байгаа аж.

“Хохирогч” хэмээх хууль зүйн талаас тодорхойлолт шаардсан энэхүү ойлголт нь зөрчил, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд болохыг манай хууль тогтоомжид ч тусгасан, эрдэмтэн, судлаачид ч мөн дээрх тодорхойлолтыг хүлээн зөвшөөрдөг.

Хохирогч нь өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, шүүхийн хэлэлцүүлэгт оролцох, шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах, аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах, мэдээллээр хангуулах эрхтэйгээс гадна шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх, өөрт илэрхий

⁴ “Хохирогчийг хамгаалах цогц зохицуулалт”, Д.Энжаргал, ХЭҮТ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хуулийн байгууллагын сургагч багш бэлтгэх сургалтын материал, 2016

⁵ 2015 оны Хүний эрхийн тайлан, <http://mongolian.mongolia.usembassy.gov/hrr-2015.html>

болсон хэргийн талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй болохыг хуулиар баталгаажуулсан.⁶ Чухамдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн хувьд хуульд заасан тэдгээр эрхээ эдлэхээс гадна үүргээ хэрэгжүүлэх боломж нь шүүх, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэл, тодруулбал гэрч, хохирогчийн зүгээс цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад итгэх итгэлээс хамаардаг болохыг НҮБ-ын баримт бичгүүдэд цохон тэмдэглэсэн байна.⁷

Мөрдөн шалгах ажиллагаанд болон шүүх хуралдааны үеэр хэргийн талаар гол мэдүүлэг өгөх гэрч, хохирогчид эрхээ эдлэх боломж олгохоос гадна түүнд бусад онцгой туслалцаа үзүүлэх нь тэдэнд хууль, шүүхийн байгууллагад итгэх итгэлийг төрүүлж, улмаар шүүн таслах ажиллагааны явцад хуулиар хүлээлгэсэн зохих үүргээ гүйцэтгэх баталгаа болж байдаг нь зүйн хэрэг. Ялангуяа хүч хэрэглэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон хүн худалдаалах, бэлгийн эрх чөлөөний эсрэг, хүүхдийн эсрэг зэрэг гэмт хэргүүдийг шалган шийдвэрлэхдээ гэрч, хохирогчид үзүүлэх туслалцааг онцгойлон авч үзэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль зэрэг Монгол Улсын хууль тогтоомжоор гэрч, хохирогчийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээг авах боломжтойгоос гадна хүчирхийлэл үйлдэгч этгээдийг эрхийг хязгаарлах, албадан сургалтад хамруулах зэрэг олон арга хэмжээ авах бололцоотойгоор

тусгасан. Гэсэн хэдий ч процессын, эдийн засгийн боломж, ажилтны ур чадвар, мөн хүчирхийлэгч этгээдийн зүгээс үзүүлэх эсэргүүцэл, зүй бус нөлөөлөл, дарамт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж бодит амьдралд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг нь судалгаагаар тогтоогдсон.⁸

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны сүүлийн жилүүдийн тайлан, мэдээнээс харахад, гэмт хэргийн улмаас хохирсон гэрч, хохирогчийг хамгаалах талаар шүүхийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тайлан, анализ судалгаа байхгүй, зөвхөн гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, учирсан хохирлыг гэмтлийн зэрэг, мөнгөн дүнгээр илэрхийлсэн хохирлын тоо хэмжээ л харагддаг.

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2013-2015 оны бүтэн жилийн тайлан мэдээг шүүж үзэхэд, жилээс жилд сэжигтнийг баривчилсан, цагдан хорьсон хүний тоо өссөн. Үүний дотор баривчлах арга хэмжээ авагдсан болон захиргааны журмаар баривчлагдсан, торгуулсан эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна.⁹ Мөн согтуугаар болон давтан гэмт хэрэг үйлдэгчдийн тоо өссөн үзүүлэлттэй гарчээ.

Гэмт хэргийн төрлийн хувьд, 2014 онтой харьцуулахад 2015 онд хүнд, хүндэвтэр гэмтэл авсан хүний тоо 4,2-5,5%-иар буурсан боловч хөнгөн гэмтэл авсан хүн 6,2%-иар өссөн бөгөөд гэмт хэргийн улмаас нийт 59 тэр бум 796 сая 149 мянган төгрөгний хохирол учирснаас иргэд 14 тэрбум 291 сая 804 мянган төгрөгний хохирол учирсан байгааг тайланд дурдсан байна.¹⁰ Эдгээр тооны ард ямар шалтгаан,

⁶ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002, 46 дугаар зүйл, <http://www.legalinfo.mn/law/details/59>, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016, 7.2 дугаар зүйл.

⁷ Эрүүгийн эрх зүйн хүрээнд болон эрүүгийн процесс дахь хохирогчийн байдлын талаархи зөвлөмж, 1985, Recommendation on the position of the victim in the framework of Criminal law and criminal procedure, 1985, http://ec.europa.eu/civiljustice/comp_crime_victim/docs/council_eur_rec_85_11_en.pdf

⁸ Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, Судалгааны тайлан, 2010, хуудас 22.

⁹ Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан, 2015, <http://www.judcouncil.mn/tailan2015.html>

¹⁰ Мөн тэнд.

нөхцөлийн улмаас ийм байдал үүсээд байна вэ гэдэг асуултын хариуг шүүхийн тайлан, мэдээнээс харах боломжгүй байна.

“Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” УИХ-ын 2015 оны 23 дугаартай тогтоол гарч, Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан “Шүүх, хууль сахиулах байгууллагуудын өгөгдөл солилцох дундын нэгдсэн сан бүрдүүлэх тухай” тушаал батлагдсан. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Хууль зүйн яамтай хамтран цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын дунд нэгдсэн сүлжээний орчин үүсгэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг дамжуулах, хүлээн авах боломжтой шүүхийн бүртгэлийн системийн анхан шатны хувилбарыг хийж, 2016 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд нэвтрүүлэхээр ажилласан нь¹¹ чухал ач холбогдолтой юм.

Ер нь Монгол Улсын Цагдаагийн байгууллага 2007 оноос эхлэн зөрчил, гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллагын мэдээллийн сан бүрдүүлж, статистик мэдээлэл гаргаж ирснийг эс тооцвол шүүх, прокурор зэрэг хуулийн байгууллагуудад гэрч, хохирогч судлал, тэднийг хамгаалахтай холбоотой дорвитой судалгаа, мэдээ тайлан, мэдээллийн нэгдсэн сан үгүйлэгдэж байна.

Харин хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, гадаадын зарим орны, тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамнаас жил бүр Монгол Улсад хүний эрх хэрхэн хэрэгжиж байгааг ялангуяа гэрч, хохирогчийг хамгаалах

асуудал ямар түвшинд байгааг ажиглаж, дүгнэлт хийж иржээ.¹²

Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хууль зүйн үндэслэл

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Гэрч, хохирогчыг дарамтлах, сүрдүүлэх, амь нас эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол мөрдөгчийн саналыг үндэслэн прокурор сэжигтнийг баривчлах саналыг шүүхэд даруй хүргүүлнэ” гэж тусгаж өгсөн байна. Харин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сэжигтэнд хэрэглэх боломжгүй байхаар хуульчилж зохицуулсан байна. Бодит байдалд, тухайлбал гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн хохирогч нь сэжигтэн этгээдийн талаар бүрэн мэдээлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж, ял сонсгох хүртэл хамгаалагдах боломж хомс хэвээр байна.

Хэрэв хохирогч нь хүчирхийлэгч этгээд болон түүний ах дүү, хамаатан садангаас байнгын дарамт, нөлөөн дор байснаас хэрэг бүрэн шийдэгдэж чадахгүй, удааширч, өөрөөр хэлбэл ял сонсгож, яллагдагчаар татаж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хүртэл хохирогч цааш хохирсоор байх эрсдэлд орохыг үгүйсгэхгүй.

Харин 2017 оны 05 дугаар сард батлагдсан Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Сэжигтнийг баривчлах” тухай үндэслэлд 31.4 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт “...хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол”, 1.4 дэх хэсэгт “дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол”, 1.5-д “...гэрч,

¹¹ Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан, 2015, хуудас 31, <http://www.judcouncil.mn/tailan2015.html>

¹² Хүний эрхийн тайлан, 2015, <http://mongolian.mongolia.usembassy.gov/hrr-2015.html>

хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол” гэсэн заалтуудыг тус тус оруулж өгсөн нь өнөөгийн бодит байдалд нийцсэн гэж үзэж байна. Мөн дээрх хуулийн 13.10 дугаар зүйлд “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл”-д “...хохирогч, гэрч, шинжээч, шүүгч, прокурор, мөрдөгч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа” зэрэг үндэслэлүүдийг оруулсан нь гэрч, хохирогчийг хамгаалах баталгаа болохуйц заалт болсон гэж дүгнэж байна.

Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн холбогдогчид зайлшгүй авах талаарх олон улсын стандарт, хэм хэмжээ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн дотор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо ихэссэн болохыг судлаачид, төрийн бус байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсээр байна.¹³ Үүнтэй холбоотойгоор хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгч этгээдийн үйлдлийг таслан зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Нэг талаас олон улсын түвшинд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэглэгддэг албадлагын арга хэмжээний эцсийн арга хэмжээ байх ёстой гэдэг чиг хандлага жишиг болон тогтсоны зэрэгцээ хүч

хэрэглэсэн гэмт хэрэг, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн үед цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг mandatory arrest буюу заавал авах таслан сэргийлэх арга хэмжээ гэж үздэг байна.¹⁴ Тухайлбал, АНУ-д шүүгдэгчийг гадуур байлгах асуудлыг шийдэхдээ хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг харгалзан шийдвэрлэдэг.¹⁵ ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хуулийн 112 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч нь бэлгийн хүчирхийллийн болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, оргон зайлсан, эсхүл нуугдаж байсан болох нь тогтоогдсон, нотлох баримтыг цуглуулахад саад учруулах, хуйвалдах, устгах, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэрч, шинжээч болон бусдад зүй бусаар нөлөөлөх өндөр эрсдэлтэй бөгөөд тэдгээрээс улбаалан хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болзошгүй, мөн онц хүнд гэмт хэрэгт шийтгэгдэж байсан, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй эрсдэлтэй байгаа талаар тодорхой фактууд тогтоогдсон бол гэмт этгээдийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болдог байна.¹⁶

1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгээс батлан гаргасан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль зүйн үндсэн зарчмын тухай Тунхаглал”¹⁷-д “Хохирогч шүүхэд хандах, шүүхээр хурдан шуурхай, шударга шүүлгэх, хохирлоо арилгуулах, нөхөн төлбөр, туслалцаа авах эрхтэй” болохыг

¹⁴ Domestic violence and Mandatroy arrest laws, Journal of Criminal law and Criminology, volume 98. <http://scholarlycommons.law.northwestern.edu/cgi/viewcontent.cgi?article=7284&context=jclc>.

¹⁵ Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, Судалгааны тайлан, 2010, хуудас 49.

¹⁶ German Code of Criminal procedure (Strafprozessordnung)

¹⁷ Тунхаглалын 5 дугаар зүйл.

¹³ Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдог боллоо, Б.Бадамгарав, <http://eagle.mn/tr/11359>

заасан. Түүнчлэн “Хохирогчийн тав тухыг алдагдуулахгүй байх, шаардлагатай үед хувийн амьдралыг нь хамгаалах, тэднийг болон тэдний гэр бүлийн гишүүд, мөн гэрчүүдийг айлган сүрдүүлэх, өс хонзон авахаас хамгаалах арга хэмжээ авна”¹⁸ гэсэн байна.

Мөн НҮБ-аас батлан гаргасан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-ийн 25 дугаар зүйлд “Хохирогсод туслах, хамгаалах” тухай, “Эрүүгийн хууль, шүүн таслах ажиллагааны хүрээнд хохирогчийн эдлэх эрхийн тухай зөвлөмж”¹⁹-д эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны тогтолцоо нь “Хэрэв шаардлагатай байвал, ...гэмт хэрэгтэн хохирогч болон түүний гэр бүлийг айлган сүрдүүлэх, өс хонзон авах эрсдэлээс үр дүнтэй хамгаалах арга хэмжээ авах ёстой”, “зарим тохиолдолд хохирогчийн хүндрэл бэрхшээлийг багасгах биш харин нэмэгдүүлэх хандлагатай байсан”, “хохирогчийн хэрэгцээг хангаж, ашиг сонирхлыг нь баталгаажуулахад эрүүгийн шүүн таслах ажиллагааны үүрэг байх ёстой”, “эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хохирогчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ялангуяа гэрчийг хамтран ажиллах явдлыг нэмэгдүүлэх нь чухал” болохыг тэмдэглэжээ.

Дээрх “Эрүүгийн хууль, шүүн таслах ажиллагааны хүрээнд хохирогчийн эдлэх эрхийн тухай зөвлөмж”-д мөн бэлгийн эрх чөлөөний эсрэг, хүүхэд, тахир дутуу хүмүүс, цөөнхийн бүлгийн эсрэг, хүн худалдаалах зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч, гэрчид эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед болон шүүхийн шатанд онцгой туслалцаа

шаардлагатай байж болохыг тэмдэглээд шүүх ажиллагааг шуурхай, шударга явуулах чадамжтай байхаас гадна оролцогчдын аюулгүй байдлыг хангах, эрх эрх, чөлөөг нь хамгаалах чадамжтай шүүхийг бүрдүүлэхийг улс гүрнүүдэд зөвлөмж болгосон²⁰ байдаг.

Дээр өгүүлсэнээс дүгнэхэд, баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагаа нь зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр явагддаг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцгой төрөл мөн. Тийм учраас энэ ажиллагаанд тавигдах хяналт шинжилгээ, анализ, дүгнэлтийг шүүх өөрөө эсвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх шүүхийн судалгаа, мэдээлэл сургалтын хүрээлэн хийх нь зүйтэй. Энэ нь нэг талаас сэжигтэн, яллагдагчийг дур зоргоор баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаас урьдчилан сэргийлэх боловч нөгөө талаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах зэрэг онцлог гэмт хэргийн хувьд гэрч, хохирогчийг цаг алдалгүй хамгаалахад чухал нөлөө үзүүлж болзошгүй юм.

Дүгнэлт

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, үйлдэхээр завдаж буй этгээдийг заавал баривчилдаг, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх, энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч, гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, гаргасан гомдлоо буцаан авсан эсэхийг үл харгалзан шүүхээр хэргийг шийдвэрлэж, хүчирхийлэгч этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гарцаагүй болохыг олон нийтэд ойлгуулах нь нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

¹⁸ Тунхаглалын 6 (d) дугаар зүйл.

¹⁹ “Эрүүгийн хууль, шүүн таслах ажиллагааны хүрээнд хохирогчийн эдлэх эрхийн тухай зөвлөмж, № R (85) 11, Оршил хэсгийн 2,3,4,16 дугаар зүйл.

²⁰ Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, Судалгааны тайлан, 2010, хуудас 45.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, гэрчийг нэн түрүүнд шуурхай хамгаалах буюу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авсанаар хохирогч өөрөө энэ хэргийн гол гэрч нь болж, хүчирхийлэгч этгээдийг гарцаагүй нотолгоогоор яллаж, тохирсон хариуцлагыг оногдуулах ач холбогдолтой. Гомдол, мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлсэн цагаас эхлэн хохирогчид аюултай нөхцөл байдал бүрэлдэх учраас хүчирхийлэгч этгээдийг тусгаарлах буюу баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зайлшгүй, түргэн шуурхай авах шаардлагатай байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн онцлог нь нууц далд аргаар үйлдэгддэг, байнга давтагдаж, даамжирдаг онцлогтой нэг удаагийн үйлдэл бус, байнга үргэлжилдэг учраас хохирогч дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг.

Өөрөөр хэлбэл, хохирогчийн амь нас, эрүүл мэнд эрсдэлд өртөх өндөр магадлалтай байгаа тохиолдолд түүнийг хамгаалах хууль зүйн төрөл бүрийн арга хэрэгсэл байгаа хэдий ч юуны түрүүнд хүчирхийлэгч этгээдийг баривчлах, цагдан хорих замаар хамгаалах нь тохиромжтой.

Дэлхийн улс орнуудад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг шийдвэрлэдэг тусгайлсан шүүх, прокурорын байгууллага, энэ чиглэлээр дагнан мэргэшсэн өмгөөлөгч, цагдаагийн байгууллагын ажилтнууд, сэтгэл зүйч, мэргэжлийн зөвлөгөө өгдөг, сургадаг газрууд, олноор бий болон ажилласаар байна. Зарим оронд гэмт этгээд нь сургалт, эмчилгээ болон бусад тусгай хөтөлбөрт хамрагдах талаар шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд түүний биелэлтэд хяналт, мониторинг хийх үүрэг бүхий тусгай бүтэц нь дагнсан шүүхийнхээ дэргэд ажиллаж байна.²¹ Нөгөө

талаас, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь хохирогч өөрөө хүсээгүй буюу гомдол гаргаагүй байсан ч гэмт этгээдийн гэм бурууг шүүх тогтоож, хариуцлага хүлээлгэдэг байх ёстой. Практикт, ихэнх тохиолдолд хүчирхийлэгч этгээд хохирогчийн зүгээс гаргасан гомдлыг эргүүлэн авахуулах, эвлэрсэн мэт харагдуулах оролдлогуудыг хийдэг. Гэтэл хохирогчийг айлган сүрдүүлж, дарамтлах нь харин ч хуулиар хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.

Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч байгаа шүүхийн практик ажиллагаанд хяналт шинжилгээ, мониторинг хийж ажилласнаар таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх шалгуур үзүүлэлтийг нарийн тогтоож, хууль сахиулах, прокурорын байгууллагатай хамтран тодорхой үр дүнд хүрч ажиллах, улмаар шүүн таслах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэх учиртай. Ийм учраас дараах саналыг дэвшүүлж байна.

Санал

1. Хүчирхийллийн давтамжид анхаарах; Зөрчлийн хэрэгт шийтгэл хүлээж байсан эсэх талаарх мэдээлэл, лавлагаа, өмнө нь хүчирхийллийн гэмт хэрэгт цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авч байсан эсэх болон ял шийтгэлийн байдал. Үүнд тухайн гэр бүлд өмнө нь хүчирхийлэл үйлдэгдэж байсан эсэх, түүндээ ял шийтгэл эдэлж байсан эсэх тухай мэдээллээс гадна хүчирхийлэл үйлдэгч этгээд бусдын бие махбодод гэмтэл учруулах хэрэг үйлдэж, шийтгэгдэж байсан эсэх талаар мэдээлэл нь тухайн этгээдийг асуудлыг шийдэхдээ хүч хэрэглэх замаар шийддэг гэдгийг тодорхойлж өгөх нэг хүчин зүйл болно.

toringResults from a Randomized Trial at the BronxMisdemeanor Domestic Violence Court, p1,<http://www.courtinnovation.org/sites/default/files/battererprogrameffectiveness.pdf>

²¹ Testing the Effectivenessof Batterer Programs andJudicial Moni-

2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үед хохирогчийн биед ямар нэг гэмтэл учирсан эсэх талаар баримтыг нягтлахдаа хохирогч нь заавал эмнэлгийн тусламж авч байсан эсэх, түүнийг нотлох өөр ямар нэг бичиг баримт байгаа эсэх, эсхүл шүүх эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон байхыг шаардахгүй байх;

3. Гэр бүл цуцлах талаар нэхэмжлэл гаргасан эсэх, хүүхдийг асран хамгаалах эрх хэнд шилжиж байгааг анхаарах;

Энэ тохиолдолд хүчирхийлэгч этгээдийн зан араншин, үйлдэл нь улам түрэмгий болох магадлалтай байдаг.

4. Хүчирхийлэл үйлдэхдээ буу, зэвсэг хэрэглэдэг эсэх;

Тухайн этгээдийн буу, зэвсэг, ашиглах зөвшөөрлийг хүчингүй болгосон эсэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

5. Хохирогч талаас хүчирхийлэгчийг баривчлуулахгүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахгүй байх, гомдолгүй гэх талаар хүсэлт гаргасан тохиолдолд няхуур хандах;

Ихэнх тохиолдолд хүчирхийлэгч айлган сүрдүүлж, дарамт, үүсгэснээс хохирогч нь тийнхүү хүсэлт гаргах боломжтой байдаг.

6. Нэг нотлох баримт нь нөгөөгөө дэмжиж байгаа эсэхийг анхаарах;

7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хэргийн сэжигтэн, яллагдагч хэрэг үйлдэх үедээ согтуу байсан, уур нь хүрсэн, эсхүл гэм буруугаа ойлгож гэмшсэн зэрэг нь түүнийг хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл


болохгүй байхаар зохицуулах;

8. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн үед баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах талаарх шүүх хуралдааныг шаардлагатай тохиолдолд хаалттай хийх замаар гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад анхаарах, шаардлагатай бол хүчирхийлэгч этгээдийн шууд өөдөөс харах боломжгүйгээр, эсвэл түүний эзгүйд буюу танхимаас гаргаж, гэрч хохирогчийг оролцуулах, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, хүүхэд, өндөр настан бол видео хуралдаанд оролцуулах, видео шүүх хуралдааны гэрч, хохирогчийн зүс царай, дууны өнгийг хүчирхийлэгч этгээдэд танигдах боломжгүйгээр хувиргах, өөрчлөх зэргээр техник, технологийг ашиглаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахад анхаардаг байх нь зүйтэй байна.

9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэчилсэн хуулиар яллагдагчаар татах ажиллагаа хийгдэх хүртэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүйгээр зохицуулагдсаныг анхаарах нь зүйтэй болов уу.

Эдгээр саналын зарим нь “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуульд тусгагдсан Хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам, Аюулын зэргийн үнэлгээ, Нөхцөл байдлын үнэлгээ зэрэгт тусгагдсан байгаа боловч сэжигтэнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийг гаргахад төдийлэн нөлөөлөхгүй байна.

ДҮРВЭГЧ ГЭХ “ГАДНЫ” ХҮМҮҮС



МАЙКЛ ИГНАТЬЕВ

Майкл Игнатъев нь Унгар Улсын Будапешт дэх Төв Европын Их сургуулийн захирал бөгөөд Канадын Либераль намын тэргүүнээр ажиллаж байв. Тэрээр түүхч мэргэжилтэй. Кэмбриж, Оксфорд, Харвард, Торонтогийн их сургуулиудад багшилж байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны улмаас хүмүүс үй олноороо нутгаа орхин гарахаас аргагүй болсон юм. Үүний дараагаар дүрвэгсэд мөрдлөг хавчлагад өртөнө гэдгээ үндэслэлтэйгээр нотолж чадаж байвал аль нэг улсын хамгаалалтыг авах эрхтэй болж, эрх зүйн болон ёс суртахууны статус олж авах болжээ. НҮБ-ын Дүрвэгсдийн тухай 1951 оны Конвенцоор олон улсын эрх зүйд дүрвэгсэд ёс суртахууны хувьд бие хүн гэдэг цоо шинэ статустай болов.

Жаран жилийн дараа ч гэсэн олон улсын эрх зүйн энэхүү ойлголтод өөрчлөлт ороогүй хэвээр байна. Гэвч дүрвэгсдийг бусдын адил эрхтэй, ёс суртахууны зүй ёсны шаардлагатай хувь хүмүүс гэж үзэхийн оронд “түрэмгийлэгч гадныхан” гэж үздэг шинэ “зүйрлэл” ардчилсан улс төрд орж иржээ. Үүний нэг илрэлийг Зүүн Европын орнуудын цөөн хэдэн жишээнээс харж болно. Тухайлбал, 2015 оны 9 дүгээр сард Чех, Словакийн улс төрчид, анагаахын мэргэжилтнүүдтэйгээ нийлж байгаад дүрвэгсдийг өвчин авчрах эрсдэлтэй хэмээгээд хилээ хаацгаах саналыг дэмжсэн

юм. Мэдээж хэрэг энэ нь бодитой бус үндэслэл байв. Өөрөөр хэлбэл зүгээр л улс төрчдийн хэрэглэдэг бусдыг харлуулах нэг башир аргыг ашиглан дүрвэгсдийг бүхэлд нь улс оронд учруулах аюул гэж харуулах гэсэн оролдлого төдий ядруухан зүйрлэл байсан юм. Үүний улмаас Чех, Словакийн аль нь ч 1951 оны конвенцид заасан холбогдох эрхийг дүрвэгсдэд эдлүүлэхийг зөвшөөрөөгүй ажээ.

Дүрвэгсэд “Христын соёл иргэншил”-д аюул учруулж буй тул хилээ хаах ёстой хэмээн мөн тэр жилийн намар Унгарын Ерөнхий Сайд Виктор Орбан мэдэгдэв. Ийм зүйрлэлийг аль эртнээс л хэрэглэдэг байлаа. Унгар бол Европын “Христийн шашинт харуул” гэх зүйрлэл өнгөрсөн зууны туршид тус улсын үндэсний үзлийн нэг тулгуур болж байв. Ноён Орбан иймэрхүү зүйрлэл хэрэглэхдээ тун гаргууд нэгэн бөгөөд улс төрийн нөлөө, эрх мэдлээ уран үг хэллэг, зүйрлэлийг сурамгай ашигласныхаа хүчээр бий болгосон юм. Тэрбээр түүхийг биологийн үүднээс тайлбарлаж, Лалын шашны итгэл үнэмшлийг өвчинтэй адилтгаж

ярьдаг нэгэн. Угтаа VIII зуунаас хойш Европт оршин тогтнож, түүний түүхийн нэгэн хэсэг болсон Лалын шашинг “түрэмгийлэгч гадныхан” гэж дахин нэрлэжээ.

Иймэрхүү зүйрлэлийг улс төрд хэрэглээд ирмэгц ядарсан зүдэрсэн нэгэнд үргэлж аюултай байдлаар тусдаг байна. Европын популист, тэр дундаа барууны чиглэлийн улс төрчид дээрх зүйрлэлийг буруугаар ашиглаж бодит байдлыг гайхалтайгаар гуйвуулж чаджээ. Үймээн самуун, бөмбөгдөлт, айх аюулаас болж эх орноосоо дүрвэж буй нэгнийг “түрэмгийлэгч хүчин” болгож харагдуулав. Лалын улс бүлэглэлийн террористуудаас зугтаж Ирак, Сири улсаас дүрвэж буй хүмүүсийг терроризмын аюул занал болгон дүрслэх болжээ. Хохирогчдийг ингэж зүйрлэх болсноор улс орнууд болон иргэдийн өмнө нь байх л ёстой зүйл гэж үздэг байсан эрх зүйн болон хүмүүнлэгийн үүрэг хариуцлага яваандаа мартагдаж, хаяад явж болдог хүнд ачаатай ижил зүйл болон хувирчээ. Хохирогчид эрхээ шаардах нь нэг бол айлган сүрдүүлж буй хэрэг, аль эсвэл бидний өгөөмөр сэтгэлийг ашиглах гэсэн оролдлого гэж үзэх болсон байна.

Дүрвэгсдийг “түрэмгийлэгч гадныхан” гэж үзсэний улс төрийн үр дагавар нь тэр даруй гарч эхэлсэн юм. Түр байрлуулах лагерь байгуулах, баривчлан саатуулах, хүчээр нутаг буцаах, өргөст тор, хүчит гэрэлтүүлэгч, харуул манаа болон үнэрч ноход зэрэг зүйлс бүгд л ар араасаа шил даран гарч ирцгээв. Ядарсан нэгэнд өгөөмөр сэтгэлээр, хүн ёсоор хандах гэсэн олон нийтийн сэтгэл оршиж байдаг улс төрийн орон зайг нураах зорилгоор барууны чиглэлийн популист улс төрчид зарим зүүний улс төрчидтэй хамтдаа эдгээр зүйрлэлийг зохиож байна. Хохирогчдыг энэрч хайрлах орон зай хаа сайгүй

хумигдсаар. Америк өмнө нь үй олноор орж ирж буй дүрвэгсэд ба төрөлх нутгаа хүчээр орхиоос аргагүйд хүрсэн цагаачдад өгөөмөр хандаж байгаа хэмээн бусдад гайхуулдаг орон байв. Харин Сирийн иргэний дайны улмаас бараг 10 сая хүн гэр орноо орхин явахаас аргагүйд хүрэх үед энэхүү уламжлал олон нийтийн дэмжлэгийг авах хүч, бодлогын ач холбогдлоо нэгэнт алджээ. 2012 оноос хойш АНУ дөнгөж Сирийн 15 мянган дүрвэгсдийг хүлээн авсан юм. Өдгөө бүр шинээр сонгогдсон ерөнхийлөгч нь лалын шашинтай орнуудаас ямар ч дүрвэгч хүлээж авахгүй гэсэн зохицуулалт хийхийг оролдож байна.

Популист улс төрчид болон тэдний ард буй үзэл санааны эх баригчид энэхүү өгөөмөр, энэрэнгүй сэтгэлийн орон зайг нураасанд буруутай боловч либераль сэхээтнүүдийн үл тоомсорлодог олонхийн айдсыг бид л анхаарч байна гэж тэд хэлдэг. Эрх ямбатай цөөн хэдэн хүмүүсийн огт ойшоохгүй хаясан зүйлд ардчиллын дуу хоолойг хүргэдэг хэмээн популистууд үргэлж сайрхсаар ирсэн юм.

Айдас хүйдэс нөмөрсөн цаг үед ардчиллын энэхүү үндэслэл тодорхой хэмжээнд үнэний хувьтай юм. Сан Бернардино, Орландо, Брюссель, Парис, Истанбулд болсон террорист халдлага түгшүүртэй нөхцөл байдлыг бий болгосон учир популист улс төрчид дүрвэгсэд, цагаачдыг “гадныхан” болгон харагдуулахад хялбар байв. Айх айдсаасаа болж хүмүүс бодит баримтыг үл хэрэгсэж эхэлдэг байна. Бодит баримт дүрвэгсэд болон террористуудын хооронд ялгаа байгаа гэдгийг хэлж өгөхөө больдог ажээ. Парис, Брюссельд болсон халдлагыг дүрвэгсэд бус Европт төрж өссөн залуучууд үйлдсэн байдаг. Орландод болсон халдлагыг мөн л Америкт төрж өссөн тус улсын иргэн

үйлдсэн юм. Айдаст нэгэнт автсан л бол хүмүүс халдлага, заналхийллийг уугуул гаралтай юу, эсвэл дүрвэгч үйлдсэн үү гэдгийг ялгахыг хүсдэггүй байна. Харин хоёуланг нь өөрсдийн биш мэт санахын сацуу тухайн халдлага ямар нэг шашинтай холбоотой байвал буруутгахад хялбар шалтаг болж өгдөг ажээ. Ингээд л тулгарч буй аюулыг тусгаарлах, устгах, эсвэл хүчирхийллээр л үгүй хийх нь зөв гэж үзэцгээнэ. Энэ л жинхэнэ улс төрийн зүйрлэлийн аймшигт хүч чадал юм.

Энэ хандлагыг өөрчилж чадах зүйл байгаа бол тэр нь юу вэ? Дүрвэгсэд бол хамгаалагдаж, хүндлэл хүртэх эрхтэй хохирогчид гэдэг дүр зургийг либераль болон дэвшилтэт улс төр хэрхэн эргүүлж авчрах вэ? Энэхүү үзэл бодлын тэмцэлд яаж ялах вэ?

Ёс суртахууны зарчмын хувьд либераль улс төр гэдэг нь бүх нийтийг хамарсан улс төр юм. Ёс суртахууны хувьд универсалист буюу бүх нийтийг хамарсан байна гэдэг нь чухамдаа “гадныхан” гэсэн ойлголт байхгүй улс төрийг хэлэх юм. Либерал үзэлд зөвхөн “бид” гэсэн ойлголт байх ба бүх хүн бидэн шиг хүндлэл хүлээж, адил тэгш эрх эдлэх ёстой гэж үздэг. Либерализмын ёс суртахууны гол хүч ба түүний түүхийн явцад олж авсан үндсэн амжилт бол арьсны өнгө, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсээр нь ялгаварлах бүх хэлбэрийг буруушаасаар ирсэн явдал юм. Либерализмын ёс суртахуун үндсэндээ бусдаас ялгаатай байх гэдэг зүйл өөрөө ёс суртахууны хувьд ямар ч хамаагүй зүйл гэж номлодог. Иймээс улс төрийн гол субъект бол хүн буюу универсаль хувь хүн юм. Либерализмын хамгийн итгэл найдвар тавьдаг ойлголтоор бол хүн ерөөсөө хүн гэдэг утгаараа л бие биетэйгээ холбоотой байдаг ба дүрвэгсэдэд эдлэх ёстой эрхийг нь

өгч байгаа нь бид бол нэг л хүн төрөлхтөн гэдгээ зөвшөөрч буй хэрэг юм.

1945 оны дараа бий болсон олон улсын эрх зүйн маш нарийн зохион байгуулалт бүхий тогтолцооны нэг хэсэг болох Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон Дүрвэгсдийн тухай Конвенцоор хүн төрөлхтний эв санааны нэгдлийн либераль универсаль хувилбарын эрх зүйн суурийг нь тавьж өгсөн юм. Нэгдсэн Үндэстний Байгууллага болон төрийн бус байгууллага, сайн дурын байгууллагуудаас цалинжин ажиллаж байгаа либераль мэргэжлүүд болох хүний эрхийн хуульч, профессор, олон улсын шинжээчид энэ бүх нийтийг хамарсан үзэл баримтлалыг түгээхээр ажиллаж байна. Бүх нийтийг хамарсан үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх гэсэн оролдлого хүнд давааг давсаар ирсэн юм. Улс орнууд энэхүү хүчин чармайлтын эсрэг сөрөн зогсож, хүчирхийлэл, зүй бус явдал амь бөхтэй хэвээр ч үл гүйцэлдэх тэмүүлэлд хүрэх гэсэн тэмцэл үргэлжилсээр. Бүгдийг хамарсан үнэт зүйлсийг дэлхийн бүх улс орнуудаар хүндэтгэн сахиулах энэхүү үл гүйцэлдэх зорилго яагаад ийм хүндрэл бэрхшээлтэй тулгарна вэ? Учир нь энэ зорилго хүний мөн чанарын тухай чин сэтгэлийн тэмүүлэл агуулж байдаг явдал юм. Өөрөөр хэлбэл дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүн бие биенийхээ чадварыг нь биш юм гэхэд онцлог, бодит боломжийг нь хүлээн зөвшөөрч, харилцан ойлгож, өөрийгөө хүндэтгэдэг шиг бусдыг хүндлээсэй гэхийг хүсэх явдал юм.

Сирид болж буй аймшигтай иргэний дайны улмаас бий болсон өнөөгийн дүрвэгсдийн зовлон зүдгүүр өөрөө хүний эрхийн төлөөх хувьсгал, дүрвэгсдийг хамгаалах үзэл санааг өдөөсөн энэхүү универсаль итгэл үнэмшлийг сориод

зогсохгүй хамгийн хүнд асуудлын нэг болж хувирав. Европ бүхэлдээ өгөөмөр, энэрэнгүй сэтгэлээр асуудалд анхандаа хандсан ч иргэдийн олонхийн үзэл бодол бусдыг ялгаварлах улс төрийн уур амьсгал руу удалгүй шилжжээ. Дүрвэгсдийн хөл тасардаггүй Германд хүртэл олонхийн үзэл бодол нэг жилийн дотор эргэж эхэлж байна.

Айдаст тулгуурласан популист улс төр, хүмүүсийг “гадныхан” гэж ялгадаг зүйрлэлийн башир арга олон нийтийн санаа бодлыг өөрчилсөн байж болох ч энэ нь бүхэлдээ авралгүй гэсэн үг биш юм. Харин олон нийт яагаад ятгалгад ийм амархан оров, эдгээр зүйрлэл яагаад хүчээ алдахгүй байгаа вэ, яагаад бусдыг ялгаварлах үзэл өгөөмөр сэтгэлийг ийм амархан ялав гэх асуултууд гарч ирж байгаа юм.

Либерализмын мандан бадралын үед либералиуд бусдад “зүй зохистой үг хэллэг, ойлголт”-ыг хэтэрхий их тулгасныг олон нийт эсэргүүцэж гарч ирсэн тул популизм амжилт олсон гэж популистууд өөрсдөө тайлбарладаг. Харин дүрвэгсдийг шашин, арьсны өнгөөр нь ялгаварлан гадуурхах популист үзэл хандлага, хана, хориг саад бий болгохыг зарим талаар эсэргүүцэж энэхүү хэлэлцүүлэгт либералиуд оролцох болсон юм.

Европ болоод хаа сайгүй арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах явдал байсаар байна. Айдас хүйдэс, жигшэл зэвүүцэл байгаа үед арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл хүчтэй байх нь ойлгомжтой учир дүрвэгсдийн эсрэг чиглэсэн популизм гаарчээ. Асуудлын гол нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлдээ биш юм. 2015 оны 9 дүгээр сард галт тэрэгний зогсоол дээр туйлдаж цөхөрсөн хүмүүст дулаан хөнжил, ус авчирч өгсөн олон мянган европчуудын өгөөмөр сэтгэлийг тэгвэл бид юу гэж тайлбарлах вэ? Тэд зөвхөн өөрсдийн

айдас, хардлага сэрдлэгээ даван туулаад зогсохгүй бусдыг өөртөө халуун дулаанаар хүлээж авах Ангела Меркелийн сэтгэлийг дэмжсэн юм. Тэд дүрвэгсдээс айсангүй, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлд ч автаагүй. Гэвч жилийн дотор дүрвэгсдийг зогсоо зайгүй хүлээж авах хэрэгтэй гэсэн бодлогоос татгалзах хэрэгтэй гэдэг дүгнэлтэд дуртай дургүй хүрчээ. Хүмүүс яагаад ингэж бодол санаагаа өөрчлөв?

Германы хувьд Үндсэн хуулиараа Дүрвэгсдийн тухай Конвенцийг дотоодын хуулийн нэгэн адил хүлээн зөвшөөрдөг тул асуудал үүсчээ. Конвенцид зааснаар тус баримт бичигт нэгдэн орсон улс мөрдлөг хавчлагад өртөнө гэсэн баттай үндэслэлээ гаргаж ирсэн бүх хүнд орогнох эрх олгох ёстой байдаг. Хэдийгээр тус улс нь дүрвэгчийн мэдүүлэг хангалттай үндэслэлтэй эсэхийг үнэлж дүгнэх, аль эсвэл дурдсан үндэслэл нь хуурамч байвал мэдүүлгийг хүлээж авахаас татгалзах бүрэн эрхтэй. Гэхдээ л баримт, нотолгоо сайтар бүрдүүлсэн хүмүүсийг хүлээн авахаас өөр аргагүй. Хэдэн арваараа, эсвэл зуу зуугаараа ирж буй орогнол хүсэгчдийг хүлээн авах нь байж болох л зүйл. Харин ганцхан жилийн дотор зуу зуун мянган ийм хүсэлт хүлээн авах нь захиргааны хувьд хүндрэл дагуулахаас илүүтэй өөр хүндрэл үүсгэж байна. Гол нь орогнох эрх олгох гэх мэт бүх нийтээр хүлээсэн үүрэг гэдэгт хэнд түрүүлж эрх олгох тухай асуудлаар баримтлах бодитой зарчим болоод гаргаж буй хүсэлтийг хязгаарлах, эсвэл багасгах тухай ямар ч зохицуулалт байдаггүй ажээ. Хэрэв аль нэг улсын хил дээр мөрдлөг хавчлагад өртөнө гэх баттай үндэслэл бүхий сая хүн нэгэн зэрэг гараад ирвэл Герман шиг олон улсын эрх зүйн зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжийнхоо нэг хэсэг болгон соёрхон баталсан улс бүх нийтээр дагаж

мөрдөх орогнох эрхийн хуулийг заавал биелүүлэх хууль журам бус улс төрийн нэгэн байж болох үйлдэл гэж харахаас өөр аргагүй юм.

Түүхэн учир шалтгаан болоод хүн ёсны үүднээс өгөөмөр сэтгэлтэй германчууд бусдад орогнох эрх олгохыг чухал зүйл гэж үздэг ч энэхүү бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн үүрэг хариуцлага тус улсын хилээ хамгаалах үндсэн зорилттой зөрчилдөж байгааг ойлгож эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл хууль эрх зүйн түвшинд авч үзвэл улс эх орны бүрэн бүтэн байдал ба бүх нийтээр дагаж мөрдөх үүрэг хариуцлагын хооронд зөрчил гарч иржээ. Тус улсын Канцлераас авахуулаад өгөөмөр сэтгэлтэй германчууд хүртэл улс орны бүрэн бүтэн байдлыг хангаснаар энэхүү зөрчлийг шийдвэрлэнэ гэх дүгнэлтэд хүрэхээс аргагүй байдалд хүрчээ. Герман лс орогнол хүсэгчдийг хүлээн авсан хэвээр байгаа ч хэнд нь орогнол олгох нь илүү чухал байгаа гэдэг зарчмыг баримтлан хүлээж авах тоогоо бууруулж, нутаг буцаах тоог нэмжээ.

Дүрвэгсдийн хямралын асуудал зөвхөн улсын бүрэн бүтэн байдал ба дүрвэгсдийг хүлээн авах тухай бүх нийтээр дагаж мөрдөх үүрэг хариуцлагын хооронд зөрчил бий болгоод зогсоогүй юм. Энэ асуудал мөн либераль универсализмын ёс суртахууны үндсэн номлолыг ч авч үзэх болж байна. Энэхүү асуултыг Герман болоод Европын бусад орны энгийн гэгдэх бүхий л анги давхаргын төлөөлөл болсон цалингийн янз бүрийн түвшинтэй жирийн сонгогчид, улс төрд идэвхтэй оролцдоггүй, үзэл санааны аль нэг талыг баримталдаггүй хүмүүс, мэргэжлийн хувьд хүний эрхийн салбар, иргэний эрх чөлөөний төлөөх шүүхийн процесст оролцдоггүй болоод иргэний нийгэм гэх салбарт ч ажилладаггүй хүмүүс тавих болов. Либераль улс төр бусдыг

хүлээн зөвшөөрөх замаар өөртөө нэгтгэх гэж чармайж байхад жирийн хүний хувьд хүн бусдыг өөрсдийн нэгэн адил бодгал, нийтлэг нэг л онцлогтой гэж харна гэдэг тун бэрх зүйл юм.

Эдгээр ойлголтыг шалгаад үзвэл өргүй хоосон зүйл байвал яах вэ? Хэрэв хүмүүс өөр газраас ирсэн нэгнийг хармагц ялгааг нь эхэлж хараад, адил төстэй зүйлийг нь олж харахгүй бол яах билээ? Хэрэв шууд л “бидний эсрэг тэд”, эсвэл “манай иргэд ба гадны хүмүүс” гэвэл яах уу? Тэгвэл орогнолын тухай буюу манай иргэн ба гадныхан гэдэг энэхүү ялгааг либерал улс төр ойлгодоггүй гэсэн дүгнэлтэд аваачих тул өөрийгөө хүнд байдалд оруулахаас өөр аргагүй юм.

Өөрөөр хэлбэл өгөөмөр сэтгэлийг цаашид хадгалж үлдэнэ гэдэг асуудал айдас хүйдсээс үүдэлтэй улс төр, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг эсэргүүцэхээс илүү хүндрэлтэй тулгарч байна. Энэ асуудал чухамдаа хүний эрхийн үндсэн асуудал ба олон улсын эрх зүйд оршиж байгаа юм. Ардчилсан улсын сонгогч гадны хүний өмнө ч гэсэн бүх нийтийг хамарсан үүрэг хариуцлага хүлээдэг гэсэн үндсэн ойлголтыг өгөөмөр сэтгэлийн тухай либераль улс төр номолдог. Гэтэл жирийн сонгогчид гадны хүнийг биш нутаг нэгтнээ давууд авч үздэг бол яах вэ? Гадны иргэдээс иргэдээ давуу гэж авч үздэггүй бөгөөд хэн иргэншил олж авах эрхтэй гэдгийг тодорхойлдог төрийн эрхийг үл ойшоодог либераль улс төр хэзээ ч айдас хүйдэс, хуваагдал дээр тулгуурласан популист улс төрийн эсрэг амжилт олохгүй юм.

Айдас, түгшүүртэй байгаа ардчилсан орны ард иргэдэд улс төрийн ямар үг хэллэг илүү утга учиртай санагдаж, тэдний сэтгэлийг татаж чадах вэ? Тэгвэл хүний уг чанар болох өгөөмөр, нинжин сэтгэлийг хэрхэн хөдөлгөх вэ?

Өгөөмөр сэтгэл бол “бэлэг” гэсэн утгад хамаардаг бол үүрэг, хариуцлага “зүйл эрх” гэсэн утгад хамаардаг гэдгийг юуны түрүүнд анхаарах хэрэгтэй юм. Марсель Мосс болон Ричард Титмусс нар бэлгийн тухай социологи болон антропологийн ойлголтыг бидэнд танилцуулсан билээ. Бэлгийн тухай тэдний ойлголтоор бол сонгогчийн хувьд орогнох эрхийн тухай асуудал эрхийн тухай бус бэлгийн тухай ойлголтод хамаарах юм. Яагаад тийм гэж?

Эрх бүх нийтийг хамардаг шинжтэй бол бэлэг өгөх нь тодорхой хэсэг хүнд л зориулагдсан байдаг. Хүн бүрт өгсөн бэлэг бол бэлэг гэсэн утга агуулахаа болино. Эрх өөрөө эрх тэгш байдлыг бий болгохыг зорьдог бол бэлэг өгөх нь ялгаварлах шинжтэй байдаг. Эрх нь заавал биелүүлэх шинжтэй байхад бэлэг нь эсрэгээр буюу тодорхой нөхцөлд л байдаг зүйл. Эгэл жирийн хүмүүсийн үнэ цэнийн системд гадны хүмүүсийн өмнө хүлээх үүрэг гэдэг зүйл заавал бус буюу бэлгийн шинжтэй байдаг. Орогнох эрхийг гадны хүнд өгнө гэдэг нь сайн санааны үүднээс хийж буй үйлдэл буюу ховор зүйлийг олгож буй хэрэг болж байна. Нэг ёсондоо орогнох эрх бэлэглэж байгаа иргэн ба орогнох эрхийг бэлгэнд авч байгаа гадны хүн хоёрын харилцаа гэж орогнолыг ойлгож болно. Хэдийгээр үүнийг төр эрхлэн явуулж, оролцож байгаа ч гэсэн энэ бүгд тусгайлсан, хувь хүн хоорондын харилцаа юм.

Миний бодлоор ийм ойлголт л олон нийтийн дунд түгээмэл үлдсэн учраас орогнол хүсэх эрхийг ингэж хараад байгаа юм. Ийм учраас л цөхөрлөө барсан гадны хүмүүсийн өмнө хуулиар баталгаажсан бүх нийтээр хүлээх ёстой үүрэг гэсэн ойлголт байдаггүй. Үүний оронд тодорхой хэсэг хүмүүст тоотой барааг тарааж өгч байгаа мэт хариуцлагын сайн дурын ухамсар

төдийхөн зүйл л байдаг гэсэн үг. Энэ ойлголтоор бэлэг гэдэг нь зочломтгой зантай адил тэр болгон олдоод байдаг элбэг дэлбэг зүйл биш. Ховор зүйл нэгэнт үгүй болбол дахиж өгөх бэлэг байхгүй гэсэн үг. Гэтэл олон улсын эрх зүйд энэхүү хариуцлагыг хязгаарлана гэсэн зүйл байдаггүй.

Бүх нийтээр дагаж мөрдөх тодорхой нэг хязгааргүй үүрэг хариуцлага жирийн хүмүүсийн дургүйцлийг төрүүлж байдаг. Учир нь энэ бүхэн амьдралаас холоос гадна төр л гагцхүү орогнол хэр хэмжээнд байх ёстойг тодорхойлох эрхтэйгээс гадна энэхүү эрх, үүрэг гэдэг зүйл бэлэг өгч байгаа иргэнийг давууд авч үздэггүй. Орогнох эрхийг бэлгийн харилцаа гэж ойлгосон үед орогнол хүсэгч уугуул иргэний бүрэн эрхийн хүрээнд байдаг давуу эрхийг түүний ёс суртахуунтай нь цуг зөвшөөрч байна гэсэн үг. Гэтэл орогнол хүсэгчид эдлэх ёстой эрхээ эдэлж байна гэж үзэх юм бол уугуул иргэдтэй нэг л адил эрх ямба эдэлж, иргэний эрхтэй болж байна хэмээн уугуул иргэд дургүйцдэг байна.

Иймээс жирийн хүмүүсийн хувьд гадны хүн нь бэлгийг баяр талархалтайгаар хүлээн авч, энэхүү бэлгийг өгч байгаа иргэний давуу эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой болж байна. Тэгвэл бэлгийг дараах нөхцөлтэйгөөр шилжүүлж өгдөг болж таарч байна. “Иргэн надад та За гэж хэлбэл би танд За гэж хэлнэ.” Өөрөөр хэлбэл орогнол нь иргэний тодорхойлсон нөхцөлөөр бий болох ёстой ажээ.

За гэдэг зүйлд юу багтах тухай асуудал мөн гадны хүн шинэ нийгэмд нэгдэж орох асуудал мэдээж маргааны том сэдэв юм. Амьдарч буй нийгэмдээ За гэж хэлэхдээ иргэн чухам юу мэдэрч байгаа нь маргаантай учраас асуудал гэсэн үг. Үнэнч зан өнөөгийн чөлөөт нийгмийн үзэл санаатай төдийлөн сайн зохицдоггүй. Орогнол олгох зөвшөөрөл буюу бэлэг авсан

гадны хүмүүс ядаж л шинэ нийгмийнхээ хуулийг даган мөрдөж, хэлийг нь сурч, ажилд орж, хүлээн авсан нийгэмдээ хувь нэмэр оруулж эхлэх хэрэгтэй гэсэн хүлээлт уугуул иргэдэд байдаг. Харин эдгээр гадны хүмүүс дээрх хүлээлтэд хүрч чадахгүй бол уугуул иргэдэд тусыг усаар хариулж байна гэх бодол төрдөг ажээ.

Дүрвэгсэд, орогнол хүсэгчдийн тухай өгөөмөр, хүнлэг бодлогыг хамгаалахыг зоригсод энэхүү жирийн бодол гэдэг зүйл утгагүй санагдаж магадгүй байх. Гэвч үнэхээр л орогнол хүсэгчдийн төлөөх ардчилсан зөвшилцлийг популист дайралтаас авч үлдье гэвэл дээр дурдсан жирийн хүмүүсийн үзэл бодлыг авч үзэхээс өөр аргагүй юм. Орогнох эрхийг хүсэгчид өөрсдөө эрхтэй гэдэг зүйлийг огт мартаж болохгүй. Ингэснээр холбогдох хууль тогтоомж, олон нийтийн санаа бодолд олноороо хүч түрэн орж ирж буй “орогнох эрх бол бэлэг” гэсэн өрөөсгөл ойлголтыг няцааж чадах юм. Иргэд заримд нь өгч, заримаас нь харамлах замаар бэлгээ өөрсдөө тараахгүй л бол орогнох эрхийг бусдад өгөх сонирхолгүй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл бэлэг хүлээж авч байгаа нэгэн өөрийг нь тосч буй нийгэм, иргэдэд заавал За гэж хэлэхийг шаардана гэсэн үг болж таарч байна.

Хэрэв та над шиг хүний эрхийн тухай бусдад зааж, хүний эрхийг хамгаалдаг бол барууны нийгэм өнөөгийн нөхцөл байдал, үнэн бодит байдал, ёс суртахууны үнэт зүйлсийн хувьд хямарч байгаа гэдгийг сайтар мэдэрч байгаа байх. Хүний эрхийн хамгаалагч, дэмжигчидтэй уулзаж ярилцахад энэ хямрал бол хэрэгжилт, нийцлийн хямрал гэдэг. Гэтэл үнэн хэрэгтээ хямрал үүнээс ч илүү гүнзгий байгаа юм. Терроризм, цагаачлалын урсгалын улмаас улс орнууд бүх нийтээр хүлээсэн

үүргийг биелүүлж байгаа эсэх, уг үүргийн хэрэгжилтийг хэн нэгэн шаардаж байгаа талаарх асуудал өөрөө ардчилсан орнууд дотроо дайралтад өртөж байна. Хэрэв орогнол хүсэгчдэд таатай нөхцөл байдлыг дахиж бий болгоё гэвэл бид арьсны өнгөөр ялгаварлан гадуурхагч, популист улс төрийг дэмжиж байгаа хүмүүсийг үл ойшоохын оронд иргэдтэйгээ чин сэтгэлээсээ ярилцах хэрэгтэй байна. Манай нийгэмд арьсны өнгөөр ялгаварлан гадуурхдаггүй, хамгийн хүнд нөхцөл байдалд байгаа гадныханд иргэншлээ бэлэглэх улс төрийг дэмждэг, өгөөмөр сэтгэл, эсвэл гэнэн итгэмтгий зангаас л болж байна гэдэг хүмүүсийг үл ойшоодог, зүй ёсны, үр өгөөж бүхий хилийн хяналтыг шаарддаг сонгогчид манай нийгэмд байгаа. Хэдийгээр ийм зүйл хүний эрхийн салбарт ажиллаж буй ихэнх хүмүүсийн хувьд тэрслүү зүйл байж болох ч ийм итгэл найдвар төрүүлсэн бодлого байхгүйн улмаас л орогнох эрхийг бусдад өгөх орон зайг үгүй хийж, олон нийтийн санаа бодлыг айдас, ялгаварлах чиглэл рүү аваачсан юм.

Энэ бүхнийг зөв замд нь оруулна гэдэг томоохон сорилт юм. Үй түмээрээ цагаачлал хийж буй тэр дундаа нутгаа орхиод нүүхээс аргагүйд хүрч байгаа хүмүүсийн асуудал бидний ирээдүйтэй холбоотой гэдэг нь тов тодорхой. Тэгш бус ертөнцөд цагаачлал нь хөгжингүй орнуудад байгаа ядуурлын асуудлыг шийдвэрлэх, мөн боломж гарцыг нээх хувь хүний сонголтын асуудал хэвээр байх юм. Иргэн, гадны хүний дунд буй хилийг баглан хамгаалахын сацуу гадны хүнд өгөөмөр сэтгэлээр иргэншил бэлэглэх тухай асуудал чөлөөт ардчиллын хувьд шийдвэрлэх сорилт байх юм. Бид дүрвэгчдийн хүсэлтийг эдлэх ёстой эрх гэдэг утгаар хүлээж авах учиртай ч амьд гарахын төлөө зогсоо зайгүй дүрвэж

буй иргэдэд хандсан олон улсын шинэ зохицуулалттай болох шаардлагатай байна. Чингэснээр бид тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэж эхлэх юм. Цаашлаад цагаачлалын тогтмолжсон, сайтар зохион байгуулсан, зүй ёсны тогтолцооний төлөөх иргэдийн дэмжлэгийг бид дахин бий болгох хэрэгтэй байна. Хэрэв бид зүй ёс ба хяналт

хоёрын зөв тэнцвэрийг олж чадвал улсын хил, улсын бүрэн эрхт байдал, дүрвэгсдэд хандах өгөөмөр сэтгэлээ дахин олж авах юм.

*Social Research сэтгүүлийн 2017 оны №1
Орчуулсан ХЭҮК-ын Захиргаа, хамтын
ажиллаганы хэлтсийн референт Т.Ариунаа*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗОЧНЫ ЯРИА



**Ж.ХУНАН: “ШУДАРГА ЁС,
ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖ НЬ
ХУУЛЬЧИЙН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН
САЛШГҮЙ ХЭСЭГ”**

*“Хүний эрх” сэтгүүл энэ удаагийн
зочноороо Монголын Хуульчдын холбооны
тэргүүн Жаргалсайханы Хунанг
урьж ярилцлаа.*

- Хүний эрхийн салбарт төсөл хөтөлбөр удирдаад цөөнгүй жил ажилласан хүний хувьд Та хүний эрхийн нөхцөл байдал ямархуу түвшинд байна гэж боддог вэ?

- Мэдээж төгс хангагдсан гэвэл худлаа болно. Хүний эрхийн нөхцөл байдал зарим талаараа маш боломжийн сайжирч байгаа. Засгийн газар ч анхааралдаа авч, тууштай, ахицтай явж байгаа гэж хардаг. Зарим нэг асуудал тухайн хүмүүсийн хүмүүжил, боловсрол, амьжиргааны түвшин, газар зүйн онцлогоос хамаараад хангагдахгүй орхигдох байдал анзаарагддаг. Гэхдээ аль болох дээд зэргээр хангахын төлөө Монгол Улсын Засгийн газар, бусад эрх мэдлийн байгууллагууд маш их хичээж ажиллаж байгаа гэж боддог. Улсаас мөнгө хөрөнгийг ч зарцуулдаг болсон гэж харж байна. Сүүлийн үед энэ чиглэлээр төсөв нэмэх, хүний эрхийг хангах бусад бүтцүүдийг бий болгож байна. Энэ нь хөгжиж байна, үйл явц өрнөж байна, цаашдаа улам сайжирна гэсэн найдвар төрүүлж, тэгж ч харагдаж байгаа.

- **НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийг та удирдаж хэрэгжүүлсэн. Хүний эрхийн Үндэсний**

Комисс болон бусад байгууллагатай хамтран жил бүр хөдөө орон нутагт ажилладаг байсан. Төслийн үр дүн хэр байсан бэ? Та нар юуг өөрчилж чадсан бол?

- Энэ төсөл 2007 оноос эхэлсэн, төслийн үр дүнд Хууль зүйн туслалцааны төвүүдийг улсын хэмжээнд байгуулсан, Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль батлагдсан. Анх энэ нь хөтөлбөр байсан. Монгол Улсын Үндсэн хуульд “Хүн бүр хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гээд заачихсан, өөрөөр хэлбэл хууль зүйн туслалцаа авах нь хүний үндсэн эрхэд хамаардаг. Тэгээд бие даасан хууль, бүтэцтэй болсон. Яахав, нэг талаараа зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа нь хязгаарлагдмал юм. Нэг дор бүх асуудлыг шийдэх боломжгүй, үе шаттайгаар явна. Бусад төлбөрийн чадваргүй иргэдэд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хуульчдын холбоо хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцаж байна. Энэ нь эрүүгийн хэргийн төлбөрийн чадваргүй гэрч, хохирогч, иргэн, захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчид юм.

Дараагийн нэг чухал үр дүн гэвэл энэ төслийн дэмжлэгтэйгээр Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон явдал. Уг конвенцид нэгдэж орохын ач холбогдлыг сурталчлан таниулж, уриалсан, ойлгуулж таниулах ажлыг зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн гэж хардаг. Түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан нь төслийн үр дүн гэж болно. Эдгээр нь дээрх төслийн томоохон үр дүн гэж харж байгаа.

Эдгээрээс гадна иргэдийг чадавхжуулах, хууль зүйн мэдлэг, мэдээлэл, анхан шатны зөвлөгөө өгөх замаар өөрсдөө эрхийнхээ төлөө тэмцэх, дуугарах чадвартай болгох, амьжиргаагаа аваад явах, өөрийгөө хөгжүүлэх боломжтой юм гэдгийг сурталчилсны үр дүнд иргэдийн эрх зүйн чадавхийг дээшлүүлэх санаачлагын эхлэлийг тавьсан. Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Нээлттэй нийгэм форум хамтран “Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулах ажлыг эхлүүлээд байгаа.

- Орон нутагт ажиллах үед өөрчилж амжаагүй, өөрчлөх юмсан гэсэн ямар асуудал үлдсэн бол?

- Ер нь бол ахиц гарсан. Хүний эрхийн Үндэсний Комисс 21 аймагт төлөөлөгчтэй болсон. Энэ бол том дэвшил. Орон нутагт нэг зүйл анзаарагддаг, хүн ам цөөн учраас хүний эрхийг хангах ажил, зөрчлүүдийг бүртгэх, шалгах, засч залруулах нь дутмаг. Цөөхүүлээ тул бие биесээ таньдаг болоод ч тэр үү, “миний эрх зөрчигдлөө” гээд хандаад байдаггүй. Түүнээс гадна манай улс дүрэм, журам, хууль батлахдаа ихэвчлэн нийслэл хотын нөхцөл байдал, орчинд нийцүүлчихдэг, түүнийг нь орон нутагт сахиулж, дагаж мөрдүүлэхэд хүндрэлтэй. Жишээлбэл,

суманд хоолны газарт заавал паалантай жорлон байх ёстой гэсэн шаардлагыг биелүүлэх нөхцөл байхгүй. Зам дагуух гуанзундад стандартыг дагаж мөрдүүлэх хэцүү. Энэ мэтчлэн зүйлийг зохицуулмаар санагддаг. Өөрөөр хэлбэл, ялгамжтайгаар журамлаж өгөх шаардлагатай. Хууль хүн бүрт ижил тэгш үйлчилж, орон зайгаас үл хамааран хэрэгжих ёстой байтал 2000-3000 хүнтэй суманд мөрдөгдөх нөхцөл юу билээ, хэрэгцээ, шаардлага бас юу билээ. Ингээд хууль нь өөрөө хүний эрхийг зөрчих нөхцлийг бий болгоод байгаа ч юм шиг байдал ажиглагддаг.

- Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгчөөр сонгогдоод удаагүй ч Та Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч ажиллах, хүний эрхийн сургалт явуулах ажлыг эхлүүлэхээр зорьжээ. Хуульч бүр хүний эрхийг хамгаалагч байх ёстой гэдэг үүднээс ийн нухацтай хандав уу?

- Хуульч бүр хүний эрхийг хамгаалагч. Хүний эрхийг хамгаалагч бүр хуульч байх албагүй. Хүний эрхийг хамгаалагч нь нийгмийн сайн сайхны төлөө санаа зовдог, хүн бүрийн эрхийн төлөө арга хэмжээ авдаг, зөрчил гажуудлыг арилгахын төлөө дуу хоолойгоо хүргэдэг. Хуульч хүн хууль зүйн хувьд илүү гаргалгааг хийдэг. Номыг нь сурсан учраас илүү өргөн хүрээнд шийдвэрлэх гарц, гаргалгааг нь хийдэг болов уу. Шударга үнэн, хүний эрх, нийгмийн сайн сайхан, эдгээр үнэт зүйл, зарчмуудыг эрхэмлэж явах шаардлагатай.

Хуульчдын холбоо нь хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага юм. Өнөөдөр бид ямар хуульч бэлтгэх, хуульч хүн ямар мэдлэг, чадвартай байх ёстой, ямар чиг үүрэг хэрэгжүүлэх, нийгмийн өмнө ямар үүрэг хүлээсэн бэ гэдгийг сурталчлан таниулж, хуульчдыг байнга хөгжүүлж байх үүрэг

бүхий байгууллага юм. Хэдийгээр төрийн бус байгууллага боловчиг төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгодог, давтан сургалтын асуудлыг хариуцдаг. Өөрөөр хэлбэл, сургууль төгсөөд ажилд ороод орхичих биш, байнгын сургалт, байнгын хөгжүүлэлт хийж, чадавхийг дээшлүүлж байна.

Хуульчийн мэргэжлийн дүрэм гэж бий. Хуульч хүний амьдрал, хувь заяаг шийддэг учраас өндөр ёс зүйтэй байх ёстой. Шударга үнэнийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаагаар хэмждэг. Дараагийн нэг ажил нь хуульч, эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиудыг магадлан итгэмжлэх, хуульч болгоход ямар мэдлэг эзэмшсэн байх вэ? Сургуулиудад ямар хичээл заах ёстой юм, хуулийн ямар мэдлэгийг олгох, ямар хүрээнд сургалт явуулах ёстой вэ, ерөнхийдөө сургалтын хөтөлбөрийн агуулгыг хөндөнө гэсэн үг. Зөвхөн Монголд ч биш, дэлхийн бусад улс оронд ч Хуульчдын холбоо магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцдаг юм байна лээ.

Өөр нэг чиг үүрэг нь тодорхой хууль тогтоомжид анализ хийгээд хууль тогтоох байгууллагад санал хүргүүлдэг. Шүүхийн ерөнхий зөвлөлд нэг гишүүнийг санал болгодог. Манайх одоогоор 5400 орчим гишүүнтэй. Холбоо маань байгуулагдаад удаагүй, 4 жил, одоо 5 дахь жилийнхээ нүүрийг үзэх гэж байна. Байх ёстой юу гэвэл байх ёстой байгууллага.

Үйл ажиллагаандаа шударга ёс, хүний эрхийг дээдлэх зарчмуудыг баримталдаг. Тиймээс хүний эрхийн сургалтыг явуулах зайлшгүй шаардлагатай. Иймээс мэргэшсэн байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч ажиллах нь зүй ёсны хэрэг. Зөвхөн хуульчид ч биш, эрх зүйч бэлтгэдэг бүх сургуулиудад

хүний эрхийн сургалтыг түлхүү оруулах хэрэгтэй. Сургалтын хөтөлбөрт ХЭҮК-оос боловсруулсан сургалтын хөтөлбөрийг оруулчих юм бол хуульчид маань сургалтад тогтмол хамрагдах, мэдлэгээ дээшлүүлэх боломжтой болно.

- Хуульчдын холбооны шинэ удирдлагаас гишүүд нь ямар нэг хүлээлттэй байж магадгүй юм. Жишээлбэл, хуульч сонгон шалгаруулах хугацааг өөрчлөх, гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг бууруулах зэрэг асуудлыг тавьж болох. Танай гишүүнчлэлийн хураамж нэлээд өндөр санагдсан?

- Одоогоор хуульчийн сонгон шалгаруулалтын шалгалтыг жилд нэг удаа авна гэсэн хуулийн зохицуулалттай байгаа. Гэхдээ өөрчилнө гэж үзэж байгаа. Чанартай, бэлтгэгдсэн хуульчдыг бэлтгэхийн тулд ирээдүйн үр дагаврыг харж, шалгалт чанартай, шударга байх ёстой. Давтамжийн хувьд асуудал гардаг. Шалгалтад унасан хүн бүтэн жил хүлээх шаардлага гардаг. Хугацаа их чухал. Цаг бол алт гэдэг үүднээс үүнийг уян хатан болгож зохицуулах шаардлага байгаа. Ирэх жилээс холбогдох өөрчлөлтүүдийг оруулах санал явуулна гэсэн бодолтой байгаа. Гишүүнчлэлийн татварын хувьд хэмжээг бууруулах санал тавих эрх нь гишүүдэд нээлттэй байгаа. Янз бүрээр ярьдаг. Хуульчдын холбоо маань өөрөө удирдах ёсны байгууллага. Хэмжээг нь өөрсдөө хэлэлцээд тогтоодог. Тэр зарчмаараа санал оруулж болно. Хуульчид маань өөрсдөө шийддэг. Зөвлөл, их хурлаар оруулж шийдвэр гарна.

- Танай холбооны гадаад харилцаа нэлээд хөгжих байх хэлтэй устай ерөнхийлөгчтэй болсны хувьд?

- Мэдээж гадаад харилцаа чухал. Энэ чиглэлээр түлхүү ажиллана. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц

чадварлаг хуульчдыг бэлтгэх, тухайн улсын хууль тогтоомжийг судлах, гадны мэргэжилтэнгүүдийг урьж ирүүлж сургалт явуулна. Одоогоор манай холбоо Олон Улсын Барын холбооний гишүүн. Бүс нутгийн хэмжээнд хэд хэдэн бүтцэд гишүүнээр орсон, хэд хэдэн улстай хамтын ажиллагаатай. Сая Франц улсад Монголын шүүгчийн өмсгөлийг олон улсын үзэсгэлэнд оролцуулж олон улсад сурталчилсан.

- Хуульчдын холбоонд ирэхээс өмнө таны эхлүүлж ажил хэрэг болгосон нэг ажлын талаар асуулгүй болохгүй нь. E-Khutuch.mn цахим хуудас буюу эрх зүйн туслалцаа үзүүлдэг бүх байгууллагын холбоос, нэгдсэн лавлах, сүлжээг үүсгэн байгуулж байсан?

- Хууль зүй, дотоод хэргийн яаманд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулах ажлын хүрээнд цахим эрх зүйн хөтөчийн бүтцийг бий болгох юм. Өөрөөр хэлбэл, ухаалаг төхөөрөмжийн тусламжтайгаар иргэн бүр өөрт шаардлагатай хууль зүйн анхан шатны зөвлөгөөг авах боломж нээгдэнэ гэсэн үг. Хууль, тогтоомж, дүрэм журмыг өөр өөрөөр тайлбарлаад л, бүрдүүлэх материалын жагсаалтыг дур мэдэн тогтоодог зэргээс иргэд мухардалд ордог, хүндрэл учирдаг. Үүнийг цэгцлэх зорилгоор эрх зүйн хөтөчийн тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Жишээлбэл, иргэн Б газар худалдан аваад нэр шилжүүлэхийн тулд хуульд заасны дагуу материал бүрдүүлээ гэхэд аймаг, нийслэлд өөр зүйл шаарддаг байж болохгүй. Мэдээллийн зөрүүг арилгах үүднээс багц мэдээллийг бэлтгээд хөтөчид байршуулна. Түүнийг нь иргэн татаж аваад газрын албанд хандах, холбогдох газарт “Энэ танай боловсруулсан мэдээлэл, үүний дагуу явж байна” гээд хандахад асуудал

үүсэхгүй. Түүнээс гадна мэдээллийн нэгдсэн зөвлөгөө, сургалт, сурталчилгааны багц мэдээлэл байх юм. Хүн бүр өөрт зориулсан мэдээллээ авах боломжтой. Зөвхөн иргэд ч биш, төрийн албан хаагчдад гарын авлага болно.

- Та хүний эрхийн салбарт цөөнгүй жил ажилласан хүн. Энэ салбарт ажиллах болсон шалтгаан юу байв? Хувь заяаны тохиол уу, аль эсвэл сонголт уу? Шантрах үе тохиож байв уу?

- Шантарна, буцаж няцна гэсэн ойлголт байхгүй. Хуульч бол нийгмийн эмч. Нийгмийн харилцаанд болж бүтэхгүй байгааг олж харж, шалтгааныг оношлодог. Хүний амьдралын харилцааг зохицуулсан хэм хэмжээг дагаж мөрдүүлэх, зөв чиглүүлэх, хүн бүрт эдлэх эрхийг нь эдлүүлэх, сайн сайхан нийгмийг бий болгохын төлөө зүтгэж явдаг. Хүний эрхийг хамгаалагчдыг бурхан хардаг гэж боддог. Цаанаасаа ажил үйлс нь бүтдэг. Мэдээж амар биш, дарамт, заналхийлэл дунд ажилладаг. Гэхдээ бурхантай.

- Тийм үү? Ямар бурхан байдаг юм?

- (инээв.) ...Шударга ёсны Фемида гээд бурхан. Та мэдэж байгаа байх. Өмгөөлөгчид янз бүрийн заналхийлэлд өртдөг. Прокурор, шүүгч нар элс цацуулна. Манайхан чинь сонирхолтой юманд итгэдэг. Соёл, уламжлал нь өөр болохоор ч юм уу их мухар сүсэгтэй. Гэхдээ хуульчид тоодоггүй. Айж шантраад, бусдын нөлөөнд автаад сөрөг шийдвэр гаргах тохиолдол байх ёсгүй шүү.

- Хүний эрхийг хамгаалагч, хуульч болсноор та ямар амжилт гаргасан бол, үүнийг л өөрчилсөн гэх зүйлээсээ хуваалцвал?

- Энэ талаар бодож үзээгүй юм байна. Яахав, эргээд харах юм бол нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийн төлөө ихэнх ажил нь чиглэсэн байна. Ялангуяа хэн ч

төлбөрийн чадваргүй байдлаасаа болоод эрхээ эдлэхгүй байх, хохирох зүйл байж болохгүй. Хамгийн гол нь зөв тогтолцоог бүрдүүлэхийн төлөө л ажиллаж байна. Үр дүн гарна гэж итгэж байгаа шүү.

- Хүний эрхийг хамгаалагчид өөрсдийгөө дөвийлгөж, сурталчлаад байдаггүй онцлогтой. Гэхдээ та хүрсэн үр дүнгээсээ сонирхуулбал зүгээр юм?

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг Монгол Улсад багтуулахад кампанит ажил зохион байгуулахад, зам хааж байгаад гудамжинд тайван жагсаал хийх зэрэг ажлыг хийж байсан. Байгууллагууд, ялангуяа төрийн байгууллагууд руу нэвтрэх налуу зам байхгүй, тодорхой хугацааны дараа яамдууд налуу замтай болж, өөрчлөлт гарч байгааг харах сайхан байсан шүү.

- Хуульч болохыг багаасаа л хүсдэг байсан гэж та хэлсэн. Энэ мэргэжлийг сонгоход хэн нөлөөлөв?

- Манай ээж хуульч мэргэжилтэй. Шүүгч учраас хэрэг уншина. Ажил дээр нь очно, ажиллаж байгааг ажиглана. Яагаад тэр хүн хэрэг үйлдэв? Юу нь болохгүй байсан юм бол? гэх зэргээр боддог байсан... Анх МУИС-ын Хууль зүйн сургуульд элссэн.

Тэндээсээ Унгарт очиж суралцан төгссөн. Шалгалт шүүлэг бүгдийг өөрөө өгөөд л, тухайн үед чадах, үгүй нь эргэлзээтэй. Хууль зүйн яаманд төрийн албан хаагчийн шалгалт өгч, ажилд орж байлаа. Хуульчийн шалгалтыг бол бүр 2 удаа өгч байж тэнцсэн. Бусдын жишгээр л явж ирсэн.

- Ээж нь мэргэжлийн үүднээс хэр зааж зөвлөдөг вэ? Магтуулж байв уу?

- Магтахгүй ээ. Мэргэжлийн зөвлөгөө өгч байсан удаа бол бий.

- Та одоо л нэг хуульч боллоо доо гэж өөрийгөө хэдийд үнэлэв?

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэг төслийг дуусгаад, дараагийн төслийг эхлүүлээд 2013 онд “За нэг хуульчийн дүр төрхтэй, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой болсон байна” гэдгийг мэдэрч байсан. Хэлний хувьд, мэдлэг, туршлагын хувьд хуульчаас өөр ямар ч ажил хийж чадахгүй юм байна гэж бодож байлаа.

- Цаг зав гаргаж ярилцсанд баярлалаа.

*Ярилцсан: З.Бадмаараг
Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын референт*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ

НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ АСУУДЛААРХ ТУСГАЙ ИЛТГЭГЧ, НОЁН ЖОН Х. НОКС МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТЭЭС

НҮБ-ын Хүний эрхийн Шинжээч ноён Жон Х.Нокс 2017 оны есдүгээр сарын 19-нөөс 27-ны өдрийг хүртэл Монгол Улсад анхны албан ёсны айлчлалаа хийж, 9 дүгээр сарын 27-ны өдөр манай улсад хийсэн үнэлгээнийхээ урьдчилсан дүгнэлтийг хэвлэлийхэнд танилцуулсан уулзалтын тэмдэглэлийг бүрэн эхээр нь толилуулж байна.



Сайн байцгаана уу,

Есдүгээр сарын 19-нөөс эхлэн Монгол Улсад ажиллаж, хийсэн үнэлгээнийхээ урьдчилсан дүгнэлтээс өнөөдөр та бүхэнд танилцуулах гэж байгаадаа таатай байна.

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс Хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгчийн маань хувьд хүний эрхийн хэм хэмжээг аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд хэрэгжүүлэх үйлсийг дэмжин дэлгэрүүлэх эрх надад олгосон билээ. Иймээс миний хүлээдэг эрх үүргүүдийн нэг хэсэг нь улс орнуудад айлчилж, хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаар хэлэлцэн ярилцаж тухайн улс орнуудад бий болсон сайн туршлага, хүний эрх, хүрээлэн буй орчныг хамгаалах явцад тулгарч буй сорилтуудыг судлан бэлтгэсэн тайлангаа НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд танилцуулах ажил юм.

Монгол Улсад хийсэн айлчлалынхаа үеэр миний бие зарим яам, хуульчид, их хурлын гишүүд, олон улсын болоод бүс нутгийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллүүдтэй уулзсан болно. Түүнчлэн Заамар сум, Налайх дүүрэгт зочилж нөхцөл байдалтай танилцаж, орон нутгийн төр засгийн албаны хүмүүс, малчид, орон нутгийн иргэдтэй уулзаж ярилцсан.

Намайг урьж, миний айлчлалын бэлтгэлийг хангаж, амжилттай зохион байгуулахад хамтран ажилласан Монгол Улсын Засгийн газарт талархал илэрхийлэхийг хүсч байна.

Ялангуяа, надтай уулзсан хүн бүрийн зочломтгой байдал, өөрийн үзэл бодол, туршлага, санаа зовнилоо илэн далангүй хуваалцсанд би маш их талархаж байна.

Хүний эрхийг зөрчиж буй хүрээлэн буй орчны хор нөлөө

Хүний эрх, хүрээлэн буй орчны хамгаалал нь өөр хоорондоо харилцан хамааралтай. Эрүүл орчин нь хүн амьдрах, эрүүл байх, хоол хүнс, уух устай байх зэрэг олон эрхээ бүрэн эдлэхэд зайлшгүй шаардлагатай. Үүний зэрэгцээ хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд мэдээлэл авах эрх, оролцоо, нөхөн төлбөр зэрэг хүний бусад эрхийг хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай.

Монгол Улсад хүний эрхийг зөрчиж буй хүрээлэн буй орчны хамгийн ноцтой хор нөлөө нь Улаанбаатар хотын агаарын бохирдол байна. Цахилгаан станц, тээврийн хэрэгслүүд бохирдлыг буй болгоход нөлөөлж байгаа ч хотын агаарын бохирдлын дийлэнх хувийг гэр хорооллын айл өрхүүдийн хэрэглэж буй нүүрсний шаталтаас үүдэлтэй бохирдол бий болгож байна. Өвлийн хүйтэн улиралд Улаанбаатар хот дэлхийн хамгийн их бохирдолтой хотуудын тоонд орж байна. Хүрэн манан тэнгэрийг нь бүрхэж, амьсгалах агаар нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон агаарын чанарын стандартаас хол давсан тоосонцор, бусад олон бохирдуулагчийг агуулсан байх юм.

Ийнхүү агаар нь бохирдсоноор хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах амьсгалын замын болон зүрх судасны өвчнийг үүсгэх шалтгаан болж хүний амьд явах, эрүүл байх эрхийг зөрчиж байна. Үүний нөлөө нь хамгийн эмзэг хэсэг болох хөгшид, өвчтэй хүмүүст илүү мэдрэгдэнэ. Хүүхдүүд эрсдэлд ороод буйг мөн олон судалгаагаар тогтоосон байна. Жишээ нь, 2016 онд хийсэн НҮБ-ын Хүүхдийн сангийн тооцоогоор агаарын бохирдлоос үүдсэн уушигны хаггалгаанаас болж Улаанбаатар хотод жил бүр 5 хүртэлх насны 400 гаруй хүүхэд эндсэн байна. Үүний зэрэгцээ, хүүхэд

насанд агаарын бохирдолтой нөхцөлд амьдарч байгаа хүмүүст уушигны хорт хавдар, зүрх судасны өвчнөөр өвчлөх зэрэг урт хугацааны эрүүл мэндийн эрсдэл үүснэ.

Хүрээлэн буй орчны ноцтой хор нөлөөг илэрхийлэх бас нэг чухал асуудал нь Монгол орны гол мөрний бохирдол улам бүр нэмэгдэж байгаа явдал бөгөөд цэвэр, аюулгүй ундны ус хэрэглэх хүний эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Ялангуяа, Туул гол нь нийслэлийнхэн болон бусад олон мянган хүмүүсийн ундны усны эх үүсвэр, гэтэл энэ нь уул уурхайн үйл ажиллагаа, шаардлага хангаагүй ус цэвэрлэх байгууламж, бусад эх үүсвэрээс шалтгаалан бохирдож байна. Айлчлалынхаа үеэр би Улаанбаатар хотын дундуур урсдаг голын хөндий, эрэг хавиар алт, нүүрсний олборлолт явуулж байгааг, нүүрсний үнс, бусад хог хаягдал замбараагүй ихээр хуримтлагдсаныг нүдээр харсан.

Хүрээлэн буй орчны хор нөлөөнөөс болж хүн бүр өөрийн соёл, ёс заншлыг эдлэх эрх хязгаарлагдаж байна. Монгол орон нүүдэлчин малчдаараа дэлхийд алдартай. Нүүдлийн мал аж ахуй нь байгаль орчноосоо ихээхэн хамааралтай, тийм ч учраас чийглэг болон хуурай бэлчээрийг тогтвортой ашиглах нь стратегийн гайхалтай шийдэл юм. Гэтэл сүүлийн жилүүдэд уламжлалт ёс заншил алдагдах аюулд оржээ. Дэлхийн дулаарлаас болж Монгол орны уур амьсгалын байдал бусад орнуудынхаас ч илүү эрс хурдацтай өөрчлөгдөж, зудын давтамж нэмэгдэхэд хүрсэн байна. Нүүдлийн соёл иргэншилд нөлөөлж буй бас нэг үзэгдэл бол уул уурхай, газар тариалангийн үйл ажиллагаанаас болж бэлчээр хомсдох эрсдэл бий болжээ. Түүнчлэн малын тоо толгой нэмэгдсэнээр бэлчээрийн талхагдалт, доройтол нэмэгдэж байна.

Малчдын уламжлалт соёлд учирч буй эдгээр асуудал нь хүрээлэн буй орчны асуудал хэрхэн өөр хоорондоо уялдаатай болохыг илэрхийлж байна. Бэлчээргүй болсон малчид Улаанбаатар хот руу зорьсноор хотын хүн амыг нэмэгдүүлж, агаар, ус, хөрсний бохирдлын асуудлыг даамжруулж байна.

Эдгээр хүрээлэн буй орчны асуудлууд нь Монголд хамаатай мэт боловч тулгарч буй нийтлэг сорилт нь бусад олон улсынхтай төстэй. Энэ нь хүмүүсийн амьдралын нэн чухал нөхцөл болсон байгаль орчноо доройтуулахгүйгээр хүн амынхаа эдийн засгийн байдлыг үргэлжлүүлэн сайжруулахын тулд байгалийн баялагаа хэрхэн яаж зохистой ашиглах вэ? Өөрөөр хэлбэл, жинхэнэ тогтвортой хөгжилд хэрхэн яаж хүрэх вэ? гэдэгт оршино.

Хөгжил тогтвортой байхын тулд хүний эрхэд суурилсан байх ёстой. Хүний эрхийн төлөв байдал нь хүний эрхэм чанар, эрх тэгш байдал, эрх чөлөө, хүний бүх эрхийг хэрэгжүүлэхийг илэрхийлэн түргэсгэнэ. Энэ нь ерөнхийдөө бодлогын үр дүнг дээшлүүлнэ. Хөгжлийн болон хүрээлэн буй орчны асуудлаарх бодлого сайтар хэрэгжсэнээр хүмүүс мэдээлэл олж авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох зэргээр бодлогын үр нөлөөг илүү хүчтэй болгодог. Хөгжлийн болон хүрээлэн буй орчны талаарх бодлогыг хүний эрх хэрхэн хангагдаж байгаа талаас нь үнэлснээр, тухайлбал, эрүүл, урт удаан, амьжиргааны зохистой түвшинд амьдарч байгаа эсэх талаас нь үнэлсэнээр чухамдаа хүмүүсийн эрүүл орчинд амьдрах эрх хэрхэн хангагдаж байгааг баталгаажуулна.

Иймээс улс орнууд хүний эрх хангагдах зайлшгүй нөхцөл болсон байгаль орчныг хамгаалах талаар хүний эрхийн тухай хуулиар

хүлээсэн үүрэгтэй. Эдгээр үүрэгт хүний эрхэд үзүүлж буй байгаль орчны нөлөөллийг үнэлэх, хүрээлэн буй орчны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, байгаль орчны асуудлаарх шийдвэр гаргахад талуудын оролцох оролцоог дэмжих, хохирлыг арилгаж нөхөн сэргээх боломжийг хангах үүрэгтэй.

Улс орнууд нь байгаль орчны нөхцөл байдлын хатуу стандартыг тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлэх ёстой. Мөн байгаль орчин нь материаллаг болон соёлын хэрэгцээ нь болсон малчид, орон нутгийнхан зэрэг байгаль орчинд учрах нөлөөлөл илүү хүндээр тусдаг эмзэг бүлгийнхнийг хамгаалах хууль тогтоомж, бодлогоо баталгаажуулах ёстой.

Монгол Улсын Байгаль орны талаарх хууль, бодлогын баримт бичгүүд

Монгол Улс нь хүний эрх, байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлууд өөр хоорондоо олон замаар холбоотой болохыг хүлээн зөвшөөрдөг. Хамгийн чухал нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтаар “хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” болохыг тодорхойлсон.

Монгол Улс тогтвортой хөгжлийг бодлогынхоо чиглэл гэж үздэг. Монгол Улс 2013 онд тогтвортой хөгжлийг дэмжих НҮБ-ын хөтөлбөр болох Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлд (PAGE) нэгдэн орсон анхны улс болсон байдаг. Өнгөрсөн долоо хоногт PAGE-ийн баг Монголд айлчилсан бөгөөд тэднийг байгаль орчны сайдын үүрэг гүйцэтгэгчтэй уулзахад би хамт байсан бөгөөд тэр үед сайдын үүрэг гүйцэтгэгч Монгол Улс тогтвортой хөгжлийн төлөө тууштай байгааг дахин баталж байсан. 2014 онд УИХ-аас Ногоон хөгжлийн бодлогыг баталж, 2016 онд

“Байгаль орчны тогтвортой байдлын зарчмуудыг” тодорхойлсон “Монгол Улсын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг” баталсан.

Тэр жилдээ Монгол Улсын Засгийн газар нь ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, түүндээ ногоон хөгжлийн үзүүлэлтүүд, ногоон ажлын байр, ногоон эдийн засгийн талаарх сургалт, тогтвортой худалдан авалт, ногоон байгууламж, тогтвортой санхүүжилт, хог хаягдлын менежментийн зэрэг олон санаачлагууд, үйл ажиллагааг тусгасан байна. Үндэснийхээ эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, салбарын бодлогоо илүү хүртээмжтэй, ногоон өсөлтийг дэмжихэд чиглүүлж буй Монгол Улсын Засгийн газрын хичээл зүтгэлийг би үнэлэн хүлээж авч байна.

Эдийн засагт ашигтай ч, байгаль орчинд хор хөнөөлтэй байж болзошгүй уул уурхай нь Монгол Улсын онцгой анхаарал хандуулах салбар юм. Ерөнхийдөө уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөтэй холбоотой хүний эрхийг хамгаалах үүрэг тодорхой юм. Хүний эрх, байгаль орчны хамгааллыг баталгаажуулахын тулд уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бүрэн үнэлгээг хийсэн, холбогдох бүх мэдээллийг олон нийтэд ил болгосон, орон нутгийн иргэдтэй тухайн явуулах гэж буй үйл ажиллагааны талаар зөвлөлдсөн, тэдний санал бодлогыг тусгасан чухам тэр үед л олгож байх ёстой. Уул уурхайн үйл ажиллагаанд баримтлах стандартууд нь уул уурхайн аюулгүй ажиллагааг хангасан, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор хөнөөлийг хамгийн доод хэмжээнд нь хүргэсэн, уул уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа тухайн газрыг анхны байдалд нь оруулж нөхөн сэргээсэн байхыг баталгаажуулах

ёстой. Тэвчишгүй хор хохирлыг бүрэн арилгах буюу нөхөн төлсөн байх учиртай. Энэ бүхнийг зөв хийсэн тэр л тохиолдолд уул уурхайн үйл ажиллагаа нь улс орны хувьд төдийгүй уул уурхайн үйл ажиллагаа шууд нөлөөлж буй тухайн орон нутгийн ард иргэдэд үр өгөөжөө өгөх болно.

Монгол Улс нь байгаль орчны хатуу стандарт, хэрэгжүүлэх журам процедурыг нь тогтоосон байгаль орчны талаарх болон уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой багц олон хууль тогтоомжтой.

Тухайлбал, уул уурхайн олборлолтын төсөл батлагдахаас өмнө байгаль орчны үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн, орон нутгийн иргэдийн батламж гаргасан байх шаардлагатайг хуульчилсан байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө гаргасан, нөхөн сэргээлтэд шаардагдах хөрөнгийн тал хувийг тусгай сан руу шилжүүлсэн байх журамтай. Орон нутгийн ард иргэдийн уул уурхайгаас хүртэх ашиг шимийг ч мөн тодорхойлсон байх шаардлагатай. Зарим газар нутгийг тусгай хамгаалалттай газар нутаг, мөн Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан, бүхийн газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай (урт нэртэй) хуулинд хамрагдаж байгаа газар нутаг хэмээн журамд хамруулдаггүй.

Хэдийгээр эдгээр хууль эрх зүйн баримт бичгүүдэд зарим шаардлагатай сайжруулалтыг хийж болох ч олон чухал асуудлууд аль хэдийнэ тусгалаа олсон байна. Гэсэн хэдий ч, эдгээр хууль тогтоомжоо үр дүнтэй хэрэгжүүлэх, мөрдүүлэхэд тус улс дорвитой ажиллах хэрэгтэй.

Хэрэгжилтийн асуудлууд

Хэрэгжилтийн явцад гарч буй олон доголдолтой асуудал байгаа нь ажиглагдлаа.

Хууль бусаар ашигт малтмал олборлогчид түгээмэл байна, тэдний дунд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд төдийгүй илүү зохион байгуулалттай уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хэсгүүд ч байна. Байгаль орчны үнэлгээ нухацтай хийгдэхгүй байна. Нөлөөллийн үнэлгээг энд тэндээс нь алаг цоог хийж байгаа мэдээллийг надад өгсөн. Говьд явуулж буй уул уурхайн үйл ажиллагааны үнэлгээнд, жишээлбэл, Монгол орны хойд хэсэгт байдаг ойн санд үзүүлэх нөлөөллийг авч үзсэн байх жишээтэй.

Үнэлгээ хийгдэж байгаа тохиолдолд тухайн уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг зохих ёсоор шалгаж үнэлэхгүй байна. Үнэлгээний талаарх мэдээллийг тухайн орон нутгийнханд тэр бүр хүргэдэггүй учир уурхайн үйл ажиллагааг эхлэхээр ухагч бульдозерууд ирэх чухам тэр үед л тэд мэдэх боломж гардаг байна.

Орон нутгийн засаг захиргаанаас батламж авах журам нь тун сайн зарчим боловч энэ нь тэр бүр амьдралд хэрэгжихгүй байна. *Нэгдүгээрт*, хуулиар орон нутгийн засаг захиргаа үзэл бодлоо нэг сарын дотор илэрхийлэх ёстой гэтэл энэ хугацаанд байгаль орчны үнэлгээ хийж сайтар хэлэлцэх боломж хязгаарлагдмал байна. *Хоёрдугаарт*, орон нутгийн албан хаагчид хангалттай мэдээлэлгүй байдаг, аль эсвэл хүмүүсийнхээ үзэл бодлыг хангалттай төлөөлөн илэрхийлж чаддаггүй байж болох юм. Орон нутгийн албан хаагчид уул уурхайн үйл ажиллагаанд хаалт тавих боломжоо хууль бус төлбөр авах арга болгон ашиглах, авилгалд өртөх магадлалтай байна. *Гуравдугаарт*, орон нутгийн эрх баригчид уул уурхайн лицензийг эсэргүүцэж байсан ч тэдний үзэл бодол төв засгийн газрын өмнө мөхөсддөг, аль эсвэл үл тоомсорлогдож байна.

Заамар сумын жишээ үүнийг илэрхийлж байгаа юм. Заамар суманд очиход олон арван жилийн өмнө эхэлсэн “Алт-1” төслийн хүрээнд алт олборлолт явуулж, уул уурхайн лиценз олноор олгогджээ. Аварга том байшин шиг эксковаторууд, сэгсрэгдэн оргилох ус, хажууханд нь хүүхдүүд хараа хяналтгүй тоглоод л, аюултай онгорхой нүхнүүд, бужигнах тоос шороо нь амьсгал боогдуулам, худгууд нь хатсан, загас жараахай нь үгүйрсэн; малчдынх нь бэлчээр хумигдсан ийм л дүртэй байна. Саяхан Алт-2 нэртэй шинэ төслийг зарласан нь ахиад л тус суманд ашигт малтмалын олон лицензийг бий болгохоор байна. Шинээр дахин уурхай нээснээр тус сумын үлдсэн бэлчээр устаж, байгаль орчинд илүү их хохирол учруулж болзошгүй юм. Орон нутгийн иргэд энэхүү төслийг эсэргүүцэж байсан нь тун ойлгомжтой. Хэдийгээр тэд эсэргүүцэж байсан ч Алт-2 төсөл батлагдаж лицензийг олгож эхэлжээ. **Энэ нь холбогдох хүний эрхийн хэм хэмжээтэй зөрчилдөж байна.**

Хүний эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхийн тулд Засгийн газар нь Алт-2 төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бүрэн хэмжээний нарийвчилсан үнэлгээг хийж, Алт-1 төслийн байгаль орчны болоод нийгмийн үр нөлөөтэй зэрэгцүүлэн үнэлж, нэмэлт лиценз олгосноор гарах хуримтлагдах үр нөлөөг судалж үнэлэх шаардлагатай. Үнэлгээний дүнг олон нийтэд ил тод мэдээлэхийн зэрэгцээ Алт-1 төслийн хор нөлөөг дорвитой нөхөн сэргээх, хохирлын нөхөн олговор олгох хэрэгтэй. Ингэхдээ олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хамгийн чухал нь Алт-2 төслийг урагшлуулах эсэхээ орон нутгийн иргэдтэй зөвшилцөн тэдний шийдвэрийг дагаж мөрдөх хэрэгтэй.

Хэрэгжилтийн явцад гарч буй зарим бэрхшээл мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас нөлөөлж байна. Тухайлбал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт уул уурхайн үйл ажиллагааг зохих ёсоор шалгах мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна. Налайхын нүүрсний уурхайн талбайд очиход орон сууцны хажууханд л хууль бус олборлолт явуулж байх юм. Үнэн хэрэгтээ, орон сууцны байшингуудад нь газрын гүн дэх олборлолтоос үүдэлтэй байж мэдэх хагарал эвдрэл гарсан хэмээн ярьж байна. Засгийн газрын холбогдох газруудад гомдол гаргасан хэдий ч оршин суугчид дорвитой тусламж авч чадаагүй байна.

Хэрэгжилтийн явцад гарч байгаа өөр нэг асуудал бол нөхөн сэргээлтийн зохих шаардлагууд ихэнхдээ хангагдаагүйтэй холбоотой байна. Шаардлагатай нөхөн сэргээлтийн хөрөнгийг төлдөггүй, аль эсвэл нөхөн сэргээлтийн хөрөнгөө өөр зориулалтаар ашигладаг талаар хэд хэдэн эх сурвалжаас сонсож байлаа. Заримдаа нөхөн сэргээлтийн ажил хийж байгаа дүрээр зарим компаниуд уул уурхайн олборлолтоо үргэлжлүүлдэг байна.

Уул уурхайгаас гадна, хууль тогтоомжийг илүү үр дүнтэй хэрэгжүүлж болох өөр нэг зам бол байгаль орчны талаарх мэдээллийн асуудал юм. Хэдийгээр хуулиар байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах аар заасан байдаг ч мэдээллийн хүртээмж харилцан адилгүй байна. Эерэг талаас нь харвал нийслэл хотын агаарын чанарын талаарх мэдээлэл тун ил тод хүртээмжтэй байгаа нь сайн байна. Гэсэн хэдий ч усны чанар, уул уурхайн үйл ажиллагаа, тоос шороо болон бусад асуудлуудын талаарх мэдээллийн хүртээмж тун хангалтгүй байна.

Дэлхийн нөөцийн институтээс Монгол дахь түншүүдтэйгээ хамтран гаргасан

саяхны тайланд тус улсад усны чанарын тухай мэдээлэл олдоц муутай, Засгийн газарт энэ талаар хүсэлт тавьсан ч хариу ирдэггүй хэмээн дурдсан байна.

Сайжруулах талаарх зөвлөмж

Зарим тохиолдолд хуулиудыг илүү сайжруулах, бэхжүүлэх шаардлагатай байна. Жишээлбэл, орон нутгийн иргэд уурхайн үйл ажиллагаа явуулах төсөлд саналаа өгөхийн тулд тэдний хэлэлцэх цаг хугацааг сунгаж өгөх шаардлагатай. Нөхөн сэргээлтийн стандартыг ил тод болгож бэхжүүлэх шаардлагатай байна. Засгийн газар нь уул уурхайн тухай хуулинд өөрчлөлт оруулах талаар зарим хүчин чармайлт гаргаж байгаа гэж би ойлгосон бөгөөд хуулийг шинэчлэхэд иргэний нийгмийн үзэл бодол саналыг тусгаж тэдний үр дүнтэй, бүрэн оролцоог хангахыг Засгийн газарт анхааруулж байна.

Үүний зэрэгцээ аль хэдий нь батлагдсан хууль эрх зүйн эмхэтгэлд орсон хууль тогтоомжоо хэрэгжүүлэхэд илүү их анхаарал тавих хэрэгтэй. Жишээ нь, Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаар Засгийн газар, Улаанбаатар хот, олон улсын хандивлагчид сүүлийн жилүүдэд агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн олон хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжихэд шаардагдах санхүүжилтыг бий болгох ёстой бөгөөд энэ нь тус улсын хөгжилд сайнаар нөлөөлнө. Үүний зэрэгцээ хөтөлбөрүүд нь хамгаалах гэж буй хүмүүсийнхээ хүний эрхийг хүндэтгэх ёстой. Ялангуяа хүмүүсийн Улаанбаатар хотод шилжин суурьших явдлыг хязгаарлаж байгаа нь тэдний амьдрах газраа чөлөөтэй сонгох хүний эрхтэй нь зөрчилдөж улмаар ямар ч нөхцөлд үр дүнгүй байх магадлал өндөр юм.

Монгол Улс нь байгаль орчны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар хэд хэдэн чухал алхмуудыг хийсэн байна. Эрүүгийн хуулинд байгаль орчны гэмт хэргийг оруулсан нь маш чухал алхам юм. Үүнээс гадна монголчуудын төрийн байгууллагын талаар гомдол гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс Захиргааны ерөнхий хуулиар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлж өгчээ.

Гэсэн хэдий ч, бодит байдалдаа, Засгийн газрын эсрэг тавьсан гомдол нь хуулийг сахиулахын төлөөх иргэдийн талд гарах нь тэр бүр ховор. Байгаль орчны асуудлын талаарх мэдээллийг олж авахыг хүссэн хэн нэгэн, аль эсвэл хуулийн заалт шаардлага биелэгдэхгүй байгааг мэдэрсэн иргэд гомдлоо Засгийн газартаа шууд хандан гаргаж чаддаг байх ёстой.

Үүний тулд миний өгөх гол зөвлөмж бол Засгийн газар нь байгаль орчны талаарх мэдээлэл, гомдлыг авч хэлэлцэх эрхтэй Байгаль орчны Омбудперсоныг томилох явдал юм.

Байгаль орчны Омбудперсон нь бусад агентлаг байгууллагуудын байр суурийг эзлэхгүй. Харин энэ нь Засгийн газартаа “Ногоон хаалга” хэлбэрээр үйлчлэх болно. Омбудперсон нь байгаль орчны талаар гомдол гаргах болон мэдээлэл хайж буй монголчуудад гомдлоо хэрхэн зөв газар руугаа илгээх талаар зөвлөгөө өгч тэдний хариултыг тухайн байгууллага цаг тухайд нь гаргаж өгч байгаа эсэхэд хяналт тавина. Энэ нь тайлан, зөвлөмжийн хэлбэрээр гарна. Омбудперсон нь байгаль орчны талаарх бүхий л мэдээллийг идэвхтэй цуглуулж хялбар ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд нээлттэй болгоно. Жишээлбэл, усны чанарын талаарх мэдээллийг Туул болон бусад голуудын усны бохирдлын түвшинг тодорхой цэгүүд

дээр мэдээлэх, мөн усны чанарын талаарх мэдээллийг төрөл бүрийн хэрэглээнд зориулан тусгайлан мэдээллэж байх болно. Уул уурхайтай холбоотойгоор уул уурхайн үйл ажиллагааны байршил, бохирдуулагч бодисын ялгаралт, Засгийн газрын хяналт шалгалт хийсэн цаг хугацаа, нөхөн сэргээлтийн байдал зэрэг мэдээллээр хангаж болно. Мөн уурхайн эзэмшигчийн талаарх мэдээллийг өгч болно. Омбудперсон нь үйл ажиллагаа явуулахаар зэхэж буй уурхайн нөлөөллийг ойлгох, уул уурхайн компаниудтай гэрээ байгуулах талаар орон нутгийн иргэд, хамт олныг дэмжин ажиллаж болно.

Би өнөөдрийн дүгнэлтээ хэрэгжилтийг бэхжүүлэхэд илүү чиглүүлж ярьсан хэдий ч Монгол Улсад хоёр шинэ хууль батлан гаргах шаардлагатайг анхааруулахыг хүсч байна.

Энэ нь юуны өмнө Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх Аархусын конвенц юм. Нэрнээс нь харсан ч энэ бол байгаль орчны талаарх мэдээлэл, оролцоо, нөхөн төлбөрийн стандартуудыг тогтоож өгсөн олон улсын гэрээ юм. Монгол Улсын хууль, тогтоомжид эдгээр стандартын нилээдийг тусгасан байгаа хэдий ч Конвенцид нэгдэх нь олон улсын стандартад нийцэж байгаа эсэхээ баталгаажуулах боломжийг олгоно. Төв Азийн болон Европын олон орнууд, Монгол Улс нь олон жилийн туршид тус конвенцид нэгдэх талаар сонирхож ирсэн гэж үздэг. Одоо харин нэгдэх цаг нь болжээ хэмээн зөвлөж байна.

Удаах нь, магадгүй нэн яаралтай хийх зүйл бол Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын боловсруулсан Хүний эрхийн хамгаалагчдын тухай хуулийн төслийг УИХ-ын Хүний эрхийн дэд хороо хянаж байгаа бөгөөд үүнийг яаралтай батлуулах хэрэгтэй.

Олон оронд байгаль орчны хүний эрхийн хамгаалагчид хүчирхийлэл, үхэл хэмээх өндөр эрсдэлд өртөж байна. Дэлхий дээр долоо хоног тутамд дунджаар байгаль орчны дөрвөн хамгаалагч амиа алдаад байна. Олон хүнийг айлган сүрдүүлэг, дарамтад байна. Хэдийгээр бусад олон оронд тахлын хэлбэрээр байгаа шиг нөхцөл Монгол Улсад илрээгүй ч байгаль орчны эрхийг хамгаалагчдаас хууль бус уул уурхай, хулгайн агнуурыг эсэргүүцэхийг оролдсон үедээ хүчирхийлэл, сүрдүүлэгт өртөж байгааг сонсоход хүнд байлаа.

Хамгийн түгшүүртэй тохиолдол бол Монголын Цоохор ирвэс хамгаалах сантай хамтран ажиллаж байсан байгаль хамгаалагч Төмөрсүхийн Лхагвасүмбэрэлийн (Сүмбээ) нас барсан явдал юм. Сүмбээгийн шарилыг Хөвсгөл нуураас 2015 оны 11 дүгээр сарын 11-нд олсон байдаг. Ихэнх ажиглагчдын гайхшралыг төрүүлсэн явдал бол түүний үхлийг цагдаагийнхан амиа хорлолт хэмээн тогтоосон явдал юм. Гэтэл өмнөх 2 жилийн хугацаанд Говь цөлийн Алтайн нурууны уулархаг нутаг дахь Тост уулаа тусгай хамгаалалтад авахуулахын төлөө түүний зүтгэлийн хариуд Сүмбээ дор хаяж гурван удаа халдлагад өртсөн байдаг. Энэхүү үйл явц нь дэлхийн өнцөг булан бүрт тохиолддог байгаль орчны хамгаалагчдын

аюул занал, хүчирхийллийн улмаас гардаг цаг бусын үхлийн шалтгаантай тун төстэй. Энэ залуугийн үхлийн талаарх албан ёсны тайлбарт олон хүн сэтгэл дундуур байгаа нь ойлгомжтой. Засгийн газар нь энэ хэргийн мөрдөн байцаалтыг дахин хийж, хамгаалалтын албаны бусад гишүүд нь болзошгүй эрсдэлээс хамгаалагдсан байх ёстой. Байгаль орчныг хамгаалагчид болон бусад хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хуулийг батлан хэрэгжүүлэхэд Монгол Улс тэргүүн ач холбогдол өгөх хэрэгтэй. Миний хийсэн олон ярилцлагаас харахад тус хуулийн ач холбогдолын талаар талууд зөвшилцөлд хүрч байгаа хэмээн ойлгож удахгүй хэрэгжих байх хэмээн найдаж байна.

Хатагтай, ноёд оо,

Байгаль орчин, хүний эрхийг хамгаалахын төлөө ажиллаж буй надтай уулзсан олон хүний хичээл зүтгэлийг би бишрэн гүнээ талархаж байна. Эдгээр асуудалд маш идэвхтэй оролцдог иргэний нийгмийнхэнтэй өмнө хэзээ ч уулзаж байгаагүй ээ. Байгаль орчныг хамгаалах үйлсийн тэргүүн эгнээнд ажиллаж байгаа эдгээр хүмүүс бидний төлөө даян дэлхийгээ илүү сайн сайхан болгохын төлөө биднийг дэмжин тусалж байна. Бид тэдэндээ хүндлэл, талархал илэрхийлэх ёстой.

2017 оны 9 дүгээр сарын 19-27-ны хооронд Тусгай Илтгэгч зарим яам, хуульчид, их хурлын гишүүд, олон улсын болоод бүс нутгийн байгууллагууд, иргэний нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллүүдтэй уулзсан болно. Тусгай Илтгэгч нь үнэлгээнийхээ иж бүрэн тайланг НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд 2018 оны 3 дугаар сард танилцуулна.

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл нь 2012 онд ноён Жон Х. Ноксыг бие даасан шинжээчээр томилсон бөгөөд 2015 онд түүнийг дахин Аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчны асуудлаарх Хүний эрхийн тусгай илтгэгчээр томилжээ. Зөвлөл нь АНУ-ын Вейк Форестийн (Wake Forest) Их Сургуулийн олон улсын эрх зүйн профессор болох түүнд хандаж хүний эрхийн хэм хэмжээ нь байгаль орчныг хамгаалах явцад хэрхэн мөрдөгдөж байгааг, түүнчлэн

байгаль орчны бодлого, шийдвэр гаргах явцад хүний эрхийн хэм хэмжээг ашиглаж байгаа шилдэг туршлагыг тодорхойлоход туслахыг хүссэн юм.

Тусгай Илтгэгчүүд нь Хүний эрхийн Зөвлөлийн Тусгай Хороо хэмээх хэсэгт харьяалагддаг. Тусгай Хороо нь НҮБ-ын Хүний эрхийн тогтолцоо дахь бие даасан шинжээчдийг удирдах хамгийн том нэгж бөгөөд Хүний эрхийн Зөвлөлийн хараат бус баримт нотолгоог судлах болон хяналт үнэлгээ хийх механизм болно.

Тусгай Хорооны бүрэн эрх олгогдсон хүмүүс нь Хүний эрхийн Зөвлөлөөс томилогдсон хүний эрхийн асуудлаарх бие даасан шинжээчид бөгөөд тэдний үйл ажиллагаа нь аль нэг орны хүрээнд буюу тодорхой сэдвээр дэлхий дахинаа хамрах асуудлыг шинжлэн дүгнэлт гаргахад чиглэгддэг. Тэд бол НҮБ-ын ажилтнууд биш бөгөөд ямар ч засгийн газар, байгууллагаас хараат бусаар ажилладаг. Тэд өөрсдийн мэдлэг чадавхиараа үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хийсэн ажилдаа цалин хөлс авдаггүй.

НҮБ-ын Хүний Эрхийн асуудал, Улсын хуудас - Mongolia

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хүмүүстэй холбогдоно уу:

Айлчлалын өмнө, үеэр, дараа: Ноён Жамшид Газиев (+41 79 109 6872/ jgazyiyev@ohchr.org, Хатагтай Мариям Наваз (mariyam.nawaz@one.un.org / +976 9542 1358), эсвэл Хатагтай Амарын Цэцэгмаа (+976 11 327 585 ext 1104 / tsetsegmaa.amar@one.un.org)

Амьдарч буй нийгэмдээ санаа зовниж байна уу? Тэгвэл, **нэгнийхээ эрхийн төлөө ЗОГСОЦГООЁ**. Хүний эрхийн төлөөх дараах нүүр хуудаст зочлоорой <http://www.standup4humanrights.org>

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



**ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ТУХАЙ КОНВЕНЦ**

Түгээсэн огноо: 2017 оны 6 сарын 2

Үндсэн эх: Англи хэл дээр
АЛБАН БУС ОРЧУУЛГА

Хүүхдийн эрхийн хороо

Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмж

I. Оршил

1. Хороо нь Монгол Улсын 5-р тайлан илтгэлийг (CRC/C/MNG/5) 2017 оны 5-р сарын 26-ний өдөр хуралдсан өөрийн 2210 болон 2211 дугаар уулзалтаар (баримт бичгийн бүртгэлийн дугаар- CRC/C/SR.2210 болон 2211) хэлэлцэж 2017 оны 6-р сарын 2-ны өдөр хуралдсан 2221 дүгээр хуралдаанаараа энэхүү ажиглалт зөвлөмжийг хэлэлцэж батлав.

2. Хороо нь тус улсыг 5 дугаар тайлангаа болон Тулгамдсан асуудлуудын лавлагаанд хариу болгож Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгох боломж өгсөн хариултыг бичгээр ирүүлснийг (CRC/C/MNG/Q/5/Add.1) талархан хүлээж авсан билээ. Мөн тус улсаас олон салбарыг төлөөлсөн өндөр түвшний төлөөлөгчдийн баг ирж маш үр дүнтэй хэлэлцүүлэг яриа өрнүүлсэнд Хорооны зүгээс талархаж буйгаа илэрхийлье.

II. Тус улсаас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ болон хүрсэн ололт амжилт

3. Өмнөх тайлангаа хэлэлцүүлсэнээс хойшх хугацаанд олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг соёрхон батлах, нэгдэн орох зэргээр, тухайлбал, 2015 онд Мэдээлэл хүргэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон баталсан

болон хүүхдийн эрхтэй холбоотой байгууллагыг шинэчлэх, бодлогын шинэчлэл хийх, хэд хэдэн хууль тогтоомжийг шинээр батлах ажлуудыг хийсэн ололт амжилтыг Хороо үнэлж байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинээр баталсан, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль зэргийг шинэчлэн найруулсныг онцлон талархаж байна.

III. Тулгамдсан асуудлууд болон зөвлөмжүүд

4. Хүүхдийн эрхийн тухай конвенцид тусгагдсан хүүхдийн бүх эрх өөр хоорондоо нягт уялдаатай, хуваагдашгүй цул гэдгийг болон энэхүү дүгнэлт зөвлөмжинд багтаасан бүх зөвлөмж туйлын чухал гэдгийг Хорооны зүгээс тус улсад сануулж байна. Дараах чиглэлээр нэн даруй арга хэмжээ авах хэрэгтэй байна гэдэгт тус улсын анхаарлыг Хороо хандуулахыг хүсч байна. Үүнд: төсөв нөөцийн хувиарлалт (9-р зүйл), бизнесийн салбар ба хүүхдийн эрх (14-р зүйл), үл ялгаварлах (16-р зүйл), гэр бүлийн орчин (26-р зүйл), орчны эрүүл мэнд (35-р зүйл), хүүхдийн хөдөлмөр болон унаач хүүхдийн асуудлыг багтаасан эдийн засгийн мөлжлөг (41-р зүйл).

А. Хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээнүүд
(4, 42, 44 (6) зүйлүүд)

Хууль тогтоомж

5. 2016 оны 2 дугаар сард Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль баталсныг Хорооны зүгээс сайшаан тэмдэглэхийн хамт эдгээр хуулийг Хүүхдийн эрхийн тухай конвенцид-д нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авахыг зөвлөж байна. Ялангуяа, шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хувиарлахад илүү анхаарна уу.

Цогц бодлого ба стратеги

6. Урт хугацааны бодлого шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх нь ерөнхийдөө бэрхшээлтэй гэдгийг тэмдэглэхийн зэрэгцээ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн бүхий л чиглэлээр хүүхэдтэй холбоотой цогц бодлого баримтлахыг тэргүүлэх зорилгоо болгохыг Хороо тус улсад зөвлөж байна. Энэхүү цогц бодлогодоо суурилан үр дүнтэй хэрэгжүүлэх алсын хараа стратегиа боловсруулах шаардлагатай юм. Боловсруулсан стратеги нь хангалттай санхүү, арга зүй, хүний нөөцөөр дэмжигдсэн байх нь зүйтэй.

Зохицуулалт

7. Өмнө өгсөн зөвлөмжийн дагуу (CRC/C/MNG/CO/3-4, 12 дугаар зүйл), өмнө нь Хүүхдийн төлөө үндэсний газар нэртэй байгаад одоо Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гэж шинээр нэрлэгдэх болсон байгууллагыг хүүхдийн эрхийн хэрэгжилтийг зохицуулах гол үүргээ амжилттай хэрэгжүүлэх боломжийг хангахуйц санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангах ажлыг яаралтай хийхийг тус улсад зөвлөж байна.

Нөөцийн хувиарлалт

8. Тус улсын санхүүгийн хүндрэлтэй байдал болон төлөвлөлт, санхүүжилт, үр дүнгийн хоорондын холбоосыг сайжруулах зорилго бүхий хөтөлбөрт суурилсан санхүүгийн тогтолцоонд

шилжиж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээнд тогтвортой хөрөнгө оруулалт дутагдаж байгаа, хээл хахууль, олборлох уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал, түүний огцом өсөлт уналт зэргээс болж улсынх нь эдийн засаг хямарсан зэргээс шалтгаалан хүүхдийн эрхийг хангах чиглэлээр өмнө олсон амжилтаасаа ухарсанд туйлын харамсаж байна.

9. Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр улсын төсөв ямар байх талаар өмнө өгсөн зөвлөмжөө сануулж (CRC/C/MNG/CO/3-4, өмнөх тайлангийн 18-р зүйл), 2016 онд Хорооноос гаргасан Хүүхдийн эрхийг хангах төсөвлөлтийн тухай 19-р ерөнхий зөвлөмжийн хүрээнд дараах арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

(a) Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийн хувиарлалт, хүртээмж, үр ашиг, тэгш байдлыг хэрхэн харгалзаж буй зэргийг нь үнэлэн дүгнэхэд шаардлагатай бүртгэлжүүлэлт, тусгай шалгуур үзүүлэлтүүдийг хамруулсан, хүүхдийн эрхийн хандлагаар хийгдсэн, үр дүнд чиглэсэн буюу хөтөлбөрт суурилсан төсвийн менежментийн шинэчлэл хийх санаачлагаа улам бэхжүүлэх;

(b) Олон нийтийг, тухайлбал, хүүхдүүдийг төсвийн хэлэлцүүлэгт оролцуулах замаар болон төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх байдлаар төсвийн ил тод, оролцоот байдлыг хангах

(c) Нийгмийн хамгааллын арга хэмжээ шаардахаар хүнд болон эмзэг нөхцөл байдалд байгаа хүүхдүүдэд зориулсан төсвийн задаргааг тогтоож эдийн засгийн уналт, хямрал, байгалийн гамшиг болон бусад онцгой байдлын үед ч тэрхүү зориулалтын төсөв танагдахгүй байхад анхаарах;

(d) Үйлчилгээ үзүүлэхэд зориулан хувиарласан төсвийг өөрчлөх танах болбол уг өөрчлөлт нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлж байгаа тухайн үеийн түвшнээс доошлохгүй байхад анхаарах;

(е) Бүх хэлбэрийн хээл хахуулийг ихээхэн хэмжээгээр бууруулна гэж тусгасан Тогтвортой хөгжлийн зорилтуудын 16.5 дахь заалтыг сануулахын ялдамд хээл хахуулийг илрүүлэх, мөрдөн шалгах, ял шийтгэл ноогдуулах институцийн чадавхийг дээшлүүлж түүнтэй тэмцэх бүхий л хүчин чармайлтаа төрийн зүгээс идэвхжүүлэх.

Мэдээлэл цуглуулах

10. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээний талаар Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж 5-ыг (2003) хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(а) Мэдээлэл цуглуулах тогтолцоогоо аль болохоор яаралтайгаар үр дүнтэйгээр сайжруулах. Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдалд, нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн талаарх дүгнэлт шинжилгээг сайжруулахын тулд Конвенцийн бүх хүрээг хамруулан хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг задаргаагаар мэдээллийг цуглуулах;

(б) Тухайн асуудлаар ажилладаг яамдууд мэдээллийн өгөгдөл болон шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар ашигладаг, тэдгээрийг Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийг боловсруулах, хяналт, үнэлгээ хийхдээ ашигладаг байхад анхаарах;

(с) Хүний эрхийн Дээд Комиссарын ажлын албанаас эрхлэн гаргасан *Хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүд: Статистикийн мэдээлэллийг тогтоох, цуглуулах болон түгээн дэлгэрүүлэхдээ ашглах хэмжилтийн аргууд болон хэрэгжилтийн гарын авлагад* тусгагдсан арга зүй, онолын хүрээг хэрэглэх;

(д) Энэ чиглэлийн арга зүйн тал дээр НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх.

Бие даасан хяналт шинжилгээ/мониторинг

11. Өмнөх зөвлөмжөө эргэн сануулахын

ялдамд (CRC/C/MNG/CO/3-4, 16-р зүйл) Хүний эрхийн бие даасан байгууллагын үүргийн талаар Ерөнхий зөвлөмж 2-т (2002) заасныг үндэслэн дараах зөвлөмжийг нэмж өгч байна. Үүнд:

(а) Хүний эрхийг дээдлэх, хамгаалахын тулд үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллагын статусыг тогтоосон Парисын зарчимд нийцүүлэн өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хүрэлцэхүйц хэмжээний санхүү, арга зүй, хүний нөөцөөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг хангах талаар анхаарах;

(б) Сонгон шалгаруулах, томилгоо хийхдээ ойлгомжтой тодорхой, ил тод, оролцоот үйл явцыг бүрдүүлэхийн тулд 2014 оны 10 дугаар сард Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Дэлхийн холбооны Магадлан итгэмжлэх дэд хорооны гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх

(с) Унаач хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, бие махбодын шийтгэл, хүүхдэд асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэгчдэд мониторинг хийх, тэдний үйл ажиллагааг зохицуулах, төрсний гэрчилгээний олголт зэрэг асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

Түгээн дэлгэрүүлэх, ойлголт нэмэгдүүлэх болон сургалт

12. Хороо өмнөх зөвлөмжөө дахин сануулахын (CRC/C/MNG/CO/3-4, para.22) зэрэгцээ дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(а) Конвенцийн бүхий л зүйл заалтуудыг олон нийт, эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан болон хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг бүх мэргэжилтнүүд, мөн хүүхдүүд өөрсдөө сайн мэддэг байхад чиглэгдсэн, одоогоор хангалттай хийж чадахгүй байгаа ойлголт нэмэгдүүлэх хөтөлбөр, кампанит ажлуудаа сайжруулах;

(б) Хууль сахиулах байгууллагад ажилладаг бүх ажилтнууд, багш нар, эрүүл

мэндийн ажилтнууд, нийгмийн ажилтнууд, хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд, бүх шатны төрийн байгууллагын ажилтнуудыг Конвенцоор хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх чиглэлээр тогтмол сургалтанд хамруулж байхад анхаарах.

Хүүхдийн эрх ба бизнесийн салбар

13. Бизнесийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгах чиглэлээр тус улсын авч явуулж буй арга хэмжээг Хорооны зүгээс сайшаахын ялдамд олборлох уул уурхайн салбар зэрэг бизнесийн байгууллагууд хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөөгөө багасгахад чиглэсэн дүрэм журамгүй байгаад сэтгэл зовинож байна. Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд гэх мэт төрийн албанд ажиллаж буй хүмүүс өөрсдөө морь уях, уралдуулах, эмийн болон архи тамхины үйлдвэрлэл эрхлэх зэргээр хувийн ашиг сонирхлоо нийтийн ашиг сонирхолтой зөрчилдүүлэн ажиллах явдал гарсаар буйд туйлын ихээр харамсаж байгаагаа илэрхийлэе.

14. Хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд бизнесийн салбарын нөлөөллийн талаар гаргасан Ерөнхий зөвлөмжийг үндэслэн (2013) олон улсын болон үндэсний хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин болон бусад стандартыг, ялангуяа хүүхдийн эрхтэй холбоотой зүйл заалтуудыг бизнесийн салбарынхнаар хатуу мөрдүүлэхэд чиглэсэн дүрэм, журам гаргаж хэрэгжүүлэхийг Хорооны зүгээс тус улсад зөвлөж байна. Тухайлбал, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

(а) Олборлох салбарыг зохицуулах хуулийг баталж энэ салбарын үйл ажиллагаа хүүхдэд сөрөг үр дагавар учруулахгүй байхад хэрэгжилтийг нь чиглүүлэх;

(б) Төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс хувийн ашиг сонирхлоо нийтийн ашиг сонирхолтой зөрчилдүүлэх явдлыг арилгахын тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт хууль тогтоомжийг мөрдүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;

(с) Хүний эрх болон бизнесийн талаарх НҮБ-ын үндсэн зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (тайлан нь A/HRC/30/6, para.108.162 and A/HRC/30/6/Add.1 гэсэн нэрийн дор цахим санд бий) хүрээнд тус улсаас хүлээсэн үүргээ биелүүлэхтэй уялдуулан боловсруулж батлах;

(d) 2013 оны 4-р сард гарсан Хүний эрх ба улс дамнасан корпорацууд болон бусад бизнесийн байгууллагын асуудлаар НҮБ-ын Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийг (A/HRC/23/32/Add.1) хэрэгжүүлэх.

С.Ерөнхий зарчмууд (2, 3, 6 болон 12-р зүйлүүд)

Үл ялгаварлах

15. Хорооны зүгээс тус улсад тэгш бус байдал өссөөр байгаад, ялангуяа орлого багатай өрхийн хүүхдүүд, шилжин суурьшсан болон бүртгэлгүй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэсний цөөнх болон өөр хэлтэй хүүхдүүд, уугуул иргэдийн хүүхдүүд, гей, лесбиян, трансжендер хүүхдүүд (LGBT) гэх мэт эмзэг, хүнд нөхцөлд орсон хүүхдүүдийг ялгаварлан гадуурхалтанд өртүүлж буйд, тухайлбал энэ тохиолдлууд нь сургууль, дотуур байрны орчинд гараад байхад ямар ч хариуцлага тооцдоггүйд харамсаж байна.

16. Ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжоо мөрдүүлэх арга хэмжээг бэхжүүлэх замаар ийм ялгаварлан гадуурхалтанд хүргэж байгаа хандлага, хэвшмэл буруу ойлголтыг арилгахад чиглэсэн дараах тодорхой арга ажлыг яаралтай хийхийг тус улсад зөвлөж байна. Үүнд:

(а) Ялгаварлан гадуурхалтын талаар мэдээлэх явдлыг дэмжих

(b) Ийм зөрчил гаргасан хүмүүст тохирох арга хэмжээг нь шуурхай ноогдуулахад анхаарах;

(с) Хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг багш, нийгмийн ажилтан, асрамж халамжийн газрын ажилтнууд, нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд гэх

мэт мэргэжилтнүүд, эцэг эх, хүүхдэд чиглэсэн ойлголт дээшлүүлэх, боловсрол олгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.

Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих

17. Хүүхэд хамгааллын хууль болон бусад саяхан батлагдсан хууль тогтоомжиндоо хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэхийг нэн тэргүүнд анхаарах талаар оруулсанд талархахын зэрэгцээ Хороо өмнөх зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.28) дахин сануулж байна. Мөн Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих тухай Ерөнхий зөвлөмж 14-ийн (2013) хүрээнд дараах зөвлөмжийг тус улсад өгч байна. Үүнд:

(a) Гэр бүлийн тухай хууль, хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох, эцэг, эхэд ял шийтгэл ноогдуулах зэрэгтэй холбоотой шүүх, прокурор, захиргааны шийдвэр гаргах, тайлбар өгөх зэрэгтээ хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг бүхий л үйл явцын туршид мөрддөг байхад анхаарах;

(b) Хүүхэдтэй хамаатай бүхий л асуудлаар хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тогтоох үүрэг хүлээсэн бүх хүмүүст өгөх энэ чиглэлийн заавар зөвлөгөө, шалгуур журмыг боловсруулах;

(c) Дээр дурдсан шалгуур журамд үндэслэн 24 цагийн цэцэрлэг, дотуур байр, асрамж, халамжийн газрын үзүүлж буй үйлчилгээ, бодлого, үйл ажиллагаа нь хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих шаардлагад нийцэж байна гэдэгт үнэлэлт дүгнэлт хийх;

(d) Хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажиллаж буй бүх мэргэжилтнүүд өөрсдийн ажил үүргийг гүйцэтгэх явцдаа хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьдаг байхад анхаарах.

Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх

18. Өмнө өгсөн зөвлөмж (CRC/C/MNG/CO/3-4, para.32) болон Хүүхдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрхийн талаарх Ерөнхий зөвлөмж 12-ыг үндэслэн Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(a) Хүүхдийн оролцоог дэмжих стратеги болон Хүүхэд хамгааллын тухай хуулинд тусгагдсан хүүхэд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжийг олгох, үзэл бодлыг нь тэдэнд нөлөөлж буй асуудлыг шийдэх явцад харгалзан үзэх заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангах;

(b) Нийгмийн ажилтнууд болон шүүх хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг мөрдөх тогтолцоог бүрдүүлэх замаар шүүн таслах үйл ажиллагаанд хүүхдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрхээ эдлэх боломжийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;

(c) Бүх хүүхдүүд, ялангуяа охидууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон LGBT хүүхдүүдийн дунд гэр бүл, орон нутаг, сургуулийнхаа үйл ажиллагаанд утга учиртай оролцох замаар чадваржих боломжийг нь өгч чадах хөтөлбөр, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах.

Эсэн мэнд амьдрах, хөгжих эрх

19. Тус улсын хэрэгжүүлсэн арга хэмжээг цохон тэмдэглэхийн зэрэгцээ осол гэмтэл, ялангуяа 5-аас доош насны хүүхдүүдийн түлэгдэлт, хөдөө орон нутагт авто замын хөдөлгөөн ихэссэнээс нэмэгдсэн осол аваар, морин уралдааны улмаас гарч буй гэмтэл осол зэрэг нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих эрхэнд эрсдэл учруулж буйд Хороо тун ихээр сэтгэл зовинож байна. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх олон нийтэд сургалт сурталчилгаа хийх, буруутай этгээдэд хариуцлага тооцох гэх мэтээр осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэхийг Хорооны зүгээс тус улсад зөвлөж байна.

D. Иргэний эрх, эрх чөлөө (7, 8, болон 13-17 дугаар зүйлүүд)

Төрсний гэрчилгээ болон үндэс угсаа

20. Төрсний гэрчилгээ авсан хүүхдийн хувь өндөр байгааг тус улсын тайланд

дурдсаныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хүн бүрт төрсний гэрчилгээ, иргэний бичиг баримт олгох талаар заасан Тогтвортой хөгжлийн зорилтуудын 16.9-г анхаарлаа хандуулахыг Хорооны зүгээс сануулж дараах зөвлөмжийг өгч байна:

(а)Казах хүүхдүүд, улсынхаа нутаг дэвсгэр дээр шилжин суурьшсан хүүхдүүд, эх баригчийн дэмжлэггүй гэртээ төрсөн хүүхэд зэргийг оруулаад бүх хүүхдэд төрсний гэрчилгээ олгох замаар иргэний бичиг баримттай болгох хүчин чармайлтаа бэхжүүлэх;

(б) Иргэний харьяалалгүй, ялангуяа Монголдоо буцаж ирсэн Казах хүүхдүүд гэх мэт тус улсын нутаг дэвсгэрт оршин сууж буй бүх хүүхдэд Монгол Улсын иргэний харьяалал олгоход шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;

(с)1954 оны Иргэний харьяалалгүй хүмүүсийн статусын тухай конвенц, 1961 оны Иргэний харьяалалгүй байдлыг бууруулах конвенцийг соёрхон батлах талаар анхаарах, эдгээр олон улсын гэрээ конвенцтэй хууль тогтоомжоо уялдуулах.

Хувийн эрх чөлөө

21. Хувийн нууцын тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль гэх мэт хууль тогтоомжоор хүүхдийн хувийн орон зай, хувийн нууцтай байх эрхийг баталгаажуулсныг сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ эцэг эх, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг хувь хүмүүс хүүхдийн энэ эрхэнд бүдүүлгээр халдсаны улмаас зарим үед хүүхэд амиа хорлоход хүргэж болзошгүй учраас хүүхдийн хувийн нууцаа хадгалах, хувийн орон зайтай байх эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг тус улсад Хороо зөвлөж байна. Тухайлбал, эцэг эх, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг бусад мэргэжлийн хүмүүс хүүхдийн хувийн нууцаа хадгалах, хувийн орон зайтай байх эрхийн талаар бүрэн

зөв ойлголттой болох, энэ эрхэнд хүндэтгэлтэй хандахад сургах тодорхой зөвлөмж журам бий болгох талаар тус улс анхаарах нь зүйтэй.

Тохиромжтой мэдээллийн хүртээмж

22. Тус улсад интернетийн хэрэглээ хүүхдүүдийн дунд өндөр байгааг тэмдэглэхийн зэрэгцээ өмнөх дүгнэлт зөвлөмжинд өгсөн даалгавраа (CRC/C/MNG/CO/3-4, para.36) эргэн сануулахын хамт Интернет болон нийгмийн сүлжээнд тавигдсан хүүхдийн сайн сайхан байдалд хор хохирол учруулах мэдээ материалаас тэднийг хамгаалахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авахыг Хороо зөвлөж байна. Бүх хүүхдийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өөр хэлтэй үндэстний цөөнхийн хүүхдүүдийн хэрэгцээг анхаарсан хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг хүүхдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, ном зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон хэлбэрийг ашиглан хүргэх замаар хүүхдэд тохиромжтой хэрэгтэй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг мөн зөвлөж байна.

Е. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл (19, 24 (3), 28 (2), 34, 37 (а), 39 зүйлүүд)

Бие махбодын шийтгэл

23. Бүх орчинд бие махбодын шийтгэлийг хориглосон заалтыг Хүүхэд хамгааллын болон Хүүхдийн эрхийн тухай хуулиар баталгаажуулсныг сайшаан талархахын зэрэгцээ бие махбодын шийтгэлийг гэр бүл, сургууль зэрэгт өргөнөөр хэрэглэсээр байгаад Хорооны зүгээс сэтгэл ихээр зовинож буйгаа илэрхийлье. Хүүхэд өсгөх, хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн биш, эерэг, оролцооны аргыг хэрэглэхийг эцэг эх, багш нарт сургах, үндэсний хэмжээний кампанит ажил өрнүүлэх гэх мэт олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээ өрнүүлэх замаар хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарахыг тус улсад зөвлөж байна.

Хүчирхийлэл үл хайхрах байдал

24. Архины хамааралтай эцэг эхийнхээ дарамтан дор хүүхдүүд гэртээ бие, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх зэргээр хүүхдүүд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөөр байгаад Хороо сэтгэл нэн зовинож буйгаа илэрхийлэн өмнөх зөвлөмжөө (see CRC/C/MNG/CO/3-4, para.47) дахин сануулж дараах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэхийг шаардаж байна.

а) Үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг нэн тэргүүнд шийдвэрлэж хүүхдүүдэд үр дүнтэй үйлчилгээ үзүүлж чадах мэргэшсэн чадварлаг нийгмийн ажилтнуудын тоог олноор нэмэгдүүлэх;

б) Хөвгүүдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах зэрэг хүчирхийллийн олон хэлбэрийн шалтгаан, мөн чанар, хамрах хүрээг тодорхойлох цогц судалгааг хийх;

в) Ирсэн гомдол мэдээлэлд хариу өгөх, мөрөөр нь ажиллах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй байлгахын тулд Хүүхдийн утас 108-ыг шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангахад анхаарах;

д) Эцэг эхчүүдэд сэтгэлзүйн болон хуулийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх.

Е. Гэр бүлийн орчин ба хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ (5, 9-11, 18 (1), (2), 20-21, 25 болон 27 (4) заалтууд)

Гэр бүлийн орчин

25. Хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх өндөр эрсдэлтэйгээс гадна боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх нь зөрчигдөж буй-сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, эцэг эх нь гадаад болон дотоодод шилжин суурьшсаны улмаас бусдын асрамжинд амьдардаг хүүхдүүд, дотуур байранд амьдардаг малчдын хүүхэд зэрэг эцэг эхийн хараа хяналтаас гадуур амьдарч буй хүүхдүүдийн тоо өндөр байгаад Хороо сэтгэл зовиносон хэвээр байна. Мөн гэрээсээ хол газарт, олон цагаар уул уурхайн салбарт ажилладагын улмаас хүүхдээ үл хайхралд оруулж буй эцэг эхчүүд болон өрх толгойлон амьдардаг хүүхдийн

тоо нэмэгдэж буйд Хороо туйлын харамсаж байна.

26. Тус улсад Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(а) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэтээр эцэг эхчүүд хүүхдээ асарч өсгөх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээгээ бэхжүүлэх;

(б) Дотуур байранд суудаг болон сүм хийдэд шавилан суудаг гэх мэт эцэг эхийнхээ хараа хяналтанд амьдарч чадахгүй байгаа хүүхдүүдтэй ажилладаг хүмүүст чиглэсэн хүүхдийн эрхийн сургалт, ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гомдол мэдээллээ өгөх үр дүнтэй арга хэрэгсэл, хүүхэд хамгааллын тогтолцоог хүртээмжтэй болгох замаар эдгээр хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах;

(с) Өрх толгойлсон хүүхдийн тоог бууруулах, ийм байдалд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нь дээшлүүлэх зэрэг тэдний хэрэгцээнд нийцсэн бодлого журам гаргахад шаардагдах мэдээллийг хүүхдэд учирч буй тухайлсан бэрхшээл асуудлуудаар нь задаргаа хийн цуглуулах.

Гэр бүлийн орчноос хөндийрсөн хүүхдүүд

27. Эцэг эхээ алдсан болон тэднээсээ тусдаа амьдрах болсон хүүхдүүдэд чиглэсэн зарим нэг арга хэмжээг тус улс авч хэрэгжүүлдэгийг Хорооны зүгээс тэмдэглэхийн зэрэгцээ асрамж халамжийн газарт амьдарч буй хүүхдийн тоонд сэтгэл зовиносон хэвээр байгаа учраас дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(а) Асралт гэр бүл, үрчлэлт зэрэг гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээг орон нутагт нь түшиглэн үзүүлж буй хүчин чармайлтаа улам бэхжүүлэх;

(б) Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим, хэрэгцээнд суурилан хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах шаардлагатай эсэхийг тогтооход чиглэсэн

шалгуур үзүүлэлт, хамгааллын арга хэрэгслээр хангахад анхаарах;

(с) Асрамж халамжийн газрын ажилтнуудын тоо, мэргэшсэн байдал, зэргийг багтаасан стандартыг гаргаж мөрдүүлэх, асрамж халамжийн газар болон бусад хувилбарт үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол хяналт үнэлгээнд хамруулж тэнд байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг тогтмол шалгаж байх;

(d) Ийм хяналт үнэлгээг хийхдээ Ерөнхий Ассамблейгаас гаргасан Хүүхдэд зориулсан асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний журмыг баримтлах (Ерөнхий Ассамблейн тогтоол 64/142, хавсралт).

Үрчлэлт

28. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулсныг үнэлэхийн зэрэгцээ үрчлэлтийн практикт хангалттай дэвшил гараагүйд Хороо харамсаж байгаа бөгөөд дараах арга хэмжээнүүдийг яаралтай авахыг шаардаж байна. Үүнд:

(a) Өмнөх зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх (CRC/C/MNG/CO/3-4, para.45);

(b) Үрчлэлтийн явцад хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим хамгийн чухлыг анхаарах, ялангуяа хүүхдийг үрчлүүлэх шаардлагатай эсхийг болон үрчилж авч байгаа эцэг эхийн талаар үнэлгээ хийхдээ энэ зарчмыг хатуу мөрдөх;

(c) Үрчлэлтэд хяналт тавих, үрчлэлтийн мөрөөр ажиллах гэх мэт үрчлэлтийн бүхий л явцад ил тод байдлыг хангах.

Г. Хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, нийгмийн халамжийн суурь үйлчилгээнүүд (6, 18 (3), 23, 24, 26, 27 (1)-(3) болон 33 зүйл)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

29. 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн гадуурхалд өртөж байгаа, тэдний амьдралын бүхий л

хүрээнд ялгаварлан гадуурхалт учирч буйд Хороо сэтгэл зовиносон хэвээрээ байна. Иймээс тус улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах цогц стратегийг хүний эрхэд суурилсан зарчимд тулгуурлан яаралтай баталж дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

(a) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Хорооноос 2015 оны 5 дугаар сард гаргасан зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх (CRPD/C/MNG/CO/1);

(b) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хувиарлахад анхаарах;

(c) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бодлого хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлийг оношлох үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах;

(d) Сурагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх цогц арга хэмжээнүүдийг авах, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, ангид сургахаас илүүтэйгээр тэгш хамруулах боловсролыг чухалчлах;

(e) Суралцах чадварын бэрхшээлтэй хүүхдүүдэд онцлон анхаарч тэд жирийн хүүхэдтэй хамт нэг ангид сурч байгаа үед тэдэнд ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх мэргэжлийн багш, ажилтныг сургаж томилох;

(f) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сэргээн засах хөтөлбөрт хамруулах зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг яаралтай авах;

(g) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жигшин гадуурхах, тэднээс ичиж зовох гэх мэт үйлдэлтэй тэмцэх, ийм хүүхдүүдийн эерэг дүр төрхийг нийгэмд бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчид, олон нийт, гэр бүлд чиглэсэн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлуудыг өрнүүлэх.

Эрүүл мэнд ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

30. Бүх хүүхдийг эрүүл мэндийн даатгалд үнэ төлбөргүй хамруулах гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх талаар тус улсын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг талархан тэмдэглэхийн зэрэгцээ хүүхдийн эрүүл мэндийн асуудалд бүс нутаг, нийгэм эдийн засгийн статусаас хамаарсан тэгш бус байдал байсаар байгаа, ялангуяа хөдөөгийн хүүхдүүд эрүүл мэндийн чанартай үйлчилгээ хүртэх боломж дутагдаж буйд Хороо сэтгэл зовиносон хэвээр байгаа тул 2013 онд гаргасан Эрүүл мэндийн хувьд хамгийн өндөр түвшинд хүрсэн үйлчилгээ авах хүүхдийн эрхийг хангах Ерөнхий зөвлөмж 15-ын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тус улсад зөвлөж байна. Үүнд:

(а) Бүх хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн арга хэмжээг нэн яаралтай авах, ялангуяа хөдөөгийн болон орлого багатай гэр бүлийн хүүхдүүдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг эрс сайжруулах;

(б) Үүрэг хүлээсэн байгууллага, хүмүүс албан бус нэмэлт төлбөр авах гэх мэтээр эрүүл мэндийн үйлчилгээний салбарт гарч буй хээл хахуультай тэмцэх тодорхой арга хэмжээ авах;

(с) Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэргээс санхүүгийн болон арга зүйн дэмжлэг хүсэх.

Хоол тэжээл

31. Хүүхдийн хоол тэжээлийн дутагдлыг бууруулах чиглэлээр гаргасан ололт амжилтыг үнэлэхийн зэрэгцээ Хороо өмнөх зөвлөмжөө дахин сануулж (CRC/C/MNG/CO/3-4, para.52) Тогтвортой хөгжлийн зорилтуудын хоол тэжээлийн дутагдлын бүх хэлбэрийг устгах 2.2 зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд:

(а) Таваас доош насны хүүхдүүдийг А болон Д витамин гэх мэт нэн чухал амин дэм, шим тэжээлээр хангахад анхаарах, ялангуяа

хөдөөгийн болон орлого багатай өрхийн хүүхдүүдэд тусгайлан анхаарах, түгээлтийн явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулах боломжийг бүрдүүлэх;

(б) Зөвхөн эхийн сүүгээр хооллохын ач тусыг эхчүүдэд сурталчилах гэх мэт үйл ажиллагааг дэмжсэн хангалттай хөрөнгө нөөц бүхий Хөхөөр хооллох үндэсний бодлого боловсруулж батлуулах, одоо мөрдөж буй Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулиа Олон улсын эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тавих ёсзүйн дүрэм болон ДЭМБ-аас гаргасан бусад тогтоол зөвлөмжтэй уялдуулан хэрэгжүүлэх, ажил эрхэлдэг эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх боломжийг бүрдүүлэх зэргээр зөвхөн эхийн сүүгээр хооллодог зургаан сар хүртэлх насны хүүхдийн тоог нэмэгдүүлэх;

(с) Хүүхдийн таргалалтыг бууруулахын тулд хүүхдэд эрүүл биш хүнс, ундааг тэдэнд үйлчилдэг байгууллагуудын ойролцоо байршилтай газруудад сурталчлахгүй байх хууль нэвтрүүлэх, сургуулийн үдийн хоол зэргээр үйлчлэхдээ эрүүл хүнс хэрэглэхийг дэмжсэн тодорхой арга хэмжээг батлах.

Өсвөр үеийнхний эрүүл мэнд

32. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлуудын мөн чанар, тархацыг ойлгохын тулд цогц судалгаа хийж тэдэнд зориулсан эрүүл мэндийн бодлого хөтөлбөр боловсруулах талаарх өмнөх зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.54) хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүйд Хороо харамсаж буйгаа илэрхийлээд энэ шаардлагыг хойшлуулгүй нэн даруй биелүүлэхийг Хороо зөвлөж байна. Мөн Хорооны 2016 онд гаргасан өсвөр насныхны хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Ерөнхий зөвлөмж 20 болон 2003 онд гаргасан Өсвөр үеийнхний эрүүл мэндийн тухай Ерөнхий зөвлөмж 4-т заасныг үндэслэн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн хөтөлбөрийг энэ насны хүүхдүүдийн оролцоотойгоор боловсруулж бие даасан хичээл болгон оруулах, тэдэнд тохирсон нөхөн

үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх талаар хүчин чармайлтаа бэхжүүлэхийг зөвлөж байна.

Сэтгэцийн эрүүл мэнд

33. Хүүхэд амиа хорлох талаар бодох, оролдох гэх мэт сэтгэцийн эрүүл мэндийн асуудал цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаад Хороо сэтгэл зовинож буй бөгөөд өмнөх зөвлөмжинд (CRC/C/MNG/CO/3-4, para.56) тусгасан санаануудыг багтаан нөхцөл байдал, үндэс шалтгааны дүгнэлтэнд суурилсан, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний түвшний цогц бодлого боловсруулахыг тус улсад зөвлөж байна. Хүүхдийн сэтгэл зүйгээр тусгайлан мэргэшсэн сэтгэлзүйчдийн тоог нэмэгдүүлэх, сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээнд мэргэшсэн сувилагч гэх мэт анхан шатны үйлчилгээг нэвтрүүлэхийг мөн зөвлөж байна.

Орчны эрүүл мэнд

34. Агаарын хэт бохирдлын талаар тус улсын хийсэн зарим ажлыг тэмдэглэхийн зэрэгцээ ургийн хөгжлийн хоцрогдол, дутуу төрөлт, амьсгалын замын хүнд хэлбэрийн өвчин болон хүндэрч байгаа уушгины үйл ажиллагааны дутагдал, насанд хүрсэн хойно нь илрэх амьсгалын замын архаг өвчин, Монголын 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хамгийн гол шалтгааны нэг болдог уушигний хатгалгаа зэрэг нь Улаанбаатар хот, ялангуяа гэр хороололын агаарын бохирдлын улам бүр нэмэгдэж буй түвшингийн шууд үр дагавар болж байгаад Хороо туйлын харамсаж байна. Мөн уул уурхайн үйл ажиллагаа, хурдацтай хотжилт зэрэг нь хүүхдийн ундны цэвэр усны хүртээмжийг багасгахад нөлөөлж байгаа хөрс усны бохирдлыг бий болгож байна.

35. Хороо өмнөх зөвлөмжөө давтан сануулахын зэрэгцээ (CRC/C/MNG/CO/3-4, para.18(c), para.51(c) and para.58) дараах арга хэмжээнүүдийг нэн яаралтай авахыг тус улсад шаардаж байна. Үүнд:

(a) Хамгийн наад зах нь HEPA буюу өндөр үр ашигтай агаарын шүүлтүүрийг төрөхийн өмнөх эмнэлгийн тусламжийн багцанд оруулах, өвлийн улиралд халаалтыг нүүрснээс өөр боломжийн үнэтэй өөр түлшээр шийдэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг агаарын бохирдлын хор нөлөөг багасгах арга хэмжээг нэн даруй батлах ;

(b) Хүүхдийг агаарын бохирдлын хор нөлөөнөөс хамгаалах, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг үндэсний бодлогын тэргүүлэх чиглэл гэдгийг зарлаж орчны бохирдлын хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөөг үр дүнтэй бууруулахын тулд санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хувиарлах;

(c) Орон нутгийн түвшинд ажиллаж байгаа албан хаагчдыг агаар, усны бохирдлыг хянах, зохицуулах мэдлэг, чадвар, арга зүйгээр хангахад анхаарах.

Цаг уурын өөрчлөлтийн хүүхдийн эрхэд нөлөөлж буй байдал

36. Тус улсын эмзэг экосистемд нөлөөлж байгаа цаг уурын өөрчлөлт, хүйтэн ширүүн өвөл нь малчин өрхүүд мал сүргээ олноор нь алдан гарз хохиролд ороход хүргэж буй нь хүүхдүүдэд нь шууд сөргөөр тусаж байгааг дурдахын хамт Тогтвортой хөгжлийн зорилтуудын 13.5-т байгаа цаг уурын өөрчлөлттэй холбоотой үр дүнтэй төлөвлөлт, удирдлагын чадварыг дээшлүүлэх механизмыг сайжруулах зорилтын хүрээнд цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицоход чиглэсэн хүүхдэд түшиглэсэн арга зүйг нэвтрүүлж, бодлого төлөвлөгөө гаргахдаа хүүхдийг оролцуулахыг зөвлөж байна.

Амьдралын чанар

37. Тус улсад ядуурал байсаар байгаа болохоор олон хүүхдийн амьдралын ерөнхий түвшин доогуур байгаад Хороо сэтгэл зовинож байгаа бөгөөд тус улсыг ядуурал болон алслагдмал газар, хөдөө нутаг, төв суурин газрын ядуусын хороололын хүүхдүүдэд

цэвэр усны хүртээмж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж дутагдалтай байгааг шийдвэрлэх хүчин чармайлтаа идэвхжүүлэхийг зөвлөж байна. Мөн дараах зөвлөмжийг Хорооноос өгч байна. Үүнд:

(a) Тогтвортой хөгжлийн зорилт 3-т дурдсан бүх нийтэд зориулсан үндэсний хэмжээний нийгмийн хамгааллын тогтолцоо, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтыг үндэслэн тэгш бус байдлын үндсэн шалтгааныг тогтоох судалгаа хийх, хамгийн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд хөрөнгө нөөцийг шууд чиглүүлсэн татварын шинэлэг, үр дүнтэй түгээлтийн бодлого хэрэгжүүлэх;

(b) Эдийн засаг, нийгэм, соёлын Хорооны (E/C.12/MNG/CO/4, para.22) болон Хүний эрх, нэн ядуу байдлын талаар ажилладаг тусгай төлөөлөгчийн (A/HRC/23/36/Add.2) зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх.

Н.Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ (28, 29, 30 болон 31 зүйл)

Боловсрол

38. Өмнө өгсөн зарим зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.60) хэрэгжүүлэхийн төлөө гаргасан тус улсын чармайлтыг онцлохын зэрэгцээ Засгийн газрын хэрэгжүүлж буй боловсролын бодлого уялдаа холбоогүй, тууштай биш байсан нь нэн даруй шийдэх ёстой маш чухал асуудлуудын явцыг удаашруулж байгаад Хороо сэтгэл зовинож байгаа учраас Боловсролын зорилгын тухай 2001 оны Ерөнхий зөвлөмж 1-ийг үндэслэн дараах зөвлөмжүүдийг заавал хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

(a) Бүх түвшинд, бүх хүүхдэд боловсролын хүртээмж тэгш байхыг баталгаажуулах хүчин чармайлтаа бэхжүүлэх, ялангуяа Казах хүүхдүүд гэх мэт үндэстний болон хэлний цөөнх хүүхдүүд, бага орлоготой өрхийн хүүхдүүд, малчин өрхийн хүүхдүүд, алслагдсан хөдөө нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөвгүүд, ялангуяа сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдэд илүү анхаарал хандуулах;

(b) Жирэмсэн охидууд болон өсвөр насны эхчүүд боловсролоо ердийн сургуульд үргэлжлүүлэхэд нь дэмжин туслах;

(c) Магадлан итгэмжлэгдсэн цахим хичээл, хөтөлбөр, явуулын сургуульд малчдын хүүхдүүдийг хамруулах зэргээр дотуур байранд суулгүйгээр суурь боловсрол эзэмшиж болох хувилбарыг олж хэрэгжүүлэх;

(d) Суурь болон дунд боловсролын хүртээмж, тасралтгүй үргэлжлүүлэн сурах боломжийг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг авах, цэвэр ус, ариун цэврийн байгууламж гэх мэт дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүн, сургуульдаа ирэх буцах унаа, чанартай багшийн хүрэлцээ зэрэгт анхаарах;

(e) Хүмүүжлийн эерэг, хүчирхийллийн биш аргыг сургалтандаа ашигладаг болгохын тулд багш нарыг сургах гэх мэтээр хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалах механизмыг бүрдүүлэн бүх түвшний сургуульд сурч буй хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг бэхжүүлэх;

(f) Бага насны хүүхдийн хөгжил, асаргааны цогц, нэгдсэн бодлогод суурилан сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх, хүртээмжийг нь нэмэгдүүлэхийн тулд хангалттай төсөв санхүү хувиарлах.

Амралт, чөлөөт цаг, зугаа цэнгэл, соёл, урлагийн арга хэмжээ

39. Сургууль дээр хичээлээс гадуур арга хэмжээг зохион байгуулах талаар бодлогын баримт бичиг батлах зэргээр хүүхдийн чөлөөт цагийн арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажилласанд талархахын зэрэгцээ хүүхдийн насанд тохирсон соёл, урлаг, амралт, чөлөөт цагийн арга хэмжээг явуулах газар, боломжууд дутагдаж буйд Хороо сэтгэл зовиносон хэвээр байна. Иймээс өмнөх зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.62) хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг хангалттай хувиарлахыг тус улсад сануулж байна.

I. Тусгай хамгааллын арга хэмжээнүүд (22, 30, 32-33, 35-36, 37 (b)-(d), 38, 39 болон 40-р зүйлүүд)

Хүүхдийн хөдөлмөр, унаач хүүхэд зэрэг эдийн засгийн мөлжлөг

40. 2016 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр гаргасан. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх чиглэлийн арга хэмжээг тус улс авсанд Хороо талархахын зэрэгцээ хүүхдүүд хөдөө аж ахуй, уул уурхай, морин уралдаан зэрэг аюултай, хортой нөхцөлд хөдөлмөр эрхэлсээр байгаад сэтгэл маш их зовинож байна. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс тавдугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд уралдаан, сунгаа, үсэргээнд 16-аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2016 оны хоёрдугаар сарын 8-ны өдрийн А/36 тушаалаар хориглосон байсныг Хөдөлмөр нийгмийн хамгаалын сайд 2017 онд хүчингүй болгосон, мөн морины эзэд, уяачдын зүгээс учруулсан бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, сургууль завсардах, гэмтэж бэртэх, амь насаа алдах эрсдэлд унаач хүүхдүүд өртсөөр байгаад Хороо маш их харамсаж байна.

41. Хороо өмнө өгсөн зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.65) дахин сануулж дараах арга хэмжээг яаралтай авахыг тус улсад шаардаж байна. Үүнд:

(a) 2012-2016 онд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн санхүү төсөв, менежмент хангалтгүй байсны улмаас уг хөтөлбөр сайн хэрэгжээгүйд дүгнэлт хийж Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үйл ажиллагааны цогц төлөвлөгөө, бодлогыг хангалттай төсөв санхүү, арга зүй, хүний нөөцтэйгээр батлах;

(b) 15-аас доош насны хүүхэд хөдөлмөр эрхлэхгүй байхад анхаарч шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн тухай хуулийг батлах;

(c) Жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс тавдугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд

16-аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон шийдвэрийг 18 наснаас доош хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох үйл явцын эхний алхам гэж үзэн хэрэгжилтийг нь сахиулахад хатуу анхаарах

(d) Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ноогдуулах;

(e) Хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхлэж буй төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах.

Гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдүүд

42. Гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг бүртгэлжүүлж хамгаалах чиглэлээр Засгийн газрын 2016–2020 оны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын “Хараа хяналтгүй хүүхдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/847 захирамж гаргасан, Хараа хяналтгүй хүүхэд зориулсан хөгжлийн төв байгуулах төлөвлөгөө баталсан зэрэг ажлыг Хороо үнэлэхийн зэрэгцээ хүүхэд гудамжинд амьдарч байгаагийн үндэс шалтгааны талаар мэдээлэл, найдвартай зөв статистикийн тоо баримт байхгүй байгаа талаар өмнөх зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.67) дахин сануулж байна. Мөн Гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн талаарх Хорооноос 2017 онд гаргасан Ерөнхий зөвлөмж 21-ийг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авахыг тус улсад шаардаж байна:

(a) Хот хөдөөд гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн талаарх нарийн задаргаатай мэдээлэл цуглуулах;

(b) Хүүхдийг гудамжинд гаргахад хүргэж байгаа үндэс шалтгааныг илүү ойлгохын тулд нөхцөл байдлын үнэлгээ хийх, судалгааны дүн мэдээг олон нийтэд танилцуулах;

(c) Гудамжны нөхцөлд байгаа бүх хүүхдийг эргэн нэгтгэх, нөхөн сэргээх, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хоорондоо уялдаа холбоотой, тогтвортой арга хэмжээнүүдийг боловсруулахын тулд Үндэсний хэмжээний бодлого, зохицуулах хүрээг тодорхойлж хангалттай төсөв хөрөнгө хувиарлах;

(d) Гудамжны нөхцөлд байгаа хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын наад захын стандартыг хүртэх эрхийг хангахын тулд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоо тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлдэг байхад чиглэсэн бүх арга хэмжээг авах;

(e) Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчимд нийцэж байвал хүүхдүүдийг аль болохоор гэр бүлд нь эргэн нэгтгэх.

Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шийдвэрлэх

43. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (A/HRC/30/6, para.108.162 and A/HRC/30/6/Add.1) тайландаа насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шийдвэрлэх, олон улсын стандартад нийцсэн цогц бодлогын хүрээг бүрдүүлнэ гэж тус улс амласныг сануулахын ялдамд энэ амлалтаа нэн даруй биелүүлэхийг Хороо тус улсад шаардаж байна. Мөн өмнөх дүгнэлт зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.76), мөн түүнчлэн, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн Хорооноос 2016 онд өгсөн зөвлөмжийг (CAT/C/MNG/CO/2, para.24) биелүүлэхийг зөвлөж байна. Тухайлбал, дараах арга хэмжээг нэн даруй авахыг тус улсад Хорооноос шаардаж байна. Үүнд:

(a) Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчмууд, зүйл заалтуудын талаар зохих сургалтанд хамрагдсан хүүхдийн мэргэжсэн шүүгчдийг тусгайлан томилдог байх;

(b) Төлбөрийн чадваргүй хүүхдүүдэд үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгөх гэх мэт хууль зөрчсөн хүүхдэд хууль зүйн мэргэжлийн, бие даасан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарах;

(c) Эрүүгийн хууль зөрчсөн гэж сэжиглэгдэж байгаа хүүхдийг батлан даалтанд өгөх, тэнсэх, эвлэрүүлэн зуучлах, зөвлөгөө өгөх, нийтэд тустай ажил хийлгэх гэх мэтээр шүүхээр оруулахгүйгээр хэргийг нь шийдвэрлэдэг арга барилыг (diversion) бэхжүүлэх, хэрвээ ял шийтгэл оногдуулах бол аль болохоор хорихоос өөр хувилбарыг ашиглах, хорих ялыг хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон, байж болох хамгийн бага хугацаагаар хорих гэсэн хувилбараар ашиглах, ийм ял өгсөн бол ялыг цуцлах боломжтой юу гэсэн үндэслэлээр хэргийг тогтмол магадлангаар оруулж байх;

(d) Хорих ялыг оноохоос өөр аргагүй үед хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт хорихгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй байх гэх мэт олон улсын стандартад хорих газрын нөхцөл байдал нийцсэн байхад анхаарах.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар Хорооны өмнөх зөвлөмжийн мөрөөр хэрхэн ажилласанд өгөх дүгнэлт, зөвлөмжүүд

44. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар тус улсын анхны тайланд Хорооноос 2010 оны 3-р сарын 3-ны өдөр өгсөн дүгнэлт зөвлөмжийн (CRC/C/OPSC/MNG/CO/1) хэрэгжилтийн талаар хангалтгүй мэдээлэл өгсөнд харамсаж байгаагаа илэрхийлээд тэрхүү зөвлөмжийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг зөвлөж байна. Тухайлбал, (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.7), Нэмэлт протоколын 2 болон 3-р зүйлд нийцүүлэн хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх,

хүүхдийг садар самуунд сурталчлахыг гэмт хэрэг гэж тодорхойлон хуульчлах, мэдээлэл цуглуулах (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.9), хохирогчдыг нөхөн сэргээх, эргэн нэгтгэх (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.31) арга хэмжээг яаралтай хэрэгжүүлнэ үү. Мөн дараах зөвлөмжийг тус улсад нэмж өгч байна. Үүнд:

(a) Хүүхдийн секс аялал жуулчлалыг устгах, үүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтын үр дүнтэй хүрээг тогтоож, хууль, захиргаа, нийгэм болон бусад бүх шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх;

(b) Цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэтээр интернет орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх.

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцид оруулах нэмэлт протоколын тайланд өгсөн өмнөх зөвлөмж дүгнэлтийн мөрөөр хийсэн ажилд өгөх дүгнэлт зөвлөмж

45. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцид оруулах нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар ирүүлсэн тус улсын анхны тайланд Хорооноос 2010 оны 3-р сарын 3-ны өдөр өгсөн дүгнэлт зөвлөмжийн (CRC/C/OPAC/MNG/CO/1) хэрэгжилтийн талаар маш хангалтгүй мэдээлэл өгсөнд харамсаж байгаагаа илэрхийлээд тэрхүү зөвлөмжийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг зөвлөж байна. Тухайлбал, цэргийн сургууль (CRC/C/OPAC/MNG/CO/1, para.11), эрүүгийн хууль тогтоомж (CRC/C/OPAC/MNG/CO/1, para.14) гэх мэт асуудлаар тодорхой арга хэмжээ авна уу. Мөн нэмэлт протоколын 4-р заалтыг үндэслэн төрийн зэвсэгт хүчнээс ангид цэрэгжсэн бүлэглэлүүдийн зохион байгуулж буй байлдааны ажиллагаанд 18 нас хүрээгүй хүүхдийг оролцуулахыг гэмт хэрэг гэж хуульчилахыг зөвлөж байна.

Ж. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг соёрхон баталсан байдал

46. Хүүхдийн эрхийг бүрэн дүүрэн хангахын тулд тус улс нь Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийг хамгаалах олон улсын конвенцийг соёрхон батлахыг Хороо зөвлөж байна.

IV. Хэрэгжилт ба тайлагналт

А. Зөвлөмжийг түгээх, түүний мөрөөр ажиллах

47. Энэхүү зөвлөмж дүгнэлтэнд багтаасан зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг тус улсад Хороо зөвлөж байна. Мөн Тавдугаар тайлан, түүний мөрөөр Хорооноос асуусан асуултанд бичгээр өгсөн хариулт болон энэхүү Зөвлөмж дүгнэлтийг тус улсад хэрэглэгддэг бүх хэл дээр гаргаж өргөнөөр түгээхийг зөвлөж байна.

В. Тайлагнах, зөвлөмжийн мөрөөр ажиллах үндэсний механизм

48. Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажилладаг, хүний эрхийн гэрээ конвенцуудын биелэлтийн талаар тэдгээр байгууллагуудын өгсөн шийдвэр, зөвлөмж дүгнэлтийн мөрөөр ажилладаг, үндэсний хэмжээний хэрэгжилтийг нь бүртгэж баримтжуулж байдаг, тэдгээрт явуулах тайлангуудыг бэлтгэх, зохицуулах ажлыг хариуцах үүрэг чиглэл бүхий Тайлагнах, зөвлөмжийн мөрөөр ажиллах үндэсний механизмыг Засгийн газрын байнгын бүтэц хэлбэрээр бий болгохыг Хороо зөвлөж байна. Энэ бүтэц нь яг энэ ажил үүргийг хариуцсан ажилтныг тогтмол ажиллуулах төсөв нөөцтэй, Хүний эрхийн Үндэсний Комисс болон иргэний нийгмийн байгууллагуудтай байнга зөвлөлдөх чадвартай байх ёстойг онцолж байна.

С. Дараагийн тайлан


49. Тус улсыг 6 болон 7-р дугаар тайлангаа нэгтгэн бичиж 2022 оны 9 сарын 1 гэхэд ирүүлэхийг Хороо урьж байна. Нэгдсэн тайланд энэхүү зөвлөмж дүгнэлтээр өгсөн

зөвлөмжүүдийн мөрөөр хэрхэн ажилласан талаар мэдээллээ багтаасан байна. Тайланг бичихдээ Хорооноос 2014 оны 1 сарын 31-ний өдөр гаргасан тусгайлсан гэрээ конвенцийн тайлан бичих журмыг (CRC/C/58/Rev.3) баримтлан 21,200 үгээс (General Assembly resolution 68/268, para. 16) хэтрүүлэхгүй бичнэ. Хэрвээ ирүүлсэн тайлан нь тогтоосон үгийн тооноос давсан байвал дээр дурдсан тогтоолын дагуу тайлангаа товчлон бичихийг хүсэх болно. Хэрвээ тухайн улс тайлангаа

дахин хянаад буцааж ирүүлэхгүй бол тайланг хэлэлцэхгүй болно.

50. Мэдээлэл нь хуучраад байгаа үндсэн баримт бичгээ 42,400 үгэнд багтаан шинэчлэн ирүүлэхийг мөн Хороо тус улсад уриалж байна. Хүний эрхийн гэрээ, конвенцийн тусгайлсан тайлан болон үндсэн баримт бичгийг холбогдох журамд заасан шаардлагуудын (HRI/GEN/2/Rev.6, chap. I) and paragraph 16 of General Assembly resolution 68/268) дагуу тайлангуудыг бичиж ирүүлнэ үү.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UHN.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, Ү давхар
Утас: 266506, 262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.mn-nhrc.org, Цахим шуудан: info@mn-nhrc.org
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 70000222
Хүний эрхийн цахим номын сан: <http://mn-nhrc.org/library/>

